

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
06 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1 – 2
Хуралдааны товч тэмдэглэл:	3 – 39
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	40 – 152
1. Хуулийн төслүүдийг эцэслэн батлах	43 – 45
2. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	45 – 48
3. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	48 – 49
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	49 – 50
5. Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	50 – 57
6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/	57 – 60
7. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, үргэлжлэл	60 – 61
8. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	61 – 67
9. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	67 – 75
10. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	75 – 87
11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	87 – 92

12.	<i>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/</i>	92 – 115
13.	<i>Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, <u>үргэлжлэл</u>/</i>	116 – 119
14.	<i>Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	119 – 120
15.	<i>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн /анхны хэлэлцүүлэг, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	121 – 123
16.	<i>Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	123 – 125
17.	<i>Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	125 – 127
18.	<i>Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /анхны хэлэлцүүлэг, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	127 – 132
19.	<i>Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /хэлэлцэх эсэх, санал хураалт, <u>үргэлжлэл</u>/</i>	132 – 134
20.	<i>Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	134 – 137
21.	<i>Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	137 – 138
22.	<i>Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай</i>	138 – 141
23.	<i>Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх/</i>	141 – 143
24.	<i>Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, <u>үргэлжлэл</u>/</i>	143 – 151
25.	<i>Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсоно</i>	151 – 152

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
06 дугаар сарын 12-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.¹

Томилолттой: Д.Амарбаясгалан, Б.Батцэцэг, Г.Ганбаатар, Ц.Идэрбат, Ц.Мөнхбат, Н.Номтойбаяр, Р.Сэддорж;

Чөлөөтэй: Х.Баттулга, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Баясгалан, Ц.Даваасүрэн, Б.Жаргалан, Ч.Лодойсамбуу, Ц.Мөнхтуяа, Б.Найдалаа, Ч.Номин, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Н.Батсүмбэрэл, Б.Баярбаатар, Ж.Ганбаатар, П.Сайнзориг, Б.Тулга, Б.Түвшин;

Хоцорсон: Ж.Алдаржавхлан–01 минут, С.Амарсайхан–3 цаг 45 минут, О.Амгаланбаатар–04 минут, Т.Аубакир–28 минут, Х.Баасанжаргал–02 минут, Х.Болормаа–01 минут, Э.Болормаа–4 цаг 34 минут, Х.Булгантуяа–16 минут, С.Ганбаатар–16 минут, Д.Ганбат–18 минут, Л.Гантөмөр–4 цаг 29 минут, Т.Доржханд–1 цаг 15 минут, Б.Дэлгэрсайхан–4 цаг 05 минут, Д.Жаргалсайхан–12 минут, Б.Заяабал–05 минут, Г.Лувсанжамц–15 минут, М.Мандхай–01 минут, З.Мэндсайхан–03 минут, М.Нарантуяа-Нара–04 минут, С.Одонтуяа–18 минут, Л.Соронзонболд–57 минут, Г.Тэмүүлэн–14 минут, А.Ундраа–17 минут, Ч.Ундрэм–54 минут, Д.Цогтбаатар–2 цаг 53 минут, Ж.Чинбүрэн–10 минут, Б.Чойжилсүрэн–03 минут, Ө.Шижир–3 цаг 55 минут, Ж.Энхбаяр–1 цаг 09 минут, Р.Эрдэнэбүрэн–53 минут.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлсэн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар явуулах үед Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлэг ажлын 5 өдрийн завсарлага авсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудлаас хассан талаар танилцуулав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн С.Амарсайханд Улсын Их Хурлын

¹ Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 3 гишүүн ирцэд нэмэгдсэн болно.

гишүүний нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, Б.Баярсайхан нар байлцав.

С.Бямбацогт: Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 72
Татгалзсан: 9
Бүгд: 81

88.9 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

С.Бямбацогт: Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71
Татгалзсан: 10
Бүгд: 81

87.7 хувь буюу нийт гишүүний олонхын саналаар хууль батлагдлаа.

С.Бямбацогт: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 8
Бүгд: 81

92.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын

хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат нар байлцав.

С.Бямбацогт: 1.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 18
Бүгд: 86
79.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 25
Бүгд: 86
70.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 23
Бүгд: 86
73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 26
Бүгд: 86
69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 23
Бүгд: 86

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 23

Бүгд: 86

73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 39

Бүгд: 86

54.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 29

Бүгд: 86

66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9. Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 28

Бүгд: 86

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 38

Бүгд: 86

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 35
Бүгд: 86
59.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 29
Бүгд: 86
66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн 2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

С.Бямбацогт: Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 26
Бүгд: 86
69.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, А.Ундраа, У.Отгонбаяр, Б.Хэрлэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 74.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан, **анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

С.Бямбацогт: Байнгын хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 22
Бүгд: 87

74.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Ж.Баярмаа, С.Замира, Б.Пунсалмаа нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 79.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл**/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Энхгэрэл, Ц.Рэнцэнтогтох, Б.Бадралт нар байлцав.

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, П.Батчимэг, Г.Ганбаатар, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3.1.14 дэх заалт болгож, 3.1.16 дахь заалтыг, мөн зүйлийн 2 дахь заалтыг тус тус хасах:

“3.1.14.“хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан, жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 28

Бүгд: 87

67.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, А.Ганбаатар нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 4.2.1 дэх заалтын “хүртээмжийн” гэснийг “хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн” гэж, 4.2.2 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, 4.2.4 дэх заалтын “салбарын” гэснийг “аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 4.3, 4.4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65

Татгалзсан: 22

Бүгд: 87

74.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4.3 дахь хэсэг нэмэх:

“4.3.Энэ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан хүнсний аюулгүй байдлын бодлогыг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, мэдээлэл болон эрсдэлийн удирдлага, хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 20

Бүгд: 87

77.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 4² дугаар зүйлийн 4^{2.1} дэх хэсгийн “мэргэшүүлэх, хөгжүүлэхэд,” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, “хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн” гэж өөрчилж, “нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний” гэснийг, 4^{2.2} дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг тус тус хасаж, 4^{2.3}, 4^{2.4}, 4^{2.5}, 4^{2.7}, 4^{2.8}, 4^{2.9} дэх хэсгийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4² дугаар зүйлийн дугаарыг 13² гэж өөрчлөх:

“4^{2.3}.Хүнсний салбарын мэргэшлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4^{2.4}.Энэ хуулийн 4^{2.3}-т заасан журамд мэргэжлийн зэргийн төрөл, хэлбэр, хугацаа, мэргэшүүлэх чиглэл, тавих шаардлага, сургалтын багц цаг болон зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

4^{2.5}.Энэ хуулийн 4^{2.4}-т заасан мэргэшлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд мэргэжилтэн уг шийдвэрийн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	21
Бүгд:	87

75.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 5.6 дахь хэсгийн “хүртээмжтэй байлгана” гэснийг “хүртээмжтэй байлгах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, 5.5 дахь хэсгийг, 5.8 дахь заалтын “тусгайлсан” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	64
Татгалзсан:	23
Бүгд:	87

73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	66
Татгалзсан:	21
Бүгд:	87

75.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 18

Бүгд: 87

79.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4.3 дахь заалт болгох:

“10.4.3.хүнсний экспорт, импорт, шошгололт, хадгалалт, хүргэлт, цахим болон бусад худалдаанд.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 19

Бүгд: 87

78.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 13.1.6 дахь заалтын “баталгаат” гэснийг “бүтээгдэхүүний аюулгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 23

Бүгд: 87

73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 13² дугаар зүйлийн 13².3.8 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, “олон нийтэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх” гэснийг “олон нийтийг соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгааны” гэж өөрчилж, 13².3.9 дэх заалтын “таван жил” гэсний өмнө “гурваас” гэж нэмж, 13².3.6 дахь заалтын “өндөр хөгжилтэй орны” гэснийг, 13².3.7 дахь заалтын “мэргэжилтэн болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн” гэснийг, 13².3.10 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 18

Бүгд: 87

79.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17¹ дүгээр зүйл.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан

17¹.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

17¹.2.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

17¹.2.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл;

17¹.2.2.гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл;

17¹.2.3.баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүртгэл;

17¹.2.4.хяналт шалгалтын тайлан;

17¹.2.5.импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл;

17¹.2.6.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

17¹.2.7.хүнсний сорилтын лабораторийн шинжилгээний дүн;

17¹.2.8.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17¹.3.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 27.9-д заасны дагуу зохицуулна.

17¹.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл ашиглах, цуглуулах, хэлбэр, хугацаа, мэдээллийн ил тод байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68

Татгалзсан: 19

Бүгд: 87

78.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 6 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 26
Бүгд: 87

70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж,” гэснийг, “, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлсан” гэж” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 22
Бүгд: 87

74.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.7} дахь хэсгийн “дүгнэлтийг үндэслэн” гэснийг “санал, зөвлөмжийг харгалзан” гэж өөрчилж, 5^{1.6} дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 20
Бүгд: 87

77.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1, 2, 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнсийг” гэж, “4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” ГЭСНИЙГ “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч хүнсний бүтээгдэхүүнд” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 25
Бүгд: 87
71.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1, 2, 13, 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 23
Бүгд: 87
73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.1,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 24
Бүгд: 87
72.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 26
Бүгд: 87
70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.4 дэх дэд заалтын “хүнсний баталгаат байдал” гэснийг “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 26
Бүгд: 87

70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Дээрх 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 28
Бүгд: 87

67.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Хоёр.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “, 6.15 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж, 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 27
Бүгд: 87

69.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн 2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ч.Батбямба, Ц.Баянмөнх, Ц.Болормаа, референт Б.Баясах, О.Мөнгөнчавхдас, А.Амармэнд нар байлцав.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 49

Татгалзсан: 38

Бүгд: 87

56.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 39

Бүгд: 87

55.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 44

Татгалзсан: 43

Бүгд: 87

50.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 36

Бүгд: 87

58.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 44
Бүгд: 87
49.4 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 45
Бүгд: 87
48.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Р.Эрдэнэбүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэг, Р.Эрдэнэбүрэн нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 44
Бүгд: 89
50.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 45
Татгалзсан: 44
Бүгд: 89
50.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 37

Бүгд: 89

58.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 36

Бүгд: 89

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Биеийн тамир, спортын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 35

Бүгд: 90

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Долоо. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат нар байлцав.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63

Татгалзсан: 27

Бүгд: 90

70.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ц.Баатархүү, О.Саранчулуун нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 14.00 цаг хүртэл хойшлуулав. /11:17/

Ес.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны

ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, О.Саранчулуун нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 14.00 цаг хүртэл хойшлуулав. /11:35/

Арав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд З.Мэндсайхан, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 11 цаг 37 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн сайд З.Мэндсайхан, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 14.00 цаг хүртэл хойшлуулав. /11:59/

Арван нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 14.00 цаг хүртэл хойшлуулав. /12:14/

Арван хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын

асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, С.Цэнгүүн, Б.Уянга, О.Саранчулуун, Х.Баасанжаргал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Баярмаа, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 14.00 цаг хүртэл хойшлуулав. /13:06/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 06 минут үргэлжилж, 13 цаг 07 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 03 минутад эхлэв.

Арван гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн 2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 17.00 цаг хүртэл хойшлуулав. /14:14/

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид “ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.1.51 дэх заалтын “гааль, татварын албаны” гэснийг “гаалийн мэдээллийн сан, татварын” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 18.1.13, 18.1.14 дэх заалтын “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан,” гэснийг “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцийг хэрэгжүүлэхэд ашиглах” гэж, мөн зүйлийн 6 дахь заалтын 76¹.3 дахь хэсгийн “тогтоож, татвар төлөгчид мэдээлнэ.” гэснийг “тогтооно.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	38
Бүгд	94

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “70” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	56
Татгалзсан:	38
Бүгд	94

59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

НАЙРУУЛГЫН САНАЛ:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “, тайлбар” гэж нэмж, 6 дахь заалтын 76¹.1 дэх хэсгийн “Гааль” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “асуудлыг агуулсан” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд 94

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Жаргалан нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “50” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд 94

62.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь заалтын “Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютер” гэснийг “Сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмж, график болон тусгай зориулалтын процессор бүхий тооцоолон бодох төхөөрөмж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд 94

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.23 дахь заалтын “виртуал бүсэд бүртгүүлсэн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд 94
63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 38
Бүгд 94
59.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15 хувиар,” гэснийг, мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд 94
62.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “22 дугаар зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж, “6 тэрбум” гэснийг “10 тэрбум” гэж, “600 сая” гэснийг “1 тэрбум” гэж, “6 тэрбумаас” гэснийг “10 тэрбумаас” гэж,” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд 94
62.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “22.5.4 дэх” гэсний өмнө “22.1 дэх хэсгийн “20.2.7” гэснийг,” гэж нэмэх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 39
Бүгд 94
58.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16^{1.5} дахь хэсгийн тайлбарын “Барааг” гэснийг “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан барааг” гэж өөрчилж, мөн зүйлийн 16^{1.11} дэх хэсгийн “бол тухайн албан татварын” гэсний өмнө “шийдвэр гарсан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 34
Бүгд 94
63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “400” гэснийг “1 тэрбум” гэж, “2.5” гэснийг “1” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 35
Бүгд 94
62.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ:**

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.10 дахь хэсгийн “100 мянган америк доллароос” гэснийг “360 000 000 төгрөгөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	60
Татгалзсан:	34
Бүгд	94

63.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

С.Бямбацогт: 1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “олимпын төрлийн спортын холбоо,” гэснийг “олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо,” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	58
Татгалзсан:	36
Бүгд	94

61.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Саналын томъёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 32

Бүгд 94

66.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

**ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН НЭГТГЭСЭН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ:**

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Жавхлан, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан аялал жуулчлалын бус орон сууцаа борлуулж олсон орлого” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 35

Бүгд 94

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар албан татвар ногдуулна:

21.1.1.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 11 049 600 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 20 049 600 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар;

21.1.2.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-24 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 1 хувиар, 24 000 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 144 960 төгрөг дээр 24 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 744 960 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 18 744 960 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар.

21.2.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 33

Бүгд 95

65.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 21.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 36

Бүгд 95

62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж,” гэснийг, мөн зүйлийн “26.1.1,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж” гэснийг “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60

Татгалзсан: 35

Бүгд 95

63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.14 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 33

Бүгд 95

65.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 33

Бүгд 95

65.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 40
Бүгд 95
57.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 42
Бүгд 95
55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн ““15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж,” гэснийг “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 43
Бүгд 95
54.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасан тухайн жилийн орлогод 5 хувиар тооцон албан татвар ногдуулна.

21.1.1.Татвар төлөгчийн асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тооноос хамааран дараах хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

21.1.1.а.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо нэг бол 4 хувь;

21.1.1.б.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо хоёр бол 3 хувь;

21.1.1.в.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо гурав бол 2 хувь;

21.1.1.г.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо дөрөв бол 1 хувь.

21.2.Асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүнд арван найман нас хүрээгүй хүүхэд, өдрийн ангид суралцаж байгаа хорин дөрвөн нас хүртэлх хүүхэд, тэжээн тэтгэж буй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийг хамруулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52

Татгалзсан: 43

Бүгд 95

54.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогод доор дурдсан хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

21.1.1.2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 5 хувиар;

21.1.2.2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1 хувиар.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 42

Бүгд 95

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.14 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсгийн “23.1-д зааснаас бусад” гэснийг”, 5 дугаар зүйлийн “23 дугаар зүйлийн 23.1, 23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг, 28 дугаар зүйлийн 28.1.2-ыг” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 42

Бүгд: 95

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, зөвлөх Л.Батмөнх, референт Б.Ууганцэцэг, М.Мандхай, Т.Билэг-Өрнөх, Б.Галсанбат нар байлцав.

С.Бямбацогт: Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 61

Татгалзсан: 34

Бүгд: 95

64.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 37

Бүгд: 95

61.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 53

Татгалзсан: 42

Бүгд: 95

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 36

Бүгд: 95

62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 45

Бүгд: 95

52.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Э.Гансүх, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх Г.Энхболд, Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн шинжээч С.Билигтборзаяа, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга С.Ганбямба, Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч Б.Мөнх-Ирээдүй, Зэвсэгт хүчний Жанжин штабын Хуулийн хэлтсийн дарга Б.Мөнхбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны зөвлөх М.Отгон, С.Дунжидмаа, референт А.Наранцэцэг, Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т заасны дагуу санал хураалтыг 17.00 цаг хүртэл хойшлуулав. /15:21/

Арван тав.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн 2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Энхгэрэл, Ц.Рэнцэнтогтох, Б.Бадралт нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Хэлэлцүүлгийг түр хойшлуулав. /15:24/

Арван зургаа.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналын тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Л.Хурцбилэг, Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

С.Бямбацогт: Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65
Татгалзсан: 33
Бүгд: 98
66.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 15 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх А.Болортуяа, Г.Анар-Эрдэнэ, Б.Мажигсүрэн, референт Н.Монголмаа, Б.Цогзолбаяр, Б.Энхмаа, Ц.Долгормаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүний олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

С.Бямбацогт: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 46
Бүгд: 98
53.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, П.Хулан, референт Б.Энхгэрэл, Ц.Рэнцэнтогтох, Б.Бадралт нар байлцав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Рэгдэл нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Бейсен, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг үг хэлэв.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Арван найм.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаас 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.5-д заасны дагуу хойшлуулав.

Арван ес.Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулиудын эцсийн найруулгатай танилцлаа. /16:02/

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /16:02/

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 19 асуудал хэлэлцэв.

Бусад. Нийслэлийн ерөнхий боловсролын 42 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаярын урилгаар Дорнод аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид, Баянхонгор аймгийн Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981, 1996 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1990 оны төгсөгчид, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1992 оны төгсөгчид, Завхан аймгийн Дөрвөлжин сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 11, 13 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1996 оны төгсөгчид, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 1976 оны төгсөгчид болон Отгонтэнгэр Их сургуулийн 2006 оны төгсөгчид, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр болон Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Хан Монгол” сургуулийн 12^а ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 1991 оны төгсөгчид, мөн Сүхбаатар аймгийн Дарьганга сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид, Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн урилгаар Дарханы Политехникумын цахилгааны техникчийн ангийн 1988 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1991 оны төгсөгчид болон Говь-Алтай аймгийн Тайшир сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 9^б ангийн багш, сурагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 1988 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын урилгаар Төв аймгийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1986 оны төгсөгчид, Үндэсний батлан хамгаалах их сургуулийн харьяа ерөнхий боловсролын “Тэмүүжин-Өрлөг” сургуулийн 12^б ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Батлан хамгаалах яамны харьяа Монгол Улсын зэвсэгт хүчний агаарын цэргийн командлалын алба хаагчид, Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн н.Сувд-Эрдэнэ багштай 7^в ангийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 9³ дугаар ангийн багш, сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн ерөнхий

боловсролын 3 дугаар сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 06 минут үргэлжилж, ирвэл зохих 126 гишүүнээс 100 гишүүн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 06 дугаар сарын 12-ны өдөр, Баасан гараг
Төрийн ордон “ИХ ХУРАЛДАЙ” танхим
10 цаг 01 минут

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлынхаа эрхэм гишүүдийн өглөөний амгаланг айлтгая.

2026 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаан ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн буюу 53.2 хувийн ирцтэй ирц бүрдсэн байна.

Чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье. /алх цохив/

Гишүүддээ мэдээлэл хүргэе.

Долоо хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах ёстой байсан.

6 дугаар сарын 10-ны өдрийн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны явцад Улсын Их Хурал Ардын намын бүлэг 5 өдрийн завсарлага авсан тул нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудлаас хасагдсан.

Төрсөн өдөр нь тохиож буй гишүүдийн мэндчилгээ дэвшүүлье.

6 дугаар сарын 13-нд Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайханд төржээ.

Улсын Их Хурлын гишүүн Сайнбуянгийн Амарсайханд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанд ирцэд бүртгүүлсэн эртэч гишүүдийг танилцуулъя. Буланы Бейсен, Сүхбаатарын Эрдэнэбат, Ганбатын Хосбаяр, Сүхбаатарын Эрдэнэболд, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын гишүүд эртэч гишүүд болсон байна.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр хуралдаанаар дараах 21 асуудал хэлэлцэнэ.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батална. Нийт 3 төсөл байгаа.

Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг хэлэлцээд үргэлжлүүлэн явуулна.

Гурав.Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдсан тохиолдолд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үргэлжлүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Долоо.“Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Өчигдөр хэлэлцэх ёстой асуудлуудаас хэлэлцсэн. Одоо санал хураалтууд явна.

Тэгэхээр санал хураалт явах учраас гишүүдийг танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

8, 9. 10. Эдгээр асуудлууд Улсын Их Хурлын тухай болон Улсын Их Хурлын дэгийн тухай, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиудын төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулах ёстой.

Төрийн байгууллагад хуралдсан тохиолдолд хэлэлцэнэ. Хуралдахгүй бол өнөөдөр хэлэлцэх асуудлаас хасагдана.

Арван нэг.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван гурав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван дөрөв.Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван тав.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Арван зургаа.Газрын тосны хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулна.

Арван долоо.Улсын нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Арван най.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Арван ес.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.

Хорь.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулна.

Хорин нэг.Баталсан хууль тогтоомжийн эцсийн найруулгыг сонсоно.

Ийм хорин нэгэн асуудал хэлэлцэхээр төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээл гэж заасан.

Үүний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн нарын 13

гишүүн 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд,

Хоёр.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг нарын 21 гишүүн 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 42 дугаар сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө 20 жилийн ойг тэмдэглэж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/ /алга ташив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Хуулийн төслүүдийг эцэслэн батлах

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл.

“Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцэслэн батална.

Эцэслэн батлах санал хураалт явагдана. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Бүртгэлийн санал хураалт явуулъя. /алх цохив/

Ирц, бүртгэлийн санал хураалт. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Ж.Галбадрах гишүүн суудалдаа сууя. Орж ирээгүй гишүүд. Ж.Баярмаа гишүүн суудалдаа суугаад ирцдээ оръё. Ж.Чинбүрэн гишүүн. Ирц бүртгэлийн санал хураалт явна. Татгалзсан гарч байгаа гишүүд нэрсээ хараад чуулгын танхимдаа хүрэлцэн ирээрэй. Бүгд бэлэн үү? Д.Ганбат гишүүн хурууныхаа хээг уншуулсан уу? Ж.Золжаргал гишүүн.

Ирц бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

Н.Алтанхуяг гишүүн, Б.Батбаатар гишүүн, О.Батнайрамдал гишүүн, А.Ганбаатар гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, П.Мөнхтулга гишүүн, Д.Пүрэвдаваа

гишүүн, О.Саранчулуун гишүүн, Г.Хосбаяр гишүүн. Даваагийн Цогтбаатар гишүүн байна. Дамдины Цогтбаатар гишүүн, Л.Энх-Амгалан гишүүн, С.Эрдэнэбат гишүүн, С.Эрдэнэболд гишүүд чуулганы танхимд хүрэлцэн ирнэ. Манай гишүүд орж ирж байна. Б.Мөнхсоёл гишүүн байгаа мөртлөө ороогүй байна. Тийм ээ.

Хуулийн төслүүдээ эцэслэн батлах хувилбарыг холбогдох Байнгын хороо бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлдэж амжсан уу?

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярын урилгаар Дорнод аймгийн ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа, төгсөлтийнхөө 40 жилийн ойг тэмдэглэж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/ /алга ташив/

Гишүүд анхааралтай байцгаая. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Ж.Золжаргал гишүүн суугаарай. Санал хураалт. Л.Энхнасан гишүүн суугаарай. Санал хураалт.

Санал хураалт явууллаа шүү. Санал хураалт. Уучлаарай. Саналын томьёоллоо уншаагүй байна шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцогдоно гэж заасан. Санал хураалт.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 72 гишүүн буюу 88.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 81 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 87.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Холбогдуулан боловсруулсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 83 гишүүн оролцсоноос 75 гишүүн буюу 90 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачилсан П.Батчимэг нарын гишүүд, ажлын хэсгийг ахалж ажилласан Г.Уянгахишиг нарын гишүүддээ нийт гишүүдийнхээ нэрийн өмнөөс талархал илэрхийлье. /алга ташив/

Энэ оны 7 сарын 01-нээс эхлээд скүүтер, мопед, сурроныг 18 нас хүрээгүй хүүхдүүд унахыг хориглосон хууль батлагдлаа.

Энэ хуулийн хариуцлагын заалтууд олон байгаа. Ялангуяа эцэг, эхчүүд 18 нас хүрээгүй хүүхдүүддээ скүүтер, мопед, суррон унуулах юм бол хариуцлага хүлээнэ.

Мөн скүүтер, мопед, суррон түрээсэлдэг байгууллагууд насанд хүрээгүй хүүхдүүдэд скүүтер, мопед, суррон түрээслэх юм бол бас хуулийн хариуцлага хүлээнэ. Ийм байдлаар замын хөдөлгөөний аюулгүй байдалд хүүхэд багачуудынхаа амь нас, эрүүл мэндийг хамгаалсан хуулийг нийт гишүүд маань баталлаа.

Хуулийн төсөл, тогтоолын төслийг баталсан Улсын Их Хурлынхаа нийт гишүүддээ талархлаа илэрхийлье.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хоёр.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Засгийн газар 2026.05.26-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийг үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Тийм ээ. Горимын санал байхгүй. Бүлгээс ү үг хэлж болно. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 79.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Хамт өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 61 буюу 70.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн санал хураалтад оролцсоноос 63 гишүүн буюу 73.3 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алх цохив/

4.Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн санал хураалтад оролцсоноос 60 гишүүн буюу 69.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

5.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

6.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 73.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

7.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 47 гишүүн буюу 54.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

8.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 57 гишүүн буюу 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

9.Газрын хэвлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 67.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

10.Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалтын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцож 48 гишүүн буюу 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

11.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 59.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

12.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

86 гишүүнээс 57 гишүүн буюу 66.3 хувиар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн Заг сумын ерөнхий боловсролын сургуулийн 1981, 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

1981 онд Д.Ганбат гишүүн төгссөн юм шиг байна. 1996 онд Д.Жаргалсайхан гишүүн төгссөн юм болов уу. Хамт яваад байх юм. Бас Да.Цогтбаатар гишүүн 1985 онд төрсөн. Хамт байна. Тэнд.

Дараагийн асуудалдаа оръё.

**Гурав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн М.Энхцэцэг нарын 70 гишүүн
2026.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийг үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх санал хураалт явуулна.

М.Энхцэцэг гишүүний Эрчим хүчний дэд хороо байгуулах төсөл байгаа.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 86 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 69.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

С.Одонтуяа гишүүнийг дэмжсэнээр авъя. 61 гишүүн боллоо.

Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ.

А.Ундраа гишүүнийг дэмжсэнээр, У.Отгонбаяр гишүүн, Б.Хэрлэн гишүүн дэмжсэнээр авъя. 65 гишүүн боллоо.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**
/Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 04 дүгээр дүгнэлтийг
хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан боловсруулсан,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Санал хураалтдаа бэлдэж дууссан уу? Гишүүд ээ. Санал хураалт явуулъя.

Байнгын хорооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 74.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

П.Батчимэг гишүүн, Ж.Баярмаа гишүүдийг дэмжсэнд авъя. 67.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг С.Замира гишүүнийг дэмжсэнд авъя. 68. Б.Пунсалмаа гишүүнийг дэмжсэнд авъя. 69.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Тав.Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, мөн түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж, мөн бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс хоёр хүртэлх гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 21 санал байна.

Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын сургуулийн 1990 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Зарчмын зөрүүтэй 21 санал байгаа. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 3.1.15 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3.1.14 дэх заалт болгож, 3.1.16 дахь заалтыг, мөн зүйлийн 2 дахь заалтыг тус тус хасах:

“3.1.14.“хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан, жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Т.Мөнхсайхан, П.Батчимэг, Г.Ганбаатар, Н.Наранбаатар, А.Ундраа, Б.Уянга. Цаашид “Ажлын хэсэг” гэх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 67.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

П.Батчимэг гишүүн дэмжсэнээр авъя. 60 гишүүн А.Ганбаатар гишүүн. 61 гишүүн.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 4.2.1 дэх заалтын “хүртээмжийн” гэснийг “хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн” гэж, 4.2.2 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, 4.2.4 дэх заалтын “салбарын” гэснийг “аюулгүй байдлыг хангах” гэж өөрчилж, 4.3, 4.4 дэх хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 65 буюу 74.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 4 дэх заалтад доор дурдсан агуулгатай 4.3 дахь хэсэг нэмэх:

“4.3.Энэ хуулийн 4.2 дахь хэсэгт заасан хүнсний аюулгүй байдлын бодлогыг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, мэдээлэл болон эрсдэлийн удирдлага, хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ.”

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.
/алх цохив/

87 гишүүнээс 67 гишүүн буюу 77.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.
/алх цохив/

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалт буюу 4² дугаар зүйлийн 4^{2.1} дэх хэсгийн “мэргэшүүлэх, хөгжүүлэхэд,” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, “хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан” гэснийг “хүнсний асуудал эрхэлсэн” гэж өөрчилж, “нөөцийн эрэлт хэрэгцээний судалгааг тогтмол хийж, хүний” гэснийг, 4^{2.2} дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг тус тус хасаж, 4^{2.3}, 4^{2.4}, 4^{2.5}, 4^{2.7}, 4^{2.8}, 4^{2.9} дэх хэсгийг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4² дугаар зүйлийн дугаарыг 13² гэж өөрчлөх:

“4^{2.3}.Хүнсний салбарын мэргэшлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4^{2.4}.Энэ хуулийн 4^{2.3}-т заасан журамд мэргэжлийн зэргийн төрөл, хэлбэр, хугацаа, мэргэшүүлэх чиглэл, тавих шаардлага, сургалтын багц цаг болон зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

4^{2.5}.Энэ хуулийн 4^{2.4}-т заасан мэргэшлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд мэргэжилтэн уг шийдвэрийн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 75.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 5.6 дахь хэсгийн “хүртээмжтэй байлгана” гэснийг “хүртээмжтэй байлгах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ.” гэж өөрчилж, 5.5 дахь хэсгийг, 5.8 дахь заалтын “тусгайлсан” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёололоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцоноос 64 гишүүн буюу 73.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

6.Төслийн 1 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёололоор санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 66 гишүүн буюу 75.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

7.Төслийн 1 дүгээр зүйлийн 8.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд;” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 69 буюу 79.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

8.Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалт буюу 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 10.4.3 дахь заалт болгох:

“10.4.3.хүнсний экспорт, импорт, шошгололт, хадгалалт, хүргэлт, цахим болон бусад худалдаанд.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 68 гишүүн буюу 78.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

9.Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалт буюу 13.1.6 дахь заалтын “баталгаат” гэснийг “бүтээгдэхүүний аюулгүй” гэж өөрчилж, мөн зүйлийн 12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 64 буюу 73.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

10.Төслийн 1 дүгээр зүйлийн 13 дахь заалтын 13² дугаар зүйлийн 13².3.8 дахь заалтын “баталгаат” гэснийг “аюулгүй” гэж, “олон нийтэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх” гэснийг “олон нийтийг соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгааны” гэж өөрчилж, 13².3.9 дэх заалтын “таван жил” гэсний өмнө “гурваас” гэж нэмж, 13².3.6 дахь заалтын “өндөр хөгжилтэй орны” гэснийг, 13².3.7 дахь заалтын “мэргэжилтэн болон хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг

хуулийн этгээдийн” гэснийг, 13².3.10 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт /алх цохив/

87 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 79.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

11.Төслийн 1 дүгээр зүйлийн 14 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17¹ дүгээр зүйл.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан

17¹.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, эрхлэн хөтөлнө.

17¹.2.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

17¹.2.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл;

17¹.2.2.гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл;

17¹.2.3.баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, хувиргасан амьд организмээс гаралтай хүнсний бүртгэл;

17¹.2.4.хяналт шалгалтын тайлан;

17¹.2.5.импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл;

17¹.2.6.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

17¹.2.7.хүнсний сорилтын лабораторийн шинжилгээний дүн;

17¹.2.8.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17¹.3.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 27.9-д заасны дагуу зохицуулна.

17¹.4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл ашиглах, цуглуулах, хэлбэр, хугацаа, мэдээллийн ил тод байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 78.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Зочин танилцуулъя. Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын ерөнхий боловсролын сургуулийн 1992 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа он жавууддаа, 92 анги төгсөгчдөө Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Санал хураалтаа үргэлжлүүлье.

12.Дээрх 6 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 61 гишүүн буюу 70.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

13.Төслийн 2 дугаар зүйлийн “1 дүгээр зүйлийн “зорилт нь” гэсний дараа “хүнсний аюулгүй байдлыг хангаж, хүний эрүүл мэндийг дэмжин хамгаалах зорилгоор” гэж,” гэснийг, “, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “харилцааг” гэсний дараа “тусгайлсан” гэж гэж” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 65 гишүүн буюу 74.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

14.Төслийн 3 дугаар зүйлийн 5¹ дүгээр зүйлийн 5^{1.7} дахь хэсгийн “дүгнэлтийг үндэслэн” гэснийг “санал, зөвлөмжийг харгалзан” гэж өөрчилж, 5^{1.6} дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 67 гишүүн буюу 77.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

15.Дээрх 1, 2, 13 дахь санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.Хүнсний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “эрхлэхтэй” гэснийг “эрхлэх, түүнд хяналт тавихтай” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтын “үйлдвэрлэсэн” гэснийг “үйлдвэрлэсэн хүнс” гэж, “хийгдсэнийг” гэснийг “хийгдсэн хүнснийг” гэж, “4 дүгээр зүйлийн гарчгийн “зарчим” гэснийг “зарчим, бодлогын чиглэл” гэж, Хоёрдугаар бүлгийн гарчгийн “ХАНГАМЖ” ГЭСНИЙГ “ХАНГАМЖ, ХҮРТЭЭМЖ” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалтын “боловсруулах болон нийтийн хоолны үйлдвэрлэл” гэснийг “хүнсний боловсруулах болон хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын “шим тэжээллэг байдалд” гэснийг “шим тэжээллэг байдал, хуурамч

хүнсний бүтээгдэхүүнд” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 62 гишүүн буюу 71.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

16.Дээрх 1, 2, 13, 14 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 64 гишүүн буюу 73.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алх цохив/

17.Төслийн 6 дугаар зүйлийн “3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.1,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 63 гишүүн буюу 72.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алх цохив/

Найруулгын санал.

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 61 гишүүн буюу 70.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. /алх цохив/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй. Саналын томьёолол.

Нэг.ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 4.1.4 дэх заалтын “хүнсний баталгаат байдал” гэснийг “хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 61 гишүүн буюу 70.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

2.Дээрх 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 59 гишүүн буюу 67.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.
/алх цохив/

**Хоёр.ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “, 6.15 дугаар зүйлийн гарчгийн “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах” гэснийг “Хүнсний бүтээгдэхүүний баталгаат байдлыг хангах” гэж, 13.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бүтээгдэхүүний аюулгүй байдал” гэснийг “бүтээгдэхүүний баталгаат байдал” гэж тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

87 гишүүнээс 60 гишүүн буюу 69.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.
/алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

**Зургаа.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж,
түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нарын 17 гишүүн
2026.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Санал хураалттай шүү дээ. Гишүүд ээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийг үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлдэж дууссан уу? Санал хураалт явуулъя.

1. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноор 49 гишүүн буюу 56.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Хамт өргөн мэдүүлсэн 7 хуулийн төсөл байгаа.

2. Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 48 гишүүн буюу 55.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

3. Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 44 гишүүний 50.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

4. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 58.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

5.Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос С.Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн гишүүн горимын санал.

С.Цэнгүүн: Сая төхөөрөмж ажилласангүй. Санал хураалтыг дахин явуулахыг хүсье. Хүчингүй болгохыг хүсье.

С.Бямбацогт: С.Цэнгүүн гишүүний санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг дэмжье гэсэн томьёолол санал хураалт явуулъя. /алх цохив/

С.Цэнгүүн гишүүний гаргасан горимын санал дэмжигдсэнгүй.

П.Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Төхөөрөмж ажилласангүй. Дарга аа. Энэ саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт хийж өгөөч.

С.Бямбацогт: Саналыг бут буцаах ёстой. Тийм ээ. Р.Эрдэнэбүрэн гишүүн горимын санал гаргая. Р.Эрдэнэбүрэн гишүүн. Р.Эрдэнэбүрэн гишүүнд микрофон өгье.

Р.Эрдэнэбүрэн: Миний төхөөрөмж ажилласангүй.

Тийм учраас энэ саналыг дахиж хураалгаж өгнө үү.

С.Бямбацогт: Р.Эрдэнэбүрэн гишүүний гаргасан горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 45 гишүүн буюу 50.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Санал хураалт. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 45 гишүүн буюу 50.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

6.Соёлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 58.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

89 гишүүнээс 53 гишүүн буюу 59.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

8.Биеийн тамир, спортын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

90 гишүүн санал хураалтад оролцсоноос 55 гишүүн буюу 61.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Долоо. “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар
авах зарим арга хэмжээний тухай”**

Улсын Их Хурлын тогтоолын төсөл, /үргэлжлэл/

“Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авч дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Санал хураалтдаа бэлдэж дуусаж байна уу? Санал хураалт явуулна.

Байнгын хорооны саналаар “Үндэсний хиймэл дагуул хөөргөх төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоо р санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 90 гишүүн оролцсоноос 63 гишүүн буюу 70.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүддээ талархлаа илэрхийлье.

Дараагийн асуудалдаа оръё.

**Найм.Татварын ерөнхий хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Пүрэвжавын Ганзориг танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл тус бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүнийг бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед –

- **Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг татвар төлөгчийн хууль даган мөрдөлтийн түвшинтэй уялдуулан хойшлуулахаар тусгасныг Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгах боломжтой эсэх,
- **Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа** Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг уялдуулан Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх боломжтой эсэх, мөн хууль, даган мөрдөлтийн түвшинтэй уялдуулан гаалийн үйл ажиллагаа болон татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан, хоорондын уялдаа холбоог хангагдаж байгаа эсэх,
- **Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар** хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хамруулах зохицуулалтыг төсөлд нэмж тусгах боломжтой эсэх, цаашид тус салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих татварын бодлогын талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хурал хуралдаанаар хуулийн төслийн анх анхны хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс бэлтгэсэн татварын өр барагдуулах ажиллагаанд татвар төлөгчийн санхүүгийн чадамж, бизнесийн үйл ажиллагаанд учирч болох болзошгүй эрсдэл, хүндрэлийг харгалзан дансыг бүхэлд нь битүүмжлэх бус дансанд орох орлогын 20 хувийг дансанд үлдээх зохицуулалтыг 30 хувь болгон нэмэгдүүлэх зэрэг зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан татвар төлөгчдийн банкн дахь дансанд ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгөөс гаргуулах татварын өрийн хэмжээг тухайн орлогын 80 хүртэл хувиас хэтрүүлэхгүй гэснийг 50 хувь гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй нэг санал гаргасныг хуралдаанд оролцогчдын гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: П.Ганзориг гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Загджавын Мэндсайхан Сангийн сайд, Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.24-д нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийж байгаа Засгийн газрын гишүүн, ажлын хэсгийн гишүүд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

Нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх, асуултад хариулах, тайлбар өгөх албан тушаалтан өөрийнхөө танилцуулж байгаа мэдээллийн үнэн зөвийг хариуцан, мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, худал мэдээлэл өгч танилцуулах, Улсын Их Хуралд худал мэдээлэл ирүүлэхийг хориглоно гэсэн хуулийн заалттай шүү.

Чуулганы нэгдсэн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, тайлбар өгөхөөс татгалзсан, хуралдаанд оролцсон этгээд дэг зөрчсөн бол парламентыг үл хүндэтгэсэн үйлдэлд тооцож хариуцлага тооцдог болохыг анхааруулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Батын Батбаатар гишүүн. Алга байна. /алх цохив/
Одонгийн Цогтгэрэл гишүүн. Алга байна. /алх цохив/

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Ажлын хэсгийн гишүүн ажлын хэсэг дээр нэлээн асуултуудаа тодруулчихсан учраас энэ дээр асуух асуулт алга.

Харин зарчмын зөрүүтэй санал гаргаж ажлын хэсэг, Байнгын хороон дээр дэмжигдсэн ажлын хэсгийн тэр татварын үл маргах журмаар татварын данс хаагаад орлого татан төвлөрүүлдэг энэ хувийг 80 хувь болгож оруулж ирснийг ажилчдын цалин, нийгмийн даатгалтай холбоотой зардлыг нь ядаж үлдээх гэдэг агуулгаар 30 хувийг нь үлдээж, 70 хувийг нь татварын өр барагдуулах үйл ажиллагаанд зарцуулах санал гаргасныг Улсын Их Хурлын гишүүдийг дэмжиж өгөхийг хүсэж байна. Баярлалаа. Байнгын хороо дэмжсэн санал байгаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя.

Ц.Баатархүү: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Татварын хууль бол хамгийн сайн хэрэгждэг хууль гэж бодож байна. Татварын алба татвараа бүрдүүлэхийн төлөө данс хаагаад л татварын орлогын төлөө цаг наргүй ажиллаж байдаг. Тэгэхдээ нэг зүйл энэ дээр дутуу харагдаад байгаа.

Энэ үндэстэн дамнасан технологийн компаниудын дижитал үйлчилгээний татварын асуудлыг ер нь хэзээ оруулж ирэх юм бэ. Энэ бол дэлхий даяар дижитал үйлчилгээний татварыг яах вэ гэдэг дээр бүгдээрээ шийдэл гаргаад явж байна. Монгол Улсад контент үйлдвэрлэж байгаа, дижитал үйлчилгээ хийж байгаа компаниуд яг ингээд орлогынхоо татварыг өгөөд хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Гэтэл үндсэн дамнасан энэ компаниудын асуудлыг цаашдаа татварын бодлого яаж авч явах юм бэ? Энэ бол иргэдээс зар сурталчилгааны шинжтэй, үйл ажиллагааны шинжтэй маш олон орлогыг татаж авдаг. Бид Монголбанкн дээрээс сар болгоны үндэстэн дамнасан технологийн компанийн Монголоос гарч байгаа долларыг бүгдээрээ харж байгаа.

Гэтэл энэ орлогын татварт бүртгэгддэггүй. Хилээр оруулж ирж байгаа зүйл нь гаалийн татвар өгдөг. Энэ зохицуулалт дээр тодорхой санал гаргах юм уу, үүнийг оруулж ирэх юм уу.

Ер нь энэ удаагийн татварын хууль яаран сандран оруулж ирсэн, олон талаас нь авч үзээгүй ийм түүхийн хууль орж ирж байна гэж харж байна.

Монгол аж ахуйн нэгж хийхээр татвар яс авдаг. Өөр аж ахуйн нэгж хийхээр татварын хөнгөлөлт үзүүлдэг ялгаатай байдлыг шийдэх, тэр дундаа дижитал салбарт яаж шийдэх юм бэ гэдэг асуултыг асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Хассуурийн Ганхуяг гишүүн. Ажлын хэсгийн ахлагч.

Х.Ганхуяг: Тийм. Ц.Баатархүү гишүүн маш зөв асуудлыг хөндөж байна. Бид хуулийг батлагдсаны дараа Их Хурлын тогтоолыг гаргана.

Их Хурлын тогтоол дээр төсөв өргөн барихдаа энэ асуудлыг хөндөж өргөн бариарай гэдэг байдлаар тогтоолд оруулъя.

ОECD-тэй уулзахад том компаниудаас, үндсэн дамнасан компаниудаас татварын асуудлаа та нар авах ёстой шүү, шийдэх ёстой шүү гэдэг асуудлыг ярьдаг. Тэр тусмаа манайх шиг ийм жижигхэн орон шударга ёсны төлөө энэ татвараа өгөөч ээ, НӨАТ-аа төлөөч ээ гэх боломжийг нь ёс зүйн хүндрэл нь бид нарт байгаа юм байна лээ.

Гэхдээ энэ асуудлыг бид өөрсдөө хуульдаа оруулж өгөх хэрэгтэй. Татварын газар тэр компани болгонтой нь хэлцэлд орох ёстой гэсэн үг. Хэлцэлд орох ёстой гэсэн үг. Энэ бол боломжтой юм билээ. Энэ бол аваад эхэлсэн. Ихэнх орнууд аваад явж байгаа.

Татварын хуулийн төслийг боловсруулж байхдаа энэ асуудлыг оруулсан байсан юм. Тэгэхдээ сая өргөн баригдсангүй. Гэхдээ энэ асуудлыг төсөв өргөн барихдаа оруулж ирээрэй гэдэг байдлаар бас оруулъя.

С.Бямбацогт: Баярлалаа.

Зочин танилцуулъя. Завхан аймгийн Дөрвөлжин сумын ерөнхий боловсролын сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө ойн баярыг тэмдэглэж байгаа, Төрийн ордонтой танилцаж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Татвар төлөгчдийн статистикийн талаар асуух гэж байна.

▷ **Нэгдүгээрт,** Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хувь эзэмшдэг эзэмшигч аж ахуйн нэгжийн тоог.

▷ **Хоёрдугаарт,** дансаа хаалгасан аж ахуйн нэгж байгууллагуудын чинь дунд хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажилладаг юм уу, эсвэл үүсгэн байгуулагч нь байдаг тийм аж ахуйн нэгжийн тоо байсан уу гэдэг хоёр асуултыг асуугаад дараа нь тодруулъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Татварын ерөнхий газрын дарга Б.Цогтнаран.

Б.Цогтнаран: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Татварын ерөнхий газар Б.Цогтнаран.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсгэн байгуулсан хуулийн этгээдүүдийн талаарх мэдээллийг Та хүсэж байна. Энэ мэдээллийг Улсын бүртгэлийн албатайгаа хамтраад боловсруулаад танд эргээгээд албан бичгээр хүргүүлье. Яг одоогоор тийм мэдээлэл алга байна.

С.Бямбацогт: О.Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бизнес хийдэг хүмүүсээ бид тоолдоггүй юм биш биз дээ.

Оруулж байгаа татварыг нь авдаг. Тэгэхдээ тооцоолдог мэдээлэл нь ил харагдахгүй байна шүү дээ. Одоо тэгвэл тоолоод, бүртгээд яг үнэхээр хэдэн хүн, аж ахуйн нэгж татвар төлөөд ажил хийгээд явдаг юм бол оо? Тэр тоог нэгдүгээрт гаргах хэрэгтэй байгаа.

Хоёрдугаарт нь, гаргачхаад тэр дүн нь өнөөдөр ямаршуу хэмжээний байдаг юм бол гэдгийг харахаар өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчид ер нь ямар эко орон зай орчин байгаа асуудлыг бид энэ тооноосоо л дүгнэлт хийж байна гэсэн үг.

Тэгэхээр энэ хуулийн төслийг хэлэлцэж дуусахаар гэж 14 хоног хүлээхгүйгээр надад энэ мэдээллийг өнөөдрийн дотор яаралтай бэлдэж өгнө үү. Баярлалаа.

С.Бямбацогт: Саяын хэлсэн мэдээллүүдийг нь бэлдээд өгөөрэй. Бичгээр асуултуудад нь гүйцээгээд мэдээлэл өгчхөөрэй.

Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/
Д.Үүрийнтуяа гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Зарчмын зөрүүтэй саналууд байгаа. Татварын багц хуулиудын санал хураалтыг 14.00 цагаас явуулна. Бусад хуулиудын санал хураалтыг 17.00 цагаас явуулна.

Гишүүд өнөөдөр чуулганыхаа хуралдаанд бүрэн оролцъё. Зарчмын зөрүүтэй санал дээрээ хэлнэ. Санал хураалтын үед. Ер нь чуулганаа жоохон шахаж ачаалалтай хуралдахгүй бол хэлэлцэх асуудал олон байгаа шүү.

Дараагийн асуудалдаа оръё.

**Ес.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг гишүүн танилцуулна.

П.Ганзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдрөөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийн хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулахад –

- **Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал** 0-ээс 6 тэрбум төгрөг, 6-аас 10 тэрбум төгрөг, 10-аас дээш тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн тоо, төсөвт төвлөрүүлэх орлогын дүн

болон жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын хөнгөлөлтийн талаар,

— **Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг** борлуулалтын орлогоос үл хамааран дэвшилтэт техник, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулж, улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед ажлын хэсгээс сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмжийн график, тусгай зориулалтын процессор бүхий тооцоолон бодох тоног төхөөрөмжүүдийн элэгдэлд тооцох хугацааг 3 жил болгон өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан тухайн жилийн орлогод шатлалтайгаар албан татвар ногдуулах зэрэг зарчмын зөрүүтэй 4 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: П.Ганзориг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүнийх хэвээрээ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуултаа асууна.

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн. Алга байна. /алх цохив/
Батын Батбаатар гишүүн. Алга байна. /алх цохив/
Наранцэцэгийн Алтаншагай гишүүн. Алга байна. /алх цохив/

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Алга байна. /алх цохив/
Сайнхүүгийн Ганбаатар гишүүн. Алга байна. /алх цохив/

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Энэ удаагийн татварын хуулийг бол үзэл баримтлалын хувьд бол дэмжиж байгаа.

Яах вэ, ерөнхийдөө бол татварын шинэчилсэн найруулгын хууль маань ороод удаагүй байгаа учраас маш чухал гэсэн хэдэн зүйлийг бол оруулж байна. Гэхдээ цаашдаа ажлын байр бий болгодог, татвараа шударгаар төлдөг, олон ажилтныг ардаа авч явдаг гэдэг юм уу ийм аж ахуйн нэгж, байгууллагуудыг илүү дэмжих бодлогыг ер нь цаашдаа оруулах хэрэгтэй байгаа юм.

Одоо яг ний нуугүй хэлэхэд нэг томоохон ажил хийдэг байлаа гэхэд дийлэнх нь тухайн орон нутагтаа, бусад салбаруудад давхар ачаалал үүрч авч явдаг. Тухайлбал, орон сууцдаг бодлого гэхэд ажилтнууддаа ядаж –

- орон сууцын урьдчилгаа өгчихдөг,
- 5, 10 саяыг гэхгүй өгчихдөг,
- тодорхой хэмжээгээр олон жил ажилласан хүнийхээ тэтгэврийн даатгал гэдэг юм уу, эрүүл мэндийн үйлчилгээ гэдэг юм уу ийм зүйл дээр нь дэмжлэг, туслалцаа үзүүлээд байдаг аж ахуйн нэгж, байгууллагууддаа жоохон урамшуулмаар байгаа юм.

Энэ нь өөрөө давхар нийгмийн асуудлуудыг зөвхөн төр гэхгүй бусад хувийн хэвшил болон бусад салбарт ажиллаж байгаа олон салбарыг уг нь ингээд дэмжээд аваад явах боломж, бололцоо байгаа юм.

Тухайлбал, хүүхдүүддээ сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг үзүүлсэн бол тодорхой хэмжээний хөнгөлөлтийг нь тэр аж ахуйн нэгж, байгууллагыг нь урамшуулдаг гээд. Иймэрхүү татварын бодлогоо бусад –

- ▶ боловсрол,
- ▶ эрүүл мэнд,
- ▶ орон сууцжуулах,
- ▶ мөн сэргээгдэх эрчим хүчний гээд л байж байна.
- ▶ Ажилтнууддаа ядаж нарны панел аваад өгчихдөг,
- ▶ бие даасан нэг дэд бүтэцтэй болоход нь,
- ▶ орлого олох боломжийг нь олгох юм бол –

-тэр аж ахуйн нэгж, байгууллагууд дээр татварт ногдох орлогууд дээр нь хөнгөлөлт, дэмжлэг гэдэг юм уу, эсвэл тодорхой төрийн худалдан авалтад давуу

эрхээр оролцох боломж, бололцоог нь өгдөг гэдэг юм уу, ийм зүйлүүдийг ер нь хийх хэрэгтэй байгаа юм.

Гэхдээ энэ удаад татварын шатлалыг дээшээ болгож байгаа бол дэмжиж байгаа. Ажлын хэсэгт саналууд өгсөн. Харамсалтай нь Засгийн газрын хөндөгдөөгүй асуудал гэдгээр хойшоо суусан.

Тэгэхээр ажлын хэсэг дээр энэ асуудлыг ер нь яг юу гэж ярьсан бэ? Х.Ганхуяг дарга аа. Маш чухал чухал саналууд уг нь байгаа.

Тийм учраас цаашдаа бид бодлогоо бариад дараагийн жилүүдэд татварын талаар баримтлах концепцоо гаргаад тавихгүй бол одоо Татварын хууль гарахаар зарим нь энэ яасан, тэр яасан гээд. Үүний өмнөх Татварын хууль дээр хүлээлттэй олон асуудлууд байгаа. Гэхдээ гол асуудлыг нь бид аж ахуйн нэгжийн орлогын албан татвар дээр бариад авсан асуудал байгаа.

Тийм учраас энэ тал дээр тодруулж асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Х.Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энэ аж ахуйн нэгжийн татварын хуульд нэг шатлал нэмэгдэж байгаа.

► **Нэг шатлал нэмэгдэнэ гэдэг нь** 6-аас 10 тэрбум ашигтай ажилласан тохиолдолд 6-аас 15 хувийн шатлалыг оруулж өгч байгаа.

— Ингэснээр нийт эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь **0.1 хувиар эдийн засгийн өсөлт нэмэгдэх** боломж бүрдэнэ.

— 15 хувийн шатлал оруулж өгснөөр нийтдээ **246.0 тэрбум төгрөгийн татварын ачааллыг бууруулах** боломжтой.

Нийтдээ 2027 онд 620 аж ахуйн нэгж 6-аас дээш тэрбумын ашигтай ажиллахаар харагдаж байгаа. Энд нийтдээ 440 мянган ажилтан байгаа.

Тэгэхээр ашгаас нь бид татвараа бууруулж байгаа хэмжээгээр эргээгээд аж ахуйн нэгжүүд нь нийгмийн хариуцлагын хүрээнд тэр –

- сургалтын төлбөр байдаг юм уу,
- орон сууцын дэмжлэг байдаг юм уу –

үзүүлэх боломжтой юм.

Яг одоо С.Эрдэнэбат гишүүний ярьж байгаа тэр нийгмийн хариуцлагын хүрээнд ажилтнуудаа дэмжих. Уг нь заалтыг нь бид 22.9-д оруулсан шүү дээ. Аж ахуйн нэгжийн орлогын татварын хуульд.

Түүн дээр харин нэг сөрөг заалт нь юу орсон гэхээр нөгөө “ашиг сонирхлын зөрчилтэй байж болохгүй” гэдэг заалт орсноор аж ахуйн нэгжүүд нь ажилтнууддаа –

- байр, орон сууц,
- сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх –

гэхээр хуулийн нэг заалт бас байгаад байгаа юм. Бид аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн байдлаар татварын хуульд энэ шатлал орж ирснээр аж ахуйн нэгжүүд эргээд албан хаагчдадаа харж үзэх, нийгмийн хариуцлагын хүрээнд асуудлуудаа шийдэх боломжууд нэмэгдэнэ.

Хоёрдугаарт, хувь хүний орлогынх нь татварыг бас нэлээн хэмжээгээр бууруулж байгаа. Тэгснээрээ манай энэ хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээс гадна тэр орлогыг өрхөд нь үлдээх тийм бодлого явна гэсэн үг. Тэгснээрээ –

- ипотект хамрагдах боломжууд нэмэгдэнэ,
- иргэд цалингийн зээлээсээ салах боломжууд бүрдэнэ гэж харж байгаа.

Цаашдаа татварын реформ байнга үргэлжлээд явах ёстой. Миний хувьд цаашдаа энэ төсөв өргөн барих дээр хэд хэдэн чиглэлүүдийг өгье гэсэн бодолтой байгаа. Улсын Их Хурлын тогтоолоор үүрэгжүүлж.

Гэхдээ бид татвараа бүрэн бүртгэдэг, мэддэг байхын тулд –

- Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг цаашдаа өөрчлөх хэрэгтэй.
- Аж ахуйн нэгжийн албан татварын хуульд тодорхой хэмжээний өөрчлөлтүүд хийх хэрэгтэй л гэж харж байгаа. Баярлалаа.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Баатархүүгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 11, 13 дугаар хорооны иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төрийн ордонтой танилцаж байгаа иргэддээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Манай Ц.Баатархүү гишүүн Чингэлтэй дүүргийн иргэд бүгдийг нь уулзуулах нь ээ. төрийн ордондоо танилцуулах нь ээ.

Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Үргэлжлүүлээд нийгмийн хариуцлага ба татварын хамаарлын талаарх асуудлуудаа тодруулах гээд байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулдаг 25.1 гэдэг хуулийн заалт байдаг. Яг энэ заалтаар –

- Үйл ажиллагаагаа ажиллуулдаг аж ахуйн нэгжийн тоо хэд байдаг вэ?
- Ажиллуулаагүйнхээ төлөө төлдөг тоо, дүн нь хэдэн төгрөг байдаг вэ?

▷ **Хоёрдугаарт,** татвараас хөнгөлөхдөө бид зөвхөн мөнгөн дүн, орлогын хэмжээ гээд яваад байгаа. Татварын хөнгөлөлтийн бодлого дээр ер нь хөдөлмөр эрхлэлтийн квот, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа байдал зэргийг тооцоолох, шатчлах, урамшуулал болон татварын бодлогоор дэмжих өөр ямар хувилбар ер нь байж болох вэ? Энэ талаар би Та бүгдийн саналыг сонсох гээд байгаа юм.

Тэгээд бас тодруулна.

С.Бямбацогт: Хассуурь Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулахад компаниуд дээр 100 хүнд хэдэн хүн билээ. Нэмээд гүйцээгээд хариулчхаарай. Би нөгөө тоонуудыг нь санахгүй байгаа болохоор.

100 хүн тутамд 25 хувь гэж санагдаж байна. Хүн ажиллуулбал татварын нэлээн хөнгөлөлтүүдийг эдэлдэг.

Өнгөрсөн хоёр долоо хоногийн өмнө. О.Саранчулуун гишүүн бараг мэдэж байгаа байх. Бид харааны бэрхшээлтэй иргэдийн төв дээр үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд хүлээлгэж өгсөн байгаа. Тухайлбал, хараагүй иргэд буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс тэр үйлдвэрээс нь худалдан авалт хийвэл бас мөн ялгаагүй компаниуд татварын хөнгөлөлт эдэлдэг гэх мэтчилэн байгаа.

Хөдөлмөрийн чадвараа 50 болон түүнээс дээш хувиар алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилладаг аж ахуйн нэгжүүд болон нийт ажиллагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүний эзэлж байгаа хувь хэмжээгээр нь аж ахуйн нэгжийн орлого дахь ногдох албан татварыг хөнгөлж өгч байгаа.

- 4 аж ахуйн нэгж 1.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна. Энэ хугацаанд. Энэ жил л гэсэн үг.

Тэгэхээр үүнийг жоохон сурталчлах хэрэгтэй байна. Яагаад гэхээр манай иргэд, аж ахуйн нэгжүүд тэр талын мэдээлэл жоохон тааруухан юм билээ. Энэ

чинь эргээд тэр иргэдийг ажиллуулбал татварын хөнгөлөлт байгаа гэдэг мэдээллийг аль болох сурталчлах шаардлагатай л гэж харагдаж байна лээ.

Өөр гүйцэж хариулах юм байвал хариулаарай. Ажлын хэсэг.

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Х.Ганхуяг гишүүнд баярлалаа. Тийм.

Тэгэхээр тэр татварын хөнгөлөлтийн тийм боломж бас байдаг байх нь.

Тэгэхээр тэрийг иргэдэд таниулахын тулд татварын газраас ямар ажил хийсэн бэ? Аж ахуйн нэгжид жишээлбэл Та бүхэн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажилд авах юм бол ийм боломж байгаа шүү гэдэг саяын Х.Ганхуяг гишүүний хэлсэн заалтын дагуу, хуулийн хэрэгжилтийн дагуу Татварын ерөнхий газар ямар ажил хийсэн юм? Сүүлийн 5 жил ч юм уу. Тийм ээ. Тоймлоод хэлээд. Түүнийх нь үр дүнд хэчнээн хүн ажилтай болсон юм?

Хоёрдугаарт нь, би асуугаад байгаа юм. Ер нь татварын бодлогоор хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ямар хувилбар байдаг юм бэ? Олон улсад. Энэ дээр Та нар ямар бодолтой байгаа юм бэ? Би Татварын ерөнхий газрынхнаас асууж байгаа шүү.

С.Бямбацогт: Ажлын хэсэг 4. Б.Цогтнаран. Татварын ерөнхий газрын дарга хариулъя.

Б.Цогтнаран: Татварын ерөнхий газар Б.Цогтнаран.

Татварын албаны үндсэн чиг үүрэгт татвар төлөгчид зөвлөгөө, мэдээлэл хүргүүлэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих чиг үүргийнхээ хүрээнд нийт татварын албанд бүртгэлтэй татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд татварын хууль тогтоомжийнхоо сурталчлах, хэрэгжүүлэх, ажлын хэрэгжилтийг нь хангаад явдаг үндсэн чиг үүрэгтэй.

Татварын алба “зөвлөн туслах” татварын алба болох зорилтын хүрээнд 2025, 2026 онуудад дунд хугацааны стратеги төлөвлөгөө дээрээ илүү “зөвлөн туслах” чиглэл рүүгээ бодлогоо тодорхойлоод явж байгаа.

2026 оны нэгдүгээр улирлын байдлаар “зөвлөн туслах” чиг үүргийнхээ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хуулийн этгээд ажиллуулдаг 17 мянга гаруй иргэдийг ажиллуулсан аж ахуйн нэгжүүддээ –

- сургалт,
- зөвлөгөө,
- үйлчилгээгээ үзүүлсэн гэдэг дүн мэдээ байна.

Өөрөөр хэлбэл энэ он гараад 6... /минут дуусав/

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. 4 дүгээр микрофон.

Б.Цогтнаран: Энэ оны хувьд “зөвлөн туслах” чиг үүргийнхээ хүрээнд 6500 орчим аж ахуйн нэгжүүдэд татварын хууль тогтоомжоо сурталчлах ажлуудаа хийгээд байгаа. Үүний цаана мэдээж 17 мянга гаруй суутган төлөгч аж ахуйн нэгж, иргэдүүд байгаа. Тэнд тодорхой хэмжээний хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ сургалт, зөвлөгөө, үйлчилгээндээ хамруулаад “зөвлөн туслах” ажлаа хэрэгжүүлсэн гэдэг дүн мэдээ байна.

С.Бямбацогт: О.Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Дансаа хаалгасан аж ахуйн нэгж, байгууллагуудын тоо судалгаа Та бүхэнд байгаа.

Тэр дансаа хаалгахад хүрсэн шалтгааных нь цаана ямар нийгмийн сэтгэл зүй, эрүүл мэндийн ч юм уу асуудал байсан бэ? Тийм ээ. Энэ аж ахуйн нэгжүүдийн цаана ер нь хүнд нөхцөлд байгаа ажилтнуудаас бүрддэг жижиг байгууллага ч юм уу, иймэрхүү асуудал байсан юм болов уу? Үүний цаадах нийгмийн асуудлыг ер нь судалж үзсэн үү? Энэ дээр бас мэдээлэл авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Х.Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Татварын ажлын хэсэг анх байгуулагдаад явж байхад яг энэ данс хаадаг харгис аргаас салгах ёстой гэсэн байдлаар хуулийн төслийг анх боловсруулж байсан.

Одоо манай П.Ганзориг гишүүн маш идэвхтэй оролцсон. Манай Р.Батболд гишүүн байна. Манай Д.Энхтүвшин гишүүн байна.

Тэр ч утгаараа Аж ахуйн нэгжийн орлогын татварын хууль болон Татварын ерөнхий хууль дээр өөрчлөлт орж ирж байгаа.

- Нэг ёсондоо шууд хаагаад, шууд мөнгийг нь авдаг биш, тодорхой хэмжээнд үлдээгээд, тодорхой хэмжээг нь татварт авдаг байх энэ зохицуулалт.

OECD (Organisation for Economic Co-operation and Development)-ийн орнуудад нэлээн түгээмэл байдаг. Одоо энд орж ирсэн загвар нь Шинэ Зеландын татварын хуулийн загвар байгаа.

Ер нь татварын дансыг хаана гэдэг нь үндсэндээ тэр аж ахуйн нэгжийг дампуураа л гэсэн үг шүү дээ. Зүгээр энгийнээр хэлэхэд. Түүнтэй холбоотой сэтгэл зүйн хүнд асуудлууд үүсдэг. Ажилтнууддаа цалингаа тавьж чаддаггүй.

- Татварын өртэй байвал тендерт ч орж болдоггүй.
- Татварын өртэй байвал тодорхойлолтоо ч авч болдоггүй.

С.Бямбацогт: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 30 жилийн ойг тэмдэглэж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Манай Ч.Ундрам гишүүн төгсөлтийнхнөө оруулаад ирсэн үү, үгүй юу? Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг 14.00 цагаас явуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Арав.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулна.

Төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Таныг индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэг бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулсан 15 гишүүн бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

- **Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал** нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлснээр татвар төлөгчийн тоо, төсөвт төвлөрүүлэх орлогын дүнгийн өөрчлөлт болон борлуулалтын орлогын ангиллаар татварын цахим системд бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн тоо өөрчлөгдөх эсэх,
- **Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа** Засгийн газарт өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулиудад тусгагдсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, валютын ханш өөрчлөхөд төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар, мөн өрхийн гишүүний тооноос хамааран татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлогоор иргэд, өрхийн бодит орлогыг дэмжих боломжтой эсэх.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед өндөр үнэлгээтэй суудлын автомашинд ногдуулах босго үнийг 100 мянган ам.доллар буюу валютаар тогтоосныг төлбөр тооцон үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэн 360.0 сая төгрөг болгон өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 400.0 сая төгрөг болгон нэмэгдүүлэх зохицуулалтыг иргэн, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдээс өнгөрсөн 2 жилийн хугацаанд ирүүлсэн саналд үндэслэн хасах, өөрчлөлттэй холбоотой зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсэж байна.

Б.Пүрэвдорж: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүчийн Татварын ерөнхий хууль дээр байсантайгаа адил.

Мөн хариуцлагын талаар Та бүхэн түрүүн сонссон.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Батын Батбаатар гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/
Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/

Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/

Болдын Уянга гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/
Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/

Чинбатын Ундрам гишүүн асуулт асууна. Байхгүй байна. /алх цохив/

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууна.

Энэ маш чухал хууль дээр яагаад гишүүд танхимаас гараад явчхаад байгаа юм бол? Асуултаа асууя. С.Цэнгүүн гишүүн.

С.Цэнгүүн: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Тэгэхээр НӨАТ яг үндсэндээ ядуу өрх айлуудад бүр хамгийн хүндээр тусдаг. Яагаад гэхээр цалингаасаа хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөд тэгээд хэрэглээн дээрээс нь бид давхар татварлаад байгаа нэг асуудал байгаа юм л даа.

Тэгэхээр НӨАТ өөрөө ганцхан аж ахуйн нэгжийн асуудлыг юм шиг хараад, тэгээд аж ахуйн нэгж дээр нь бичил жижиг аж ахуйн нэгжүүд байх юм бол НӨАТ-ын буцаан олголт дээр нь гарна гээд байгаа юм.

Гэхдээ анхнаасаа НӨАТ гэдэг зүйл маань хэрэглэгч иргэн болгон үндсэн өөрийнхөө цалингийн, татварын дараах орлогоосоо дахиж нэмж татварлуулаад байгаа гэдэг ойлголтыг иргэддээ сайн өгөх хэрэгтэй байгаа юм л даа. Тэр утгаараа НӨАТ бол маш хорлонтой татвар байгаа юм.

Дээрээс нь хууль санаачлагч 400.0 сая хүртэл босгыг нэмж байгаа юм. Энэ нь жижиг компаниудаа дэмжинэ гэж нэрлэдэг.

Гэтэл дундаж түвшний компаниудад энэ нь бүр илүү хүндрэлийг үүсгээд байна. Яагаад гэхээр бүгдээрээ адилхан НӨАТ төлдөг тийм татварын системийг бүрдүүлэхийн оронд бид ялгамж, ялгаварлал гаргаад ирэхээр чинь зарим хүмүүс нь хувь хүнээрээ, бүр ямар ч татвар төлөхгүйгээр, НӨАТ-ын ямар ч орлого оруулахгүйгээр нөгөө талдаа НӨАТ төлдөг компаниудад бараа, бүтээгдэхүүн нийлүүлдэг.

Гэтэл тэндээсээ буцааж НӨАТ-аа бид бичүүлж авч чадахгүй байгаа учраас энэ чинь буцаад бизнес эрхлэгч дээр маш том дарамт болж орж ирдэг.

Тэгэхээр НӨАТ-ынхаа бааз суурийг бид бүхэн бүгд адилхан төлдөг байя. Хэрвээ төлж байгаа юм бол бүгдээрээ адилхан НӨАТ-аа төлдөг байя.

Тэгээд тэр үндсэн сууриа нэмэгдүүлэхийн тулд хүмүүс НӨАТ хэтэрхий өндөр 10 хувь байгаа учраас төлөхгүй байгаад байна шүү дээ.

Тийм болохоор Б.Пүрэвдорж гишүүн санаачлаад байгаа НӨАТ-ыг 5 хувь болгоё гээд энэ санаачилгыг дэмжээд явах шаардлагатай байна. Тэгж байж бид эдийн засгийн бааз сууриа нэмэгдүүлээд шударга өрсөлдөөний тухай ярих ёстой.

Гэтэл улс төрчид нь аль нэг салбарыг нь ялгаж авч байгаад энэ салбар нь НӨАТ төлдөггүй байя, эндээс авдаггүй байя гээд. Тэгэхэд яг дунд нь хохирч байгаа нь ямар ч улс төрийн нөлөөлөлгүй дундаж компаниуд нь энд ямар нэгэн

хуулийн дэмжлэг, хуулийн цоорхойгүй учраас тэр хүмүүс нь нугаслуулаад үлдэж байгаа юм.

Тэгэхээр энэ дээрээ бид бодлого гаргаж өгөхгүй бол дундаж компаниуд гээд байгаа чинь 30-аас 40 хүн цалинжуулаад аваад явж байдаг, яг нийгмийнхээ зах зээлийнхээ өрсөлдөөнөөр явж байгаа хүмүүс байгаа юм.

Гэтэл хэтэрхий том группүүд нь өөрсдөдөө зориулсан хуулийг батлаад, тэр НӨАТ-аас нь чөлөөлөгдөөд яваад байгаа. Эсвэл бүр бичлүүдийг нь бид энэ бичил жижиг компаниуд юм чинь гээд бас хуулийн дэмжлэг гаргаад өгнө.

Гэтэл өнөөдөр манай нийгэмд хамгийн их дэмжих ёстой нөгөө дундаж орлоготой иргэдээ, дундаж хүмүүсийг дэмжих бодлого нь ерөөсөө гээгдээд байгаа юм байна гэж хараад байна.

Тийм учраас бид ер нь энэ НӨАТ-ынхаа бодлогыг яаж шударга болгох юм бэ? Энэ өөрөө тодорхой байх ёстой. НӨАТ-ын буцаан олголт гэж ярихаасаа илүүтэй ер нь энэ НӨАТ-ыг анхнаас нь 5 хувь болгож сууриар нь багасгах ёстой гэдэг дээр нь илүү анхаарах ёстой юм шиг миний хувьд санагдаад байгаа юм.

Тэгээд энэ дээр хууль санаачлагчийн байр суурийг асууя.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Манай С.Цэнгүүн гишүүн бол яг зөв байр суурийг илэрхийлж байна. Тийм.

Ажлын хэсэг дээр бид 400 саяын босгыг шаардлагагүй юм байна. Үүнийг хэвээр нь үлдээе гэдэг санал хураалт ажлын хэсгээс гарсан. Харамсалтай нь Байнгын хороон дээр дэмжигдээгүй. Тэгээд 400 саяын босготой байхаар Байнгын хороон дээр дэмжигдсэн байгаа.

400 саяын босго нэмэгдсэнээр нийтдээ 23 мянган аж ахуйн нэгж НӨАТ төлөгч байхаа болино гэсэн үг.

Өнөөдрийн байдлаар НӨАТ-ын хамрагдалт нийтдээ 75 хувийн хамрагдалттай байгаа. 400 саяын босго тавигдсанаар 68 хувь руу бууж ирнэ.

Тэгэхдээ яах вэ бид бас энэ дээр нэг гүйцээн боловсруулах чиглэл авч байгаад НӨАТ-ын босготой холбоотойгоор буцааж компаниудад нь олгох байдлаар ерөнхийдөө гүйцээн боловсруулах чиглэл авдаг юм уу гэсэн бодолтой байгаа юм. Өнөөдөр санал хураалт дээр энэ асуудлыг шийднэ.

Бид 400 саяын босго ямар тохиолдолд ажиллах вэ гэхээр өмнө бидний баталсан байсан буцаалт байгаа тохиолдолд энэ 400 саяын босго ажиллах юм байна, асуудалгүй байх юм байна гэж үзэж байсан.

Тэгээд нөгөө буцаалт олгодог хуулиа бид чинь хүчингүй болгосон болохоор энэ 400 саяын босготой холбоотой бид арай нэг жоохон өөрөөр гүйцээн босгуулах, өөрчлөн найруулах шаардлагатай юм гэж харж байгаа.

Дэлхий даяар нийтдээ OECD-ийн НӨАТ-ын системтэй 175 орон байдаг юм байна. Энэ дээр яг манайхтай адилхан. Ер нь манайхаас доош НӨАТ-ын татвартай 6-хан орон байгаа.

Манай 10 хувь гэдэг маань үндсэндээ доогуур түвшинд орж байгаа. Доогуур түвшинд ордог.

НӨАТ-ын систем яагаад байх ёстой гэдгийг Та маш сайн мэдэж байгаа байх. Энэ нь иргэд, аж ахуйн нэгжүүд, улс оронд маш нөлөөтэй байдаг. Чухал байдаг.

▪ Хэн ямар орлоготой байгааг мэдэхгүй тохиолдолд –

- Халамжийн бодлого буруу явдаг.
- Татварын бодлого буруу явдаг.

Сүүлийн үед OECD-ийн орнууд “**progressive VAT**”² (прогрессив НӨАТ буюу value-added tax) гэж ерөнхийдөө нэлээн түгээмэл болж байгаа. Тэр нь орлогоос нь хамаараад, эсвэл худалдан авалтын хэмжээнээс нь хамаараад буцаалт хийх нөхцөл байдаг.

Тэгэхдээ тэр хуулийг бид өнгөрсөн жил баталсан байсан. Тэгэхдээ сая хүчингүй боллоо шүү дээ. Ер нь хэсэгчилж НӨАТ-ын хуулийг тэгж оролдож болохгүй байгаа юм.

Хэрвээ оролдохоор бол яг НӨАТ-ын хуулиа бүхлээр нь харж байгаад цогцоор нь оруулж ирэхгүй бол аль нэг хэсгийг нь аваад хаячихаар НӨАТ-ын хууль нь өөрөө үйлчлэх, нөгөө шударга байх асуудал нь байхгүй болчихоод байдаг.

Одоо яг өнөөдөр 400 сая ч байдаг юм уу, гудамжинд үндсэндээ НӨАТ-тай бараа, НӨАТ-гүй бараа гэдэг юм чинь үндсэндээ түгээмэл болоод байна шүү дээ.

² **Progressive VAT** [value-added tax] гэдэг нь бараа, үйлчилгээний НӨАТ-ын хувь хэмжээг хэрэглээний төрлөөс хамааруулан шаталсан байдлаар тогтоож, суурь хэрэгцээнд бага (эсвэл 0%), тансаг хэрэглээнд өндөр татвар ногдуулдаг нэмэгдсэн өртгийн албан татварын систем.

НӨАТ-гүй авах юм бол 5 хувь хөнгөлөөд өгье, НӨАТ-аа авах юм бол баримтыг нь өгье гэдэг ийм л асуудал зах зээл дээр бүрэн бий болоод байгаа юм.

Тэгэхээр бид уг нь яг гар дээрээс зарж байгаа барааг бүгдийг нь та мөнгийг нь банкны дансаар шилжүүлж байвал шууд НӨАТ-тай үнэ юм гэдгээр тогтоод явчихвал эргээгээд нөгөө хөдөө аж ахуйн салбар, нөгөө мал аж ахуйн хүмүүсийг хүндрэлдээ оруулахгүйгээр.

Нөгөө талдаа аж ахуйн нэгжүүдээ тэр бүх худалдан авалтаа НӨАТ-тай гээд бүртгээд эхлэхээр аж ахуйн нэгжүүдээ нөгөө бүтээгдэхүүний өртөг гэдэг нь... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулах уу?

С.Цэнгүүн гишүүн тодруулъя.

С.Цэнгүүн: Одоо тэгээд бас энэ чинь компаниуд дээр компанийн бодит өсөлтийг бид ийм шаталсан татварын хэмжээ тавиад өгөхөөр чинь энэ дотор оруулах гээд тухайн компани борлуулалтын орлого нь нэмэгдээд ирэх үедээ ахиад компаниа 2 хуваагаад л бүртгүүлээд гарчихдаг.

Одоо ингээд энэ чинь манай компаниуд яг бодит санхүүгийн үнэлгээгээ тооцуулах гэхээр үнэлгээ сайтай компаниудгүй болох, нэг ийм бичил жижиг компаниуд олонтой болох ийм хуулийн эрсдэлийг бид өөрсдөө түлхэж өгөөд.

Дараа нь бид санхүүгийн зах зээлийг, хөрөнгийн зах зээлийг дэмжье гэхээр үнэлгээ сайтай компанигүй болох юм руу энэ бодлого чинь түлхээд байгаа юм шиг надад харагдаад байна л даа.

Тэгэхээр чинь яалт ч үгүй бизнес эрхлэгч нар маань аль илүү татварын боломж нь арай таатай байна тэр утгаар нь хараад л ахиад л нэг компани гаргаад л үйл ажиллагаагаа жижгэрүүлээд л, жижгэрүүлээд л явна шүү дээ.

Тэгэхээр тэрийг бид яаж тооцож байгаа юм?

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Дундуур нь сая бид 15 хувийн шатлал оруулж өглөө шүү дээ. Одоо аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 10, тэгээд дараагийн шатлал нь 25 хувь байсан байхгүй юу.

Тэгээд хэтэрхий өндөр “гар-тай” (зааг, зөрүү, завсар) байхаар эргээгээд нөгөө компаниудаа задлах асуудлууд их гардаг.

Дундуур нь 15 хувийн шатлал оруулаад ирэхээр энэ задлах процессууд багасна гэж үзэж байгаа. Яагаад гэхээр тэр дундаж болон аж ахуйн нэгжүүдийн ашгийн хэмжээ нь 6 тэрбум давангуут шууд 25 хувьтай болчхоод байсан байхгүй юу. Дундуур нь 15 хувийн шатлал ороод ирэхээр цаашдаа задрах процесс багасна гэсэн үг.

Таны тэр яг НӨАТ-тай холбоотой таны санаа зовниж байгаа асуудлыг би 100 хувь дэмжиж байгаа. Ерөөсөө л өнөөдрийн асуудал НӨАТ бүгдээрээ төлдөг байвал төлье. Төлөхгүй бол бүгдээрээ төлөхөө байя л гэдэг зарчим байхгүй юу.

Тийм учраас НӨАТ-ын хамрагдалтын 75 хувь хангалттай биш ээ. Үүнийг бүр 95 хувь руу авчрах хэрэгтэй. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Д.Пүрэвдаваа гишүүн. Алга байна. /алх цохив/

Би нэг асуулт асууя. С.Цэнгүүн гишүүний асуулттай уялдуулаад.

Тэгэхээр миний өргөн барьсан НӨАТ-ыг 5 хувь болгох хуулийн төсөл яг өнөөдрийн Засгийн газрын өргөн барьсан хуультай зэрэгцүүлээд явахад амжилт олохооргүй байгаа. Яагаад гэвэл нэгэнт энэ асуудал нь шийдэгдэж байгаа учраас Их Хурлын гишүүд бөөнөөрөө асуулт асуухаасаа татгалзаж байна гэсэн үг.

Тэгэхээр юу гэвэл энэ хууль шууд дэмжигдээд явна гэсэн үг л дээ.

Тэгэхээр миний хууль унана гэсэн үг.

Тийм учраас өөрийнхөө хуулийг хойшлуулсан байгаа.

Тэгэхээр 400 сая гэдэг асуудал гарч ирэхээр яадаг вэ гэхээр жишээ нь малчид НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй байгаа. НӨАТ төлөгч биш. Тэгэнгүүт махны үйлдвэрүүд тэд нарын махыг авахдаа НӨАТ төлснөөр тооцогддог. Гэвч малчдаасаа бичиг баримтаа бүрдүүлж авах гэж бөөн юм болдог.

Тэгэхээр 400 сая гэхээр 400 саяас дотогших аж ахуйн нэгжүүд бүгдээрээ тэр бичиг баримтыг бүрдүүлж өгөх, тэр 400 саяас дээш борлуулалттай аж ахуйн нэгжүүд бичиг баримтаа бүрдүүлэх энэ асуудал дээр чинь асар их юм гарч ирнэ.

Хоёрдугаарт нь, НӨАТ өөрөө худалдааг бүртгэх үндсэн үүрэгтэй.

Гэтэл та нар нэг хэсэг хүмүүсийн худалдааг бүртгэхгүй, тэдний орлогыг тооцох боломжгүй. Түүн үндэслээд бусад татварыг татан авах боломж нь маш хомс болно гэсэн үг. Үүгээрээ ард иргэдийг, бизнес эрхэлж байгаа хүмүүсийн дунд ялгаварлыг бий болгож байгаа.

Татвар хамгийн гол нь нэг зарчимтай байх, хүн болгонд ойлгомжтой байх энэ бүх зүйл чинь татварын хуулиуд дээр чинь бүгдээрээ байхгүй болж байгаа.

Миний өргөн барьсан НӨАТ-ын татварыг 5 хувь болгох, буцаан олголт нь 2 хувь байх. Үндсэндээ 3 хувь татвар төлөх бол 3 сектор дээр явахгүй. Өөрөөр хэлбэл –

- уул уурхай дээр байхгүй,
- архи, согтууруулах ундаан дээр байхгүй,
- тамхин дээр байхгүй.

Энэ нь тусгай зөвшөөрлөөр бизнес хийж байгаа хүмүүс.

Тийм учраас эд нараас 10 хувийн татвар авах нь зүй ёсны хэрэг гэж үзэж байгаа. Ингээд энэ гурвыгаа хасахаар үлдсэн бүх аж ахуйн нэгж, иргэд бүгдээрээ татвараа 3-хан хувь төлөх юм чинь одоо юу гэдэг юм гаалиар орж ирж байгаа бараагаа нуун дарагдуулах ямар ч шалтгаангүй болно гэсэн үг.

Энэ тохиолдолд жишээ нь Замын-Үүдээр бүх барааны 70, 80 хувь нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас ирж байгаа тэр бараа чинь бүгдээрээ яаж байна вэ гэхээр хамгийн бага үнэлгээтэй, өндөр жинтэй барилгын материал, цемент болоод бүгдээрээ орж ирдэг. Бусдаар бол одоо энэ хувцас хунар бүх зүйл нэг бүрчлэн гаалиар мэдүүлэгдэж орж ирдэггүй байхгүй юу даа.

Анхнаасаа бүртгэлгүй орж ирсэн тэр бараа, бүтээгдэхүүнүүд чинь бүгдээрээ Нарантуул дээр очдог. Нарантуулаасаа Монгол Улсын бүх өнцөг булан бүрд тараагддаг.

Энэ болгон анхнаасаа бүртгэлгүй учраас НӨАТ-гүй, НӨАТ-гүй гээд явчихдаг. Ерөөсөө НӨАТ-ын өндөр хувь чинь ард иргэдэд дарамт болоод байгаа учраас худалдаа худлаа яваад байгаа байхгүй юу даа.

Ийм үндсэн шалтгаанууд байхад та нар 400 сая болгоно. Дээрээс нь тэргүүн эгнээнд, шилдэг 100-д ордог аж ахуйн нэгжүүд чинь ихэнх нь –

- уул уурхайн компаниуд,
- банкууд байгаа.

Гэтэл банк НӨАТ төлөгч биш. Яагаад гэвэл хүүд дарамт учрах учраас.

Уул уурхайн компаниуд байна. Зүгээр л хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүнээ авдаг болохоос биш. Үндсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргадаг. НӨАТ төлдөггүй.

Ж.Цэнгүүн гишүүний хэлснээр Та нар Монгол Улсыг авч явдаг, хамгийн их ажлын байрыг бий болгодог тэр дундаж давхаргаа бүгдийг нь байхгүй болгох, бүгдийг нь ядууруулах бодлогыг явуулж байна гэсэн үг. Энэ дээр хариулт авъя.

Хассуурийн Ганхуяг гишүүн хариулья.

Х.Ганхуяг: Өмнөх парламент ч тэр, энэ парламент ч тэр маш тийм ажил хэрэгч хэдэн гишүүн байдаг юм. Би бас өмнөх Татварын хуулийн хэлэлцүүлэг дээр явж байсан. Энэ Зөвшөөрлийн хууль дээр одоо яг хамт ажиллаж, энэ энэ зөвшөөрлийн тогтолцоог, тэр олон зөвшөөрлийн тоог бууруулахад манай Б.Пүрэвдорж гишүүн маш идэвхтэй орсон. Гол санаачлагчдын нэг байсан.

Тэгээд өнөөдөр ч гэсэн НӨАТ-ын хууль дээр бас болж бүтэхгүй байгаа асуудлууд маань яг л харж байна. Тийм. Өмнө өнгөрсөн жилийн НӨАТ-ын. Ер нь бол яах вэ, яг өнөөдрийн байдлаар бид энэ жоохон жоохон юмнуудыг нь л оролдоод явна. НӨАТ-ын хуулийнхаа болохгүй асуудлуудаа бид цогцоор нь харж байгаад тэр буцаалт, тэр хөнгөлөлт, ер нь бүгдийг нь хамт оруулж ирэхгүй бол аль нэгийг нь аваад хаячихаар НӨАТ-ын хууль нь өөрөө бүртгэлийн шинж чанартай хууль болохоор утга нь алдагдчихаад байдаг.

Анх бид чинь дэмжиж байна гэж бодоод малчдыг гаргаад л, дэмжиж байна гэж бодоод л хөдөө аж ахуйн салбарыг тэндээс гаргаад л байсан чинь яасан бэ гэсэн чинь нөгөө хүнсний үйлдвэрүүд нь тэр хүмүүсээс бараа, материалыг нь авануут эргээгээд өмнөөс нь НӨАТ төлдөг болчихож байгаа юм. Тэгэнгүүт яаж байна гэхээр тэр дундын үйлдвэрлэгч нар дээр гол татварын ачаалал нь хүрээд ирдэг.

Ямар асуудал үүсэж байна гэхээр нөгөө улсууд нь импортын бараа авдаг. Тийм ээ. Иймэрхүү асуултууд үүсээд байсан.

Өмнөх татварын хууль дээр бид ямар юу оруулж ирсэн бэ гэхээр ерөөсөө л e-barimt өгчихвөл шууд НӨАТ-аар дүнг тооцъё. Мөнгийг нь тэр данс руу нь шилжүүлчихвэл шууд НӨАТ-аар дүнг нь тооцъё гээд явах юм бол тэр салбарт ажиллаж байгаа малчид байдаг юм уу, гар дээрээс худалдаа эрхэлж байдаг ч байдаг юм уу тэр хүмүүсээ дэмжээд өгнө. Нөгөө талдаа тэр худалдан авалт хийж байгаа компаниудын өртөг өсөхгүй байх боломжтой юм байна гээд ийм байдлаар хуулийн төслийг бичсэн байсан.

Тэгээд тэрийг дараа нь Сангийн сайд ярьж байгаад бид дараа нь оруулж ирэх талаар бас судалъя.

Хоёр дахь том асуудал НӨАТ-тай холбоотой асуудал бол ер нь аж ахуйн нэгжүүдийн хувьд энэ татварын өрөнд ордог асуудал байгаа. Гэрээ хийгээд л мөнгө нь орж ирээгүй байхад шууд өр үүсдэг. Тэр мөнгө учраас энэ удаа татварыг

хойшлуулах. Нөгөө татвараа сайн төлдөг компаниудаа дэмждэг болох энэ бодлого энэ хуульд бас орж ирж байгаа.

Өнөөдрийн энэ юугаар бол максимум 2 сар хугацааг нь хойшлуулж өгөх асуудал орж байгаа. Энэ дээр яах вэ, бид өнөөдөр тоог нь гаргаагүй боловч өнөөдрийн НӨАТ-аар орж ирж байгаа орлого нь 6 их наяд төгрөг байгаа байхгүй юу. Төсөвт орж ирж байгаа. Тэрний чинь дийлэнх нь тэр аж ахуйн нэгжүүд мөнгө зээлж төлдөг юм. Мөнгө зээлж.

Одоо гааль дээр юм ороод ирэнгүүт яах вэ гэхээр банкн дээр, одоо банк ч байдаг юм уу, банк бусаар ч байдаг юм уу мөнгө зээлж байгаад гаалиа төлөөд, НӨАТ-аа төлдөг байхгүй юу.

Тэгэхээр энэ 2 сарын хөнгөлөлт гэдэг маань асар олон аж ахуйн нэгжүүдийн банкны өрөөс гаргаж байгаа, банк бусын өрөөс гаргаж байгаа асар том алхам шүү.

Одоо бид хувь хүний орлогын албан татварыг бууруулж өгөөд, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бид шатлал хийж өгөөд, эргээгээд тэр татварыг нь 2 сараар хойшлуулах боломж олгосноор иргэдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байгаа юм. Аж ахуйн нэгжүүдээ жижрүүлдэг хуурамч баахан нөгөө икс тайлантай аж ахуй... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: 1 минут нэмж өгье.

Х.Ганхуяг:

- ▶ Икс тайлантай олон компани байгуулах асуудлыг багасгана гэсэн үг.
- ▶ Нэг эзэнтэй олон компани байгуулах шаардлагагүй болно гэсэн үг.

Тэгснээр эргээд санхүүгийн зах зээл дээрээс мөнгө босгох ч байдаг юм уу. Тийм ээ. Эргээд гаднын зах зээл дээр гарах боломжууд нэмэгдэнэ гэсэн үг.

Саяын тэр НӨАТ-ын татварыг хойшлуулж өгснөөр асар олон компанийг бид зээлийн өрөөс гаргаж байгаа шүү. Энэ парламент энэ гурав, дөрөвхөн өөрчлөлтийг хийснээр асар олон хүмүүсийг –

- цалингийн зээлээс,
- банк бусын зээлээс,
- банкны зээлээс –

- асар олон компанийг зээлээс чөлөөлж өгөх ийм ач холбогдолтой хууль болж байна.

Энэ хууль батлагда юм бол ирэх жилийн эдийн засгийн өсөлт хамгийн багадаа 0.2-оос 0.3 хувиар өсөх боломжтой болохоор болж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: З.Мэндсайхан сайд аа. Би нэг жишээг хэлж өгье. Малчид НӨАТ төлөгчөөр бүртгүүлээгүй.

Тийм учраас малчдаас авч байгаа махыг НӨАТ төлсөнд тооцож үйлдвэрүүд авдаг. Гэвч энэ яаж байна вэ гэхээр махны үйлдвэрүүд хэдэн арван мянган малаа уулын ам болгонд байгаа малчдаас авдаг.

Тэгээд тэд нараас буцаагаад нөгөө баримт бичгээ авах гэхээр олддоггүй, өгдөггүй. Тэгэнгүүт яаж байна вэ гэхээр буцаагаад нөгөө малчдаас авч байгаа малаа дундын зуучлагчаар дамжуулж авдаг байхгүй юу.

Тэгээд дундын зуучлагч нь татварын байгууллагатай учраа олоод ингээд явчхаж байгаа. Дахиад л шууд малчдаас авах дамжлагагүй авах энэ бүх юм чинь бүгдээрээ алга болоод малчид нь ч махаа өндөр үнээр зарж чаддаггүй, үйлдвэрүүд нь ч махаа хангалттай үнээр авч чаддаггүй ийм л болоод байгаа юм.

Энэ дээр та тэр татварын байгууллага дээрээ анхаарч тодорхой арга хэмжээ аваарай гэж хэлье. З.Мэндсайхан сайд хариулъя.

З.Мэндсайхан: Б.Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя.

Таны ярьж байгаатай санал нэг байгаа. Ер нь хөдөө аж ахуйн салбарыг бид өмнө нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөөд яг энэ салбарт оролцогч нараа дэмжиж байна гэж байсан. Эргээд энэ бол маш том хаалт болчхож байгаа юм.

Гурилын үйлдвэрүүд дээр гэхэд жишээ нь гол түүхий эд болох улаан буудай, гурилын бүтээгдэхүүний өртгийн 95 хувийг бүрдүүлдэг. НӨАТ-аас чөлөөлдөг. Гурилын үйлдвэр өөрөө тариаланчийн өмнөөс НӨАТ төлөөд явж байгаа.

Тэгэхээр энэ өөрөө системдээ болохгүй байгаа. Эцсийн хэрэглэгч нар. Ингээд нэг талд нь чөлөөлөөд өгөхөөр нөгөө талд нь үйлдвэрлэгч НӨАТ-ыг нь өмнөөс нь төлж байгаа. Үүнийг яг үнэндээ үйлдвэрлэгч биш эцсийн худалдан авагч өмнөөс нь төлж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол өөрөө энэ систем болохгүй байна гэдгийг харуулж байгаа.

Засгийн газар энэ удаад эдийн засгийн тогтворгүй үед яаралтай аж ахуйн нэгж, ажлын байрыг хадгалах чиглэлээр хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж ирсэн. Хэлэлцүүлгийн явцад яг таны ярьж байсантай санал нэг байгаа. Энэ

асуудлыг бид Татварын багц хуулийн өөрчлөлтөөр тусгаж оруулж ирэх болно. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 1976 оны төгсөгчид болон Отгонтэнгэр Их сургуулийн 2006 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Манай 3.Мэндсайхан сайд хариулж, би асууж байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг үдээс хойш нэгтгэн явуулна.

Дараагийн асуудалдаа оръё.

**Арван нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн
2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг/**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ринчиндоржийн Батболд танилцуулна.

Индэрт урьж байна.

Р.Батболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нараас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед ажлын хэсгээс аж ахуйн нэгж, байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг албан татвараас хасаж хөнгөлөх зохицуулалтыг тусгах, үүнтэй холбогдуулан төслийн нэрийг өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй 2 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг ирсэн хүмүүс нь түрүүчийнхээр байгаа.

Дээрээс нь нэмэгдээд Д.Цолмон Гаалийн ерөнхий газрын Татварын орлогын газрын дарга. Босож мэндчилээрэй.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Батын Батбаатар гишүүн. Алга байна. /алх цохив/
М.Мандхай гишүүн. Алга байна. Байна уу?

М.Мандхай гишүүн асуулт асууя.

М.Мандхай: Энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9 дэх хэсэг дээр албан татвар төлөгчийн орлого, үйл ажиллагаа хамааралгүй.

Нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой хэдэн зохицуулалтаар татварыг хөнгөлж байгаа. Тэгээд энэ дээр e-sport үндэсний шигшээ баг болон тэр тамирчдад санхүүгийн дэмжлэгийг үзүүлэх заалт орж ирж байгаа.

Тэгээд нэг зүйлийг тодруулмаар байна. Одоо хэрэгжиж байгаа 22.9 дэх хэсгийн хэрэгжилт ер нь өнөөдөр яг ямар түвшинд байгаа вэ? Энэ зохицуулалтыг ашиглаад хийгдсэн бодитой үр дүн гарсан ажил байна уу гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт, аж ахуйн нэгжийн хариуцлагын хүрээнд хөрөнгө худалдаж авч шилжүүлээд, тэгээд барилга, байгууламж барилаа гэхэд хөрөнгийн эзэмшил нь төр эзэмших үү? Нийтийн төлөө хийж байгаа нийтийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулаад тухайн тэр нийтийн төлөө хийсэн барилга, байгууламж, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт өөрөө нийтийн өмч буюу төр эзэмших үү гэдэг асуултыг би эхлээд асууя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг. Индрийн 4 дүгээр микрофоноос хариулъя.

Ч.Чимидсүрэн: М.Мандхай гишүүний асуултад хариулъя. Сангийн яам. Ч.Чимидсүрэн.

Тэгэхээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 22.9-тэй холбогдуулаад Татварын ерөнхий газрын даргын зөвлөмж гарсан байгаа.

Энэ дээр энэ асуудлыг тодорхой хэмжээнд зохицуулсан.

29.9-ийн зорилго нь тэр хөрөнгө оруулалт үндсэн хөрөнгөөр бүртгэхтэй холбоотой тэр хийсэн зохицуулалтын цаад агуулга нь компани, аж ахуйн нэгж нийгмийн хариуцлагынхаа хүрээнд бүтээн байгуулалтын ажил хийнэ гэдэг нь татварын албанд төлөх гэж байгаа татвараараа нийгмийн сайн сайхны төлөө үндсэн хөрөнгө бэлтгэгдэж байна гэсэн санаа.

Тэгэхээр өмчлөлийн хувьд төр бүртгэж авах нь бол зөв.

Одоогийн байдлаар 22.9-өөр 2025 оны тайлангийн мэдээгээр нийт 304 аж ахуйн нэгжийн 103.9 тэрбумын хөнгөлөлт эдлэх хүсэлтийг татварын албанд ирүүлсэн байна.

Б.Пүрэвдорж: М.Мандхай гишүүн тодруулъя.

М.Мандхай: Тэгэхээр одоо энэ хуулийн зохицуулалтаар. Тэгэхээр нөгөө нэг дагаж мөрддөг журмууд байгаа. Тийм ээ. Яг энэ 22.9-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой. Энэ журмууд өөрөө бодитой хэрэгжихгүй яваад байгаа.

Тэгэхээр энэ хуулийн өөрчлөлтөөр е-спортыг оруулж өгснөөр ер нь одоо бид энэ тамирчид, багийг дэмжих гэж байгаа.

Тэгээд энэ багийг, е-спортыг нь дэмжих. Одоо жишээлбэл компьютер, тоног төхөөрөмжийг нь авч өглөө. Энэ өөрөө яг тэр баг, тамирчдийн эзэмшил нь болоод баг, тамирчид тэр тухайн спортдоо амжилт гаргах боломжоор нь бүрэн хангаж өгч байгаа гэсэн үг үү? Тухайн тоног төхөөрөмж, компьютер нь тухайн компанийнх нь өөрийн өмч эзэмшил болох уу гэдгийг тодруулах гээд байгаа юм.

Одоо жишээлбэл миний мэдэж байгаа 2 аж ахуйн нэгж, байгууллага өөрийнхөө эзэмшил дээр яг энэ хуулийн дагуу барилга барьсан. Тэгээд татвар дээр маргаан үүсээд зогсчихсон яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр яг үүнийг яг тодорхой хариулаад өгөөч. Яг төрийн өмч... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Е-спорттой холбоотой асуудлууд дээр сая ажлын хэсгийн түвшинд ажиллаж байгаад томьёоллын хувьд өөрчилсөн байгаа.

Олимп, Азийн наадмын төрлийн спорт гээд явсан. Тэгэхээр е-спорт энд хамрагдахаар зохицуулагдаж байгаа.

Тэгээд е-спорттой холбоотой П.Сайнзориг гишүүний хуулийн өөрчлөлтөд орж ирэхэд тэр холбоотой тоног төхөөрөмжүүдийг нь хэлэлцэх тухай асуудал байсан нь хэлэлцэх эсэх дээр тэр нь хасагдсан байгаа гэсэн үг. Өөрөөр хэлбэл гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлнө гэсэн тэр асуудал нь дэмжигдээгүй гэсэн үг.

Тэгэхээр одоо зөвхөн төрлийнх нь асуудал нь 22.9 дээр томьёолол нь өөрчлөгдөөд орж ирж байгаа гэдгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Нэмээд тод тодорхой хариулъя.

Ч.Чимидсүрэн: Тоног төхөөрөмж нь хуулийн дагалдаж орсон НӨАТ, гаалийн татварын хууль дээр байсныг нь хэлэлцэх эсэхийг нь дэмжээгүй.

Тэгэхээр энэ асуудал чөлөөлөгдөхгүй ээ. Гаалийн татвар, НӨАТ-аас чөлөөлөгдөхгүй гэсэн үг. Е-спорттой холбоотой тоног төхөөрөмжийг оруулж ирсэн тохиолдолд гааль, НӨАТ-аас чөлөөлөгдөхгүй.

Харин тэр е-спорттой холбоотой тамирчид, тэр шигшээ баг, тэр хамтлагт олгосон санхүүгийн дэмжлэг, хандив, мөн хөрөнгө оруулалтын зориулалтаар

хийгдэх бүтээн байгуулалтын ажлууд нь 22.9-ийнхөө хуулиараа хөнгөлөгдөөд явах бололцоо нь энэ хуулиар нэгдэнэ ээ гэсэн үг.

Б.Пүрэвдорж: Д.Пүрэвдаваа гишүүн. Алга байна. /алх цохив/
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Алга байна. /алх цохив/
Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн. Алга байна. /алх цохив/

Энэ татварын асуудал чинь бизнес эрхлэгчдийн хамгийн чухал асуудал шүү. Иргэдтэй уулзаж тэдний зовлон жаргалыг сонсож Их Хурал дээр хууль санаачилж байгаа хүмүүсээс, ахалж байгаа хүмүүсээс асуулт асуух нь хамгийн чухал байдаг.

Би нэг зүйлийг тодруулж асууя. Аж ахуйн нэгжийн орлогын 1 хувиар хэрвээ спорт, өөрөөр хэлбэл олимпод ордог спорт, соёл, урлагийн болон боловсролын арга хэмжээнд зарцуулсан бол татвараас чөлөөлөх зохицуулалттай.

Тэгээд үүнийг яг ямар ямар дарааллын дагуу бичиг баримтаа бүрдүүлж чөлөөлж байгаа талаар мэдээллийг өгөөч.

Индрийн 4 дүгээр микрофон. Нэр, албан тушаалыг хэлээрэй.

Б.Цогтнаран: Татварын Ерөнхий газар. Б.Цогтнаран.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-тэй холбоотой, татварын 1 хувийн хөнгөлөлттэй холбоотой асуудал нийгмийн хариуцлагын хүрээнд бусдад хариу төлбөргүйгээр өгсөн санхүүгийн дэмжлэг, хандивын асуудлууд хамаардаг.

Өөрөөр хэлбэл спортын багт дэмжлэг үзүүлэхээр санхүүжилт өгсөн тохиолдолд тухайн баг, хандив өгсөн этгээд маань тухайн баг эсвэл хандив авч байгаа этгээдтэйгээ гэрээ байгуулдаг. Тухайн гэрээ нь өөрөө бас тодорхой шаардлагуудад нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл тухайн 22.9-д хамаарахын тулд Соёл, спорт, аялал жуулчлалын яамнаас шалгуур үзүүлэлтийг тусгайлан баталсан байгаа. Тэр шалгуурт нийцсэн байхаар гэрээнүүдээ байгуулна.

Тэгээд тухайн санхүүгийн жилдээ багтаад санхүүгийн буцалтгүй тусламж, мөнгөнүүд нь өгөгдсөн байх ёстой. Түүн дээрээ холбогдоод нөгөө е-баримтаа өгсөн байх ёстой. Санхүүгийн дэмжлэг авч байгаа этгээд маань бас тэрийгээ санхүүгийн дэмжлэг, хандив авсан гэдгээ бас давхар бүртгэх ёстой.

Тэгээд холбогдох бусад материалуудынхаа хамт жилийн эцэст 2 сарын 10-ны дотор татварын албанд материалуудаа ирүүлдэг.

Материалуудынх нь бүрдэл, шалгуурыг хангасан эсэхийг нь үзээд татварын алба тухайн чиг үүргийн яамд руу нь яамдын баталсан шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэх талаарх тодруулгыг авдаг.

Тэгээд яамд нь өөрсдөө тухайн аж ахуйн нэгж баталсан шалгуурыг нь хангаж байна уу, үгүй юу гэдэг дүгнэлт ирсний дараа татварын тайлангийн татварын алба эцэслэн баталгаажуулж авдаг. Тэр тохиолдолд тухайн аж ахуйн нэгж хөнгөлөлтөө бүрэн эдэлж дуусахаар ийм хуулийн зохицуулалттай, ийм процесс татварын албан дээр хэрэгжээд явж байгаа.

Б.Пүрэвдорж: Ихэнх багууд төрийн бус байгууллагууд дээр бүртгүүлсэн байдаг юм шүү дээ. Энэ тохиолдолд е-баримт тэр байгууллагад чинь өгөх боломжгүй. Энэ тохиолдолд яах вэ?

Б.Цогтнаран: Спортын багууд төрийн бус байгууллагаар бүртгэлтэй байгаа.

Төлбөрийн баримтыг төрийн бус байгууллага байна уу, нөгөө НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн байна уу гэдгээс үл хамаараад ер нь бүх орлого олж байгаа этгээдүүд Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасны дагуу төлбөрийн баримт олгох үүрэгтэй. Цахим төлбөрийн баримт олгох үүрэгтэй.

Тэр цахим төлбөрийн баримт маань өөрөө тухайн багт яг хэдэн төгрөгийн санхүүжилт өгсөн юм бэ, хэдэн төгрөгийн хандив өгсөн юм бэ гэдгийг нь тодорхойлох хамгийн гол баримт болдог.

Тэгэхээр заавал тэр төлбөрийн баримтыг авсан этгээд нь өгөх ёстой, үүрэгтэй. Түүгээрээ нотлох баримт болоод явдаг.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Санал хураалтыг үдээс хойш нэгтгэн явуулна.

Дараагийн асуудалд оръё.

Арван хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, анхны хэлэлцүүлэг/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг танилцуулна.

Индэрт урьж байна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26-д нэг асуудлаар хоёр ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн нэг төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу Төсвийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Нэгдсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал албан татвар төлөгчийн амьдран суух зориулалттай орон сууцаа борлуулсан орлогыг татвар ногдуулах орлогоос чөлөөлөхдөө анх удаа өмчилсөн буюу нэг удаа чөлөөлөх гэсэн агуулгаар хязгаарлалт тогтоож байгаа эсэхийг тодруулж, хүн амын орлогын албан татварын тухай бодлогоор бага, дунд орлоготой иргэн, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх зорилготой татвар ногдуулалтын хувийг тэглэж байгаа нь тухайн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлоготой нийцсэн эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар нэгдсэн хуулийн төслийг хэлэлцэх үед ажлын хэсгээс хувь хүний орлогын хооронд ногдуулах хувь хэмжээг 1 хувь болгох зохицуулалтыг 4-өөс 5 шаттай болгох буюу сарын 792 мянган төгрөг хүртэлх орлогод 0 хувиар, 792 мянган төгрөгөөс 2 сая төгрөг хүртэлх орлогод 1 хувиар албан татвар ногдуулах хувь хэмжээг нэмэх зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр өөрчлөх. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн нэр томъёог хоёрдмол утгагүй товч тодорхой илэрхийлэх нийтлэг шаардлагын хүрээнд боловсруулахтай холбоотой зарчмын зөрүүтэй 6 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн нэгдсэн хуулийн төсөлтэй холбогдуулан төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого, татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох зэрэг зарчмын зөрүүтэй 9 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт нэгтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг олонхын санал авсан аваагүй нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгдсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Х.Ганхуяг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүчийнхээрээ.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна. /алх цохив/

Зочин танилцуулъя. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр болон Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэбат: Энэ татварын өөрчлөлтөөс иргэдийн хамгийн их хүлээлттэй байгаа хууль. Олон санал яах вэ ерөнхийдөө өгсөн. Гэхдээ үндсэн зарчмыг ажлын хэсэгтэй ярилцсан. Шаталсан татварыг дэмжиж байгаа.

Яах вэ, шууд 1 хувь бүгдийг нь татвартай болгоё гээд аваад үзэхээр дэлхий дээр ер нь 4, 5-хан орон байдаг. Арабын орнууд л байдаг.

Тэгэхээр манай улс татварын ер нь яах гэж байдаг юм бэ. Татвар бол орлогыг дахин хуваарилах гол төрийн зохицуулалт.

Тийм учраас үндсэн концепцыг алдагдуулахгүй байх ёстой. 50 сая төгрөгийн цалинтай хүн 500 мянган төгрөгийн цалинтай хүн хувиар ижилхэн татвараар төлдөг ийм орон тун цөөн.

Тийм учраас бид яавал дундаж бүлгийг илүү нэмүүлэгдүүлэх вэ, татварын хөнгөлөлтүүдийг нь дэмжих вэ гэдэг энэ талаас нь би хараасай гэж бодож байгаа юм. Ялангуяа амьжиргааны баталгаажих доод түвшин өнөөдөр нэг хүнд 538 мянга орчим төгрөг байна. Нэг хүн ажил хийдэг. Ардаа 4 ам бүл тэжээдэг хүн гэхэд 2 сая 500 орчим мянган төгрөг байж тэр айл наад захынхаа хэрэгцээг хангах байгаа.

Тийм учраас зарим оронд нэг хүнд ногдох өрхийнх нь гишүүний тооноос хамаарч татвараас хөнгөлдөг байгаа. Зарим оронд хүүхдийг дэмжье гэж байгаа бол хүүхэдтэй холбоотой бараа, үйлчилгээнүүдээс ямар ч татвар авдаггүй гэх мэтчилэн.

Тэгэхээр энэ удаад –

- бага, дунд прогрессив татвараа яг яаж авч үзэв ээ?
- Эцсийн санал яаж нэгдсэн бэ?

Бид нарт магадгүй боломж, бололцоо байх юм бол энэ прогрессив татварыг цааш нь дээш нь өсгөөд явахад боломж, бололцоо байгаа. Гэхдээ өнөөдөр эргээд бодоход төлж байгаа орлогоо эргээд хуваарилахад ялангуяа хүн амын орлогын албан татвар хөдөө орон нутгийн орлогод нэлээдгүй өндөр хувь эзэлж байгаа учраас зөрүүлээд бид алс хязгаар зах нутагтай байгаа хүмүүстээ сумд орж ирж байгаа орлого, боломжийг нь хязгаарлалчих вий гэдэг болгоомжлол нэг талаас байсан.

- Үүнийг яаж шийдэх юм бэ?

Одоо ингээд хүн амын орлогын албан татварын хөнгөлөлт орж ирэхээр мэдээж орлого дутаж таарна. Энэ одоо орлогын нөхөлтийг хаанаас яаж өгөх вэ гэдгийг бол тодруулж асуумаар байна.

Би хэд хэдэн санал өгсөн юм. Тухайлбал, хүүхдийн сургалтын төлбөр гээд хүн амын орлогын албан татвар байж байгаа. 100 сая төгрөгийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг шууд татвараас хөнгөлүүлээд авдаг хүн байна. Ихэнх хүмүүс хүүхэд нь хөөрхий 5 сая төгрөгийн л сургалтын төлбөртэй байж байгаа. Эрс тэс татварын хөнгөлөлтийн ялгаатай байгаа байхгүй юу. Нөгөө шаталсан буюу тэгш шударгаар гэдэг зарчим нь алдагдсан. Магадгүй хүн болгон хүүхдээ 30 мянган доллароор гадаадад сургаад байж чадахгүй. Зээл аваад ч болсон 5 сая. Тэтгэврийн зээл хүртэл авч хүүхдүүдийнхээ сургалтын төлбөрийг төлж байгаа айлууд байгаа л даа.

Тэгэхээр цаашдаа бага, дунд орлоготой иргэддээ чиглэсэн татварынхаа саналуудыг цааш нь хэлэлцэх шаардлага байгаа. Гэхдээ өнөөдөр цаг нь биш байж магадгүй. Бидний төсөв хязгаартай учраас.

Тийм учраас миний оруулсан саналуудын заримыг нь дэмжээгүй байна лээ. Тухайлбал, -

→ хүүхдийн хадгаламжийн хүүгээс заавал татвар аваад байх хэрэг байна уу, үгүй юу гэдэг саналыг би хэлсэн юм.

Хүүхдийнхээ мөнгийг хүүхдэд нь зарцуулдаг эцэг, эхчүүд, ээжүүд хэлж байсан санал байгаа юм.

→ Мөн орон сууцын хөнгөлөлт ч гэсэн тэр.

Анх удаагаа орон сууц 5 жил амьдарсан гэдгээр орж ирсэн байна лээ. Гэхдээ зарим нь анх удаагаа боловч тэрбумын, 2 тэрбумын, 3 тэрбумын, 5 тэрбумын байшинтай айл хашаа, байшин авах хүн хоёр эрс ялгаатай шүү дээ.

Тийм учраас уг нь тэр татварын буцаалтыг 6 саяыг уг нь 15 сая болгоё гэж байсан. Үүнийгээ болих шиг боллоо. Уг нь энэ 2 хувийг анх удаагаа зөв. Гэхдээ тодорхой мөнгөн дүнгийн хязгаар тавьж өгвөл болохгүй байсан уу гэдгийг би тодруулж асууя.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг хариулна.

Х.Ганхуяг: Анх Хувь хүний орлогын татварын хуулийг тэр сум, дүүрэгтээ уядаг шалтгаан нь орон нутагт ажлын байр бий болгох, тэрийг нь дэмжүүлэх гэсэн зорилгоор уг нь уясан юм билээ. Гэхдээ зарчмын хувьд тодорхой хэмжээнд уяад, тодорхой хэмжээг нь тэр нийгмийн даатгалын сан дээр олгож байгаа татаастай уях ёстой байсан л даа.

Тэгээд түүн дээр яах вэ бодлогын алдаа байх нь байгаа. Гэхдээ бид ийм хэмжээтэй хөнгөлөлт хийснээр бараг татаастайгаа нийлээд 5.4 их наяд төгрөгийн хөнгөлөлт, татаас шаардлагатай байгаа. Бид чинь 1.8 их наяд төгрөгийг 1 хувийн шатлалтайгаар хөнгөлөлт үзүүлээд, тэгээд зөрүүлээд ирэх жилийн тэр сум, дүүрэгт олгох татаас нь бараг яг тийм хэмжээгээр татаас тавих шаардлага үүснэ.

С.Эрдэнэбат гишүүн хүүхдийн хадгаламжаас татварын холбоотой асуудал хөндсөн. Тэгэхдээ яг хүүхдийн мөнгө нь мөн эсэхийг тогтоох, яг дансанд нь байгаа мөнгө нь хүүхдийн хэсгийг нь тогтоох боломжгүй байх.

Ерөөсөө бүх мөнгөө л хүүхдийн мөнгө гэдгээр тэндээс татвар авах боломжгүй болох нөхцөл байдал бүрдэхээр байна гээд тэр санал унасан байгаа.

Орон сууц дээр анх удаагаа “нийтийн орон сууц” гэж орж ирсэн байх ёстой. “Нийтийн орон сууц” гэж уг нь санал хураасан даа.

Тэгснээрээ таны ярьж санаа зовниж байгаа өндөр үнэтэй хаус татварын хөнгөлөлтөд орно гэсэн асуудал хязгаарлагдана.

Нэг удаа нэг хүүхдийн сургалтын төлбөрийг татвараас буцааж авах, хөнгөлөлт эдлэх боломж байдаг. Түүн дээр би шударга байх болов уу гэж бодож байна. Яагаад гэхээр тэр хэмжээний хөнгөлөлт эдэлнэ гэдэг маань тэр хэмжээний татварыг төлсөн иргэн л тэр хөнгөлөлтийг эдлэх байхгүй юу.

Үндсэндээ 100 сая төгрөгийн хөнгөлөлт эдлэх гэж байгаа хүн чинь хэдэн тэрбумын татвар төлсөн л хүн байж таарах гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр хөнгөлөлтөө эдлээд яваг. Гэхдээ бид чинь шаталсан татварынхаа тогтолцоогоор өндөр орлоготой иргэн 20 хувийн хувь хүний орлогын албан татвар төлж байгаа.

Дээрээс нь нийгмийн даатглын шимтгэл орох юм бол яг нөгөө цалингаас авдаг юу бол өндөр шүү дээ. Бусад бизнесийн үйл ажиллагаанаас авч байгаа юу чинь бол хувь хүнээрээ хэрвээ орлого олж байвал 20 гаруй хувийн татвартай байгаа.

Тэгэхээр тэр 20 хувийн татвар төлсөн хүн хоёр, гуравхан зүйл дээр л хөнгөлөлт эдэлж байгаа шүү дээ.

- **Нэг нь**, орон сууц гээд 6 сая байсныг одоо ингээд 2 хувь болгож байгаа юм байна.
- **Хоёрт нь**, сургалтын төлбөр гээд нийтдээ 21 мянга 844 иргэн 15 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байдаг юм байна.

– Энэ хугацаанд.

Тэгэхээр би гадаадад эзэмшинэ үү, дотоодод эзэмшинэ үү, тэр сургалтын төлбөр дээр цөмөөрөө оролдоод хэрэггүй байх. Иргэн өөрийнхөө хүүхдээ хаана сургана уу, нэгхэн хүүхдийн асуудал байдаг. Дотоодод сургана уу, гадаадад сургана уу тэр татварынхаа хөнгөлөлт эдлээд явах нь зүйтэй гэж харж байгаа. Аль болох бид олон хүүхдийг гадагшаа явуулж сургалтад хамруулах ёстой.

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Одоогийн орж ирж байгаа төслийг бүх хүнд хамааралтай байхаар шийдэж байгаа энэ концепцыг олсон нь би зөв гэж дэмжиж байна.

2 сая хүртэл гэдэг байдлаар одоогийн төсөл явж байна гэж би ойлгосон.

792 хүртэл 0 буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй холбоотой орлогоос бүх хүнээс 0.

2019 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 240 мянга байхад нь би жил болгон тодорхой хэмжээгээр индексжүүлээд нэмээд явъя гэдэг байдлаар санал хэлж байсан боловч дэмжигдээгүй. Гэхдээ одоо яг зөв юу руугаа орж байна.

Ер нь цаашдаа бид татварынхаа хөнгөлөлтийг аажмаар дээш нь өсгөөд, цалингийнх нь хэмжээг өсгөөд явах ёстой.

Дундаж бүлгээ дэмжих гэдэг үүднээс 2 сая хүртэлх хэмжээний татвараас 1 хувь хүртэл авч байна гэдэг. Энэ зөв хувилбар. Ажлын хэсэг дундын хувилбарыг нь зөвөөр олсон байна. Энэ дээр маш олон хүмүүс хамрагдана. Яг нөгөө дундаж бүлэг буюу 5 сая ч цалинтай байсан, 3 сая ч байсан, 10 сая ч байсан бүгд хүртэх учраас би энэ саналыг дэмжиж байна гэдгийг хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Цэндийн Баатархүү асуултад асуухаас хойшлуулсан.

Отгоны Саранчулуун гишүүн. Алга байна. /алх цохив/
Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн. Алга байна. /алх цохив/
Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн. Алга байна. /алх цохив/

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуулт асууя.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд. Сая өмнөх гишүүний асуулт дээр би бас бодож сууж байлаа л даа.

Хувь хүний орлогын албан татвар ер нь манай улс тийм өндөр биш ээ. Тийм учраас ер нь үүнийг багасгаад байх хэрэггүй гэдэг юм ярьж байна. Тэгвэл нөгөө талдаа манай улсын авлигал ямар байгаад байгаа билээ? Хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлсэн төсвөө манай улс яаж зарцуулдаг билээ?

Нөгөө 182 улсаас манай улсын авлигал чинь ер нь бид 124-д жагсаад байгаа. Жил болгон 10-аар хойшлоод байгаа. Үнэхээр төлсөн татвараар нь тэр хүмүүсийн бидний дундаа хэрэглэж байгаа нийтийн тээвэр, тэгээд эрчим хүч, боловсрол гэх мэт нийт дундаа асуудлуудаа шийдээрэй гээд татварыг нь хурааж авчхаад тэр асуудлууд нь өнөөдөр гамшгийн хэмжээнд. Хүртээмжтэй биш. Эрүүл, аюулгүй орчинд амьдрах бололцоог нь бид бүрдүүлээгүй байж нөгөө хүмүүсээс олон улсын жишигт байдаг татвараа та нар төлөх ёстой юм гээд байгаа учраас иргэд маань энд цөхрөөд байгаа юм.

Үнэхээр биднээс авсан татвараараа тэр улс нь, төрийн хийх ёстой ажлуудаа хийж чаддаг байсан бол энд иргэд гомдоллоод, энд иргэд бухимдаад байхгүй.

Гэтэл тэр үүрэгт ажлуудаа бид өнөөдөр хийж чадахгүй юм байж буцаагаад үгүй ээ бид олон улсын жишгээр татвараа авна гээд байгаа чинь шударга бус байдал үүсгээд байгаа юм.

Тэгээд бид амьдралаа авч яваад хичээл зүтгэл гаргаж байгаа иргэдийгээ ерөөсөө дэмжих бодлого явуулахгүйгээр та нар дундаж давхарга, та нар ажлаа хийгээд болж байгаа юм бол Та нар илүү төлдөг байх хэрэгтэй шүү дээ. Илүү бололцоогүй хүмүүс рүүгээ бид чиглэх ёстой гээд өнгөрсөн 30 жил энэ бодлогоо хэрэгжүүлсэн.

Ингээд яваад байсан чинь үр дагаварт нь яаж байна гэхээр ид ажиллах насны залуу гэр бүлүүд, залуучууд –

- Монгол Улсдаа амьдрах бололцоо алга.
- Хөдөлмөрийг үнэлэхгүй байна.
- Хичээл зүтгэл байхгүй юм байна.
- Би энэ улсад байх юм бол гэрэл гэгээтэй байхгүй юм байна –

гээд бүх насны залуучууд Солонгос, Австрали гэх мэт чөлөөт эдийн засагтай, хөдөлмөрөө үнэлдэг, хөдөлмөрийг үнэлдэг тэр улсууд руу яваад байгаа юм.

10 жилээ төгсөж байгаа хүүхдүүд дээр Та бүхэн очоод асуугаад үзээрэй. Бүгдээрээ яаж гадагшаа явах вэ л гэдэг бодолд автсан байна. Бүр 10 жилээсээ шүү. Энэ өөрөө гамшгийн хэмжээнд ирж байгаа юм.

Бид бүхэн маань юуны төлөө Монгол Улсаа сайн сайхан болгох гээд байгаа юм бэ гэхээр чинь ирээдүй болсон залуучуудынхаа төлөө л хийх гээд байгаа юм.

Гэтэл энд улсад чинь итгэх итгэл төрөхгүй байгаа юм.

Тэгээд 1 хувь болгохоор л төсөв татраад, эндээс 2 их наядын зөрүү гараад бид ямар ч боломжгүй болно гэж яриад байгаа юм.

■ 36 их наядтай шүү дээ. Манай улсын төсөв чинь.

- Улсын төсөвт хэрэгцээгүй, иргэд хийгээч ээ гэж огт хэлээгүй маш олон зүйлүүд дээр үргүй зардлыг гаргаад байгаа.
- Зүв зүгээр байгаа бордюрыг хавчаад солиод байгаа.
- Хэн ч оролцоод ямар ч үр дүн гардаггүй хэлэлцүүлгүүдийг хэдэн 100 саяар нь хэдэн удаа улс тойроод хийгээд байгаа.

Энэ мэт зардлуудаа Та нар татаач дээ.

Тэгээд 10, 20 жил дундаж давхарга бий болох хөрс, капитал үүсэх, өмчтэй болох тэр боломжийг нь үүсгээд бид 1 хувиар нь яваад үзье л дээ. Тэгэхэд маш том өөрчлөлт гарч ирнэ. Бид залуу хүн амтай улс.

Тийм учраас хөдөлмөрөө дэмжээд өгөх юм бол энэ хүмүүс маань ямар ч тусламж, хэрэгцээ шаардлагагүйгээр аваад явна аа.

Тэгэхээр 1 хувь болгохыг ажлын хэсгийн дарга Х.Ганхуягаас хүсмээр байгаа юм. 2 сая гэдэг чамлалттай байна. Энэ тоогоо нэмээд өгөөч ээ. Яагаад гэвэл 2 сая гэдэг чинь ажилд орж байгаа, 1, 2 жил ажиллаж байгаа л хүний татвар, цалингийн хэмжээ байгаа.

Тэгэхээр чинь бид дундаж давхарга буюу хөдөлмөрийн насанд байгаа хүмүүсээ дэмжмээр байна, босгыг нэммээр байна гэдэг санал.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Тийм. Хувь хүний орлогын албан татварыг 10 хувь байсныг 15, 20 хувийн шатлалыг 2022 оны төсөв дагуулж баталсан байдаг юм.

Түүн дээр би маш их эсэргүүцсэн. Дийлээгүй л дээ. Яагаад гэхээр тэр дээшээ нэмэгдэж байгаа бол яг өнөөдрийнх шиг доод шатлалыг оруулж өгөх ёстой байсан байхгүй юу. Одоо нэг ёсондоо татварт хамрагдахгүй хэсэг нь тэд байх ёстой шүү. Түүнээс дээших нь энэ шатлалаар явна шүү гэдэг гол санаа нь.

Уг нь “прогрессив татвар” гэдэг шатлалтай байх ёстой. Гэхдээ нөгөө жижиг, дунд, бага орлоготой иргэдээ хамгаалсан тэр шатлалыг хийж өгөөгүйгээс болоод өнөөдрийн нөхцөл байдал үүссэн. Та яалт ч үгүй тэрийг зөв олж харсан байна.

Гэхдээ бид алхам алхмаар явна. Магадгүй цөмөөрөө 2 саяыгаа батлаад, хэрэгжүүлээд нэг жил, хоёр жил үзээд шаардлагатай бол тэр үед нь дахиад өргөн бариад тэрийг нь 3 сая болгодог юм уу. Тэр үед эдийн засаг нь ч гэсэн хамтдаа өсөөд явах ёстой.

Эдийн засгаа өсгөх хамгийн гол хуулиуд дээрээ цөмөөрөө хамт ажиллах хэрэгтэй. Эдийн засгаа өсгөх хууль гэхээр өнөөдөр ярьж байгаа тэр –

- ▶ Ашигт малтмалын хууль байна.
- ▶ Бизнесийн эрх чөлөөний хууль байна.

Эд нарыгаа явуулж байж нөгөөдөх нь жоохон амь ороод, эдийн засаг нь жоохон босоод өндийгөөд ирэх үед нь шатлалыг нэмэх ч байдаг юм уу. Тийм ээ. Ингээд хамтдаа би таныг явна гэж бодож байна.

Залуучууд гадагшаа гарч явж байгаа асуудал үнэхээрийн сэтгэл санаа зовниж байгаа. Гэхдээ тийм муу зүйл бол биш. Бид гадаадын хөрөнгө оруулалтыг татахгүйгээр цаашаа урагшлах ямар ч боломжгүй болоод байна шүү дээ.

Тэгэхээр иргэд маань, залуучууд маань гадагшаа явж нүд тайлъя гэж боддог. Тийм ээ. Ер нь залуудаа гадагшаа явах их сайн байдаг. Би өөрөө оюутан байхдаа гадагшаа явж байсан. Жил Солонгост хар ажил хийж байсан. Туршлагатай гэх юм уу даа. Тийм ээ.

Тэгэхээр энэ бол эргээд залуу хүмүүст аягүй сайн туршлага болдог. Юм сурдаг, ажил хийж сурдаг. Тийм ээ. Бие дааж сурдаг гэх мэтчилэн сайн зүйлсүүд байна.

Гэхдээ бид энд амьдрах боломжийг нь нэмэгдүүлж өгөх ёстой. Өнөөдөр амьдралын чанар яалт ч үгүй сайн биш байгаа шүү дээ.

- Утаа ч байдаг юм уу,
- Хөрсний бохирдол ч байдаг юм уу,
- Түгжрэл байдаг юм уу.

- ➔ Цалингаас нь хамгийг нь татварт аваад явчихдаг.
- ➔ Нийгмийн даатгалын шимтгэл гээд аваад явчихдаг.

- Эргээд тэтгэвэр тогтоож байна гээд шууд ядуурлын эгнээ рүү оруулдаг.

Өнөөдөр манайд ийм тогтолцоо байна шүү дээ. Хамтдаа цөмөөрөө өөрчлөөд явъя.

Засгийн газар тэтгэврийн бодлогоо оруулж ирэх юм байна. Татвараа ямар ч байсан эхний нэг том алхам хийлээ. Дараа нь тэтгэврийн тэр бодлого дээр нь дахиад нэг алхам хийе. Тэгээд эдийн засгаа тэлье. Үүнийг цөмөөрөө хамтдаа л хийнэ гэсэн үг. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын “Хан Монгол” сургуулийн 12^а ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Болдын Уянга гишүүн асуулт асууна.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе ээ эрхэм гишүүддээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 1 хувь гэсэн нэг ийм тоо орж ирсэн. Энэ хууль хэлэлцэх нь дэмжигдээд судлагдаад явж байна.

Миний үндсэн асуулт яг энэ 1 гэдэг тооны ар талын судалгааг асуумаар байгаа юм. Мэдээж ажлын хэсэг дээр хууль санаачлагчид танилцуулсан байх ёстой.

Улсын Их Хурлын гишүүний хувьд хүлээж авсан мэдээлэл дээр ямар ч тийм үндэслэл байгаагүй. D.parliament дээр нээлттэй байгаа. Эдийн засаг сонирхон хардаг манайхан бүгдээрээ ороод 1 хувийн ард талын тооцооллыг хайгаад үзээрэй. Байхгүй. Яагаад –

- 1.1 биш юм,
- 2 биш юм,
- 0.5 биш юм. Ямар ч судалгаа байхгүй.

Хуулийг өргөн барьсан гишүүдээс уучлалт хүсэж байгаад нэг зүйлийг хэлье.

- Батлагдвал өргөн барьсан гишүүдэд сайн.
- Батлагдахгүй бол бүр сайн гэдэг л хуулийн төсөл гэж харж байгаа.

Ингээд шалтгаанаа танилцуулъя л даа. Хувь хүний орлогын албан татварыг бууруулах юм бол авлигал багасна гээд сая миний өмнө үг хэлсэн гишүүн хэлж хэлж гарлаа.

Тэгээд яг шалтгаан нь, шаардлага нь яг юу юм?

Эдийн засгийн хүрээлэнгийн 2024 оны татварын ачааллын судалгааг харлаа. Хамгийн өндөр татварын ачаалал ярьж байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар хувиараа тооцоотойгоо байгаа.

Яагаад яг үүнийг нь барьж авахгүйгээр хувь хүний орлогын албан татвар гэж орж ирэнгүүтээ 1 хувь гээд ямар ч тийм судалгаа байхгүй тоог гаргаж ирээд өдий хүртэл явж байгаа юм бэ гэдэг дээр.

Ажлын хэсэг дээр хэрвээ танилцуулагдсан бол энэ мэдээллийг асууя.

Ингээд шатлалтай болж байгаа юм.

Хувь хүний орлогын албан татвар 0 хувь зарим нөхцөлд бий болгоно гэдгийг ойлгож байгаа юм. 0-ийг ойлгож байгаа юм.

1-ийн ар талд л яагаад 1.1 биш юм 2 биш юм 0.5 биш юм. Судалгаа байхгүй байсан учраас тодруулж асууж байгаа юм шүү.

Ингэнгүүт Засгийн газраас нь татварын орлого хөнгөлж байгаа тохиолдолд яг энэ хувь хүний орлогын албан татвар нь –

- ▶ аймаг руугаа очдог,
- ▶ нийслэл рүү очдог,
- ▶ орон нутаг руугаа хуваарилагддаг татвар –

учраас 2.7 их наяд төгрөг дутах юм байна. Үүнийг нь улсын төсвөөс хаа нэгтээгээс гаргаж ирэхээр 5.4 их наяд дутах юм байна гэхэд бид нарт 35 их наяд байгаа шүү дээ гээд байгаа юм.

Тооцоо нь байсан бол би өнөөдөр хамаг минутаа энэ дээр залруулахгүй байх байлаа.

Ингээд хууль санаачлагчийн үзэл баримтлалыг уншиж байгаа юм.

- Ядуурлыг бууруулна гэж байгаа юм. Хувь хүний орлогын албан татварын 1 хувь болгосноор ядуурлыг бууруулна.

Тэгвэл эдийн засагт бий болох мөнгөний нийлүүлэлтээсээ яаж хамгаалах юм. Яг ингээд мөнгөний нийлүүлэлт нь ихсээд эхлэхээр инфляц нь өсөөд явна.

Тэгэхээр ядуурал буурах уу. Оруулж ирж байгаа тоо болгоныхоо ар талд танилцуулга нь байсан бол хариултуудаа аваад явах ёстой байлаа л даа. Зээлийн хүү нь дагаад өсөөд эхэлнэ.

Тэгэхээр энд яг ядуурал буурах уу? Хуулийн ажлын хэсэг дээр ямар ямар хариулт бий болов оо?

Үзэл баримтлал дээр нь бас “сүүдрийн эдийн засаг хумигдана” гээд биччихсэн байгаа юм. Сүүдрийн эдийн засаг татварын хувь хэмжээтэй хамааралтай биш. Институцийн тогтолцооны асуудал гэж харж байгаа. Тийм. Ажлын хэсэг дээр ямар мэдээлэл танилцуулагдсан юм? Үүнийг нь сонсож тэмдэглэж авч үлдээд эргээд асуулт асууя.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулна.

Х.Ганхуяг: Энэ хууль батлагдвал үндсэндээ манай иргэд маань 792 мянган төгрөг хүртэлх орлого дээрээ 0 хувийн татвар төлнө.

Энэ бол иргэн бүрд хамааралтай. 0 хувийн шатлалтай холбоотойгоор нийтдээ 840.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлт буюу 840.0 тэрбум дээр төсвийн орлого буурна. Тэр хэмжээгээр орон нутгийн татаас 800 хүрэхгүй ч гэсэн ямар ч байсан татаас асуудал яригдана.

Дараагийн шат нь 792 мянгаас 2 сая төгрөг хүртэлх орлого дээрээ 1 хувийн татвар төлнө. Та одоо 3 саяын цалинтай байна уу, 5 саяын цалинтай байна уу эхний 2 сая төгрөг дээрээ 1 хувийн л татвар төлнө гэсэн үг.

Ингэснээрээ нийт цалин авч байгаа иргэдийн 55 хувь нь 1 хувийн татварын хөнгөлөлттэй л байна гэсэн үг. 1 хувийн татвартай л болно гэсэн үг.

Төсөв дээр ирэх ачааллыг бууруулах зорилгоор бид шатлалтай буюу үе шаттайгаар хэрэгжүүлэх гэж байгаа юм. Нэг ёсондоо 792 мянга дээр 0 хувийн татварыг бид 2027 оны 01 сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлнэ.

1 хувийн шатлалтай холбоотой тэр заалтыг 2028 оны 01 сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлнэ. Ингэснээрээ бид үе шаттайгаар. Энэ хоорондоо бид эдийн засгаа тэлэх асуудлуудаа ярих хэрэгтэй. Бусад шийдэх асуудлаа хамтдаа шийдээд л явна гэсэн үг.

Ингээд нийтдээ яг энэ хувь хүний орлогын татвартай холбоотойгоор 1.8 их наяд төгрөгийн татварын хөнгөлөлт бид иргэддээ өгнө гэсэн үг.

Яалт ч үгүй бид татварын тогтолцоон дотроо хэд хэдэн асуудал байдаг. Бид бага, дунд орлоготой иргэдээ хамгаалах тэр 0 хувийн буюу бага хувийн татвар авдаг шатлалыг нь хувь хүний орлогын татвар хийгээгүйгээс болоод өнөөдөр иргэд маань татварын ачаалал, татварын дарамтаас гарч чадахгүй байгаа, зээлээс зээлийн хооронд амьдардаг гэсэн асуудал үүнтэй холбоотой нь холбоотой. Тэр бол үнэн.

Тийм учраас энэ асуудал энэ шат болж орж ирж байгаа юм.

Б.Пүрэвдорж: Болдын Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Тэгээд тэгвэл ажлын хэсэг дээр 1 хувь гээд хэлэлцүүлэг хэсгийг дэмжигдэх үеэр би өөрөө байгаагүй.

Ажлын хэсэг дээр яг 1 хувь, 1-ийн тооны ард талын шалтгаан, эдийн засгийн тэр мэдрэмжийн шинжилгээ яагаад 1.1 биш, 2 биш, 0.5 биш юм бэ гэдэг нь танилцуулагдаад ажлын хэсэг дээр яригдаж байгаад энэ тоо нь өөрчлөгдөх болов уу гэтэл 1 хувь дээрээ ямар интервал тавих вэ гэдэг дээрээ л дууссан юм шиг сонсогдоод байгаа юм.

Ажлын хэсэг дээр байгаагүй хүний хувьд яг энэ 1 гэдэг тооны ар талын эдийн засгийн үр дагаврын шинжилгээ, энэ бүх тооцоолол нь үзэл баримтлал дээрээ байгаагүй.

- Танилцуулагдсан уу, үгүй юу?
- Яагаад 1 хувь дээр нь, интервал дээр нь ярьсаар байгаад дуусав аа?
- Яагаад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар биш хувь хүний орлогын татварыг авч хөндсөн юм бол оо?

→ Энэ бүх мэдээлэл нь ажлын хэсэг дээр танилцуулагдав уу?

Энэ дээрээ нэмэлт хариулт авъя.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Хувь хүний орлогын татварыг Засгийн газраас 792 мянган төгрөгийн орлого дээр 0 хувьтайгаар хуулийн төслийг өргөн барьсан.

Ж.Баярмаа нарын 32 гишүүн 1 хувийн татвартай хуулийн төслийг өргөн барьсан. 2 төслийг хоёуланг нь Улсын Их Хурал санал хураалтаараа хэлэлцэхийг дэмжсэн.

Тэгээд Улсын Их Хурал өөрөө энэ хоёр хуулийг хоёуланг нь хэлэлцье гээд шийдсэн.

Тэгээд Их Хурлын даргын захирамжаар энэ хоёр хуулийг нэгтгэх шаардлага үүссэн. Тийм учраас нэгтгэхдээ бид Засгийн газрын 0-ээс тэр 792 гэдгийг нь хэвээр үлдээгээд Ж.Баярмаа гишүүний бид төсвийн орлого болон эдийн засагт үзүүлэх сөрөг, эерэг үр дагаврыг нь харж байгаад 2 сая төгрөг гэдгийн шатлал дээр тохироод бид дараагийн шатлалын 792-оос 2 сая гэдэг дээр нь 1хувийн шатлалтай байхаар оруулж өгсөн.

Тэгээд энэ хоёр хууль санаачлагчаас хоёулангаас нь зөвшөөрөл... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Нэмж хариулъя.

Х.Ганхуяг: Тэгээд энэ хоёр хууль санаачлагчаас хоёулангаас нь зөвшөөрөл авч байж тэр агуулга дотор нэгтгэж явдаг юм. Нэгтгэж явдаг юм.

Эдийн засагт үзүүлэхэд сөрөг, эерэг үр дүнгийн талаарх мэдээллүүдийг нь би танд өгч болно. Тэгэхдээ ерөнхийдөө өнөөдөр бид энэ концепцоороо хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ-ын хуулийг баталснаар эдийн засагт 0.3 хувийн эдийн засгийн өсөлт авчирна гэсэн ийм эффект тооцоо гарсан байгаа.

Б.Пүрэвдорж: Болдын Уянга гишүүн тодруулъя.

Б.Уянга: Тийм. 1 гэдэг тооны ар талыг асуугаад байгаа шүү дээ.

Ажлын хэсэгт хуулийн төсөл боловсруулсан хүмүүс нь –

- яагаад 1 хувь юм,
- яагаад 2 биш юм,
- яагаад 0.5 биш юм,
- яагаад 1 гэсэн тоог –

өглөө босож ирэнгүүтээ санаад л оруулж ирж хуулийн төсөл бичигдэж байгаа юм бэ гэдэг нь танилцуулагдаагүй гэж ойлголоо. Эсвэл танилцуулагдсан юм уу?

Энэ дээрээ л хариулт аваад. Яг хэрвээ танилцуулагдсан бол ямар учраас 1-ийн тоог сонгосон юм? Түүндээ хариулт авъя.

Б.Пүрэвдорж: Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Саяын асуултуудыг хууль хэлэлцэх үү, хэлэлцэхгүй юу гэдэг хэлэлцүүлгийн шатад асуух ёстой байсан байх. Яагаад 1 хувь юм. Тийм ээ. Тэгээд Их Хурлын шийдсэн юман дээр би одоо тэр болохгүй гэж ярьж болохгүй.

Тэгээд хоёр хууль санаачлагч хоёулантай нь зөвшилцөж байж саяын үр дүн, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, төсөвт үзүүлэх нөлөөллүүдийг харгалзан үзэж энэ шатлал орсон байгаа.

Хууль өргөн баригдахад хуулийн хамт бүх тооцооллыг хамт өргөн баригддаг. Би тэр тооцооллыг нь танд уншаад сууж байлтай биш. Та d.parliament.mn дээр байгаа тэр тооцоонууд нь хараад тэр шаардлагатай хариултуудаа авбал сайн байна.

Ажлын хэсгээс хууль санаачлагчдын хүрээнд –

- эдийн засагт үзүүлэх нөлөө,
- хэчнээн хүнд нөлөөлөх юм,
- ямар байдлаар эдийн засагт нөлөөлөх юм,
- татаас буюу төсөвт ямар нөлөөлөл үзүүлэх юм.

Тэр тоонуудаа харж байгаад л бид нэгтгэж явдаг шүү дээ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр дэлхийн улс орнууд төр засаг нь зөв бодлого явуулж ард иргэдээ чинээлэг сайхан амьдруулдаг. Чинээлэг сайхан амьдруулсан тэр иргэдээсээ татвар авч ер нь хувь хүний орлогын албан татвараараа л татварын орлогоо бий болгож хөгжүүлдэг.

Мэдээж бусад орлогууд нэмэгдэнэ. Жишээ нь, одоо NBA-ийн тамирчид 5 жилийн хугацаатай 200 сая долларын гэрээ байгуулдаг. Цалин авдаг. Тэндээсээ шууд 50 хувийн татвар төлдөг. Ингэхээр 100 сая долларын татварын орлого төлөөд 100 сая доллар нь өөрт нь үлдэж байна гэсэн үг.

Ийм байдлаар чинээлэг иргэдээсээ илүү татвар авах замаар, бас дундаж иргэдээ олон болгох замаар энэ хувь хүний орлогын албан татвар дээрээ улс орон хөгжиж явдаг юм гэдгийг хэлье.

Монголын хувьд бага орлоготой иргэдээ дэмжих бодлого нь зөв гэдгийг хэлье.

Тэгээд энэ дээр түрүүчийн Б.Уянга гишүүний асуулт дээр нэмж хариулт Хассуурийн Ганхуяг хариулъя.

Х.Ганхуяг: Хаана ч байдаггүй 1 хувь гээд ярих шиг боллоо. 1 хувийн татвар байдаг. Хувь хүний орлогын албан татвар дээр ч байгаа. Үйл ажиллагааны орлоготой иргэн хялбаршуулан 1 хувийн татвар төлөх боломжтой байдаг.

Аж ахуйн нэгжийн орлогын татвар дээр мөн ЖДҮ бол 1 тэрбум төгрөгийн хүртэлх орлого дээрээ 1 хувийн татвар төлөх боломжтой байдаг.

Одоо 1 тэрбумыг бид аж ахуйн нэгжийн орлогын албан татвараараа 2.5 тэрбум болж нэмэгдүүлж байгаа. Нэмэгдүүлж байгаа.

Тэгэхээр бид 1 хувь гэдэг асуудал нь бизнес эрхэлдэг хувь хүн ч байдаг юм уу, бизнес эрхэлдэг аж ахуйн нэгж байдаг юм уу. Тийм ээ. 1 хувийн шатлал байдаг байхгүй юу.

Өнөөдөр бид харин цалингаасаа орлого олж байгаа иргэд ээ нэг удаа дэмжье гэж байгаа юм. Энэ бол зөв. Ер нь.

Б.Пүрэвдорж: Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууна.

О.Саранчулуун: Баярлалаа. Нэгдүгээр асуулт нь татварын давхар хөнгөлөлтийн асуудал дээр ямар шийдлийг тооцсон бэ гэдгийг асууя.

Яагаад гэвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст татварын хөнгөлөлтүүд байдаг.

Манайх ингэдэг шүү дээ. Чи тэндээсээ авсан юм чинь эндээс давхар авч болохгүй гээд хасдаг байхгүй юу. Энэ дээр ямар зохицуулалтыг тооцсон гэдэг асуудал.

Хоёрдугаарт нь, татварын дүн буурахаар хүн амын орлогын албан татвараас хамааралтай төсвийн хөрөнгө оруулалт нь буурах юм бол татварын хөнгөлөлтийн үр өгөөж нь сайн хэрэг боловч нөгөө талдаа тэр мөнгөөр санхүүждэг нийгмийн зорилтот бүлгийн төсөл, хөтөлбөрүүдийн мөнгө зардлыг яаж нөхөх вэ? Тэрийг бууруулахгүй байх, хуучнаас нь тасалдуулахгүй байх баталгааны талаар ер нь ямар тооцоолол хийсэн юм?

Түрүүн Х.Ганхуяг гишүүн хэлж байна. Тийм ээ. Бид үүний дараах нийгэм, эдийн засгийн үр нөлөөг ажлын хэсэг тооцсон байгаа гэж байна. Тэр хэсэгт нь яг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг зорилтот бүлэгт буюу улсад татвар төлдөггүй иргэдэд хүрч байгаа үйлчилгээнүүд дээр санхүүжилтийг нь бууруулахгүй ба хамгаалалт гэж юм хийсэн үү? Тэнд ямар зүйлийг төлөвлөсөн бэ? Тэгээд би бас тодруулна.

Б.Пүрэвдорж: Эхлээд зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 1991 оны төгсөгчид, мөн Сүхбаатар аймгийн Дарьганга сумын ерөнхий боловсролын сургуулийн 2001 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бид хувь хүний орлогын албан татвараар орлогыг нь, бүгдийг нь татвараас чөлөөлж байгаа.

Цалин, үйл ажиллагааны орлого болон төрлийн орлогыг хувь хүний орлогын дотроос чөлөөлж байгаа.

НӨАТ-ын тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэглээнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл ч байдаг юм уу, тоног төхөөрөмж байдаг юм уу, авто тээврийн хэсгүүд бүгдийг нь НӨАТ-аас чөлөөлдөг.

2025 оны байдлаар 2.5 сая орчим иргэн ямар нэгэн орлого олсон. Үүнээс 20 мянга нь хөгжлийн бэрхшээлтэй.

20 мянга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн орлого олсон байгаа. Бизнес болон бусад төрлийн үйл ажиллагаанаас.

Цаашдаа яах вэ гэдэг асуултыг Та асууж байна. Энэ жилийн төсөв өргөн баригдахад бид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал дээр анхаарлаа хандуулаад л явах ёстой. Яагаад гэхээр урьдчилаад төсөвтэй холбоотой асуудлыг манай татварын ажлын хэсэг шийдэх боломж байхгүй. Бид төсөвт үзүүлэх нөлөөллөө л хардаг. Эдийн засагт үзүүлэх нөлөөллөө л хардаг. Тэр тооцоонууд харж байгаа.

Б.Пүрэвдорж: О.Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Тийм тийм. Би улсын төсвийн талаар яриагүй байна.

Нөлөөллөө хардаг бол тэр нөлөөлөлд чинь миний асуугаад байгаа зорилтот бүлэгт чиглэсэн олон үйлчилгээ байгаа шүү дээ. Тэр үйлчилгээний тооцооллыг оруулсан юм уу, үгүй юу л гээд байна л даа.

Яагаад гэвэл одоо угаасаа мөнгө байхгүй байна гээд хэрэгждэггүй өчнөөн төсөл Засгийн газарт тусгасан хөтөлбөрүүд байгаа байхгүй юу. Одоо мөнгө байхгүй байна гээд хэрэгжихгүй байгаа. Одоо байхгүй байгаанууд нь дахиад яг энэ шилжилтээс болоод бүр байхгүй болох юм биш биз дээ гэдэг нэг ийм болгоомжлол байгаа учраас би асуугаад байна шүү дээ. Тийм ээ.

Хоёрдугаарт нь, Та НӨАТ дээр ярьж байна. Туслах хэрэгсэл, туслах технологийн жагсаалт гэдэг юм Монголд алга л даа.

Тэгэхээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэглэдэг энэ зүйлсүүдэд хөнгөлөлт байдаг гэж байна. Тэр жагсаалтыг татварын албанаас өгөөч.

Б.Пүрэвдорж: Татварын албанаас асууж байна. Та эхлээд хариулах уу? Х.Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Сая өнгөрсөн гурав дахь өдөр Ерөнхий сайд хэвлэл мэдээллээр тэтгэврийн бодлого болон халамжийн бодлого болон бусад юмнуудаа танилцуулсан.

Түүгээр нийтдээ 2.2 их наяд, 2.4 их наяд шахуу төгрөгийг тэр чиглэл рүү нэмж зарцуулах асуудлыг ярьсан.

Татварын хөнгөлөлтүүдийг үзүүлснээр 2.2 их наядыг бид төсвийн орлого алдах боловч яг энэ хэмжээгээр 9 сард улсын төсвийг өргөн барихдаа Засгийн газрын бүтэц болон бусад хэмнэлтийн асуудлыг Ерөнхий сайд хэвлэл мэдээллээр ярилцлагадаа өгсөн байгаа.

Тэгэхээр бид –

- тэтгэврийн багц хууль,
- нийгмийн даатгалын багц хууль,
- халамжийн хууль,
- улсын төсвийн хуулиудаа харах хэрэгтэй болно.

Миний ойлгож байгаагаар халамжийн чиглэл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэтгэврийн чиглэлээр нийтдээ 2.4 их наяд гэж санаад байна. 2.4 их наядыг нэмж зарцуулахаар... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Индрийн 4 дүгээр микрофон дээр хариулъя. Ч.Чимидсүрэн хариулаарай.

Ч.Чимисүрэн: О.Саранчулуун гишүүний асуултад хариулъя.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тусгай зориулалтын хэрэгсэл, хиймэл эд, эрхтэн тоног төхөөрөмжүүд гээд явчхаж байгаа. Тийм.

Тэгэхээр энэ ангилалдаа орж байгаа бүх төрлийнх нь тоног төхөөрөмжүүд гаалийн болон НӨАТ-ын татвараас чөлөөлөгдөх бололцоотой. Мөн нэмэгдсэн өртгийн албан татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татварууд дээр тусгайлсан хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг нарийвчлаад тооцсон байдаг.

Б.Пүрэвдорж: Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн. Алга байна. /алх цохив/

Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би асуултаа ажлын хэсгийн ахлагч болоод бас татварын байгууллагаас илүү тодруулж асууя.

Бид татварыг улсын төсвийн орлого бүрдүүлэх нэг арга хэрэгсэл гэж нийтлэгээрээ хардаг. Нөгөө талдаа амьжиргааг дэмжих маш чухал бодлого гэж бид харах ёстой. Мэдээж амьжиргааг дэмжих бодлого учраас татварыг бууруулж байна гэдэг өнцөг явах байх.

Гэхдээ бид энэ дээр нэг зүйлийг маш сайн бодох хэрэгтэй. Нэг гэр бүл нэг орлого олж байгаа хүний цаана хэчнээн хүнийг асран хамгаалж байгаа вэ? Тэр нь өөрөө тухайн өрхөд яаж энэ орлого өөрөө нөлөөлж байгаа вэ гэдэг тооцоо судалгааг бид хийж, цаашид татварын бодлогодоо асрахуйн эдийн засгийн асуудлыг агуулгаар нь бид оруулж ирмээр байна.

Өөрөөр хэлбэл 2 сая төгрөгийн орлого олж байгаа 2 хүний амьдрал хоёулаа яг адилхан гэсэн үг биш. 4 хүүхэдтэй 2 сая төгрөгийн орлого олж байгаа хүний амьдралын чанар өөр байгаа. Ганц бие хүнийх өөр байгаа.

Үүнээсээ татвараа хамаарч авдаг байх яг энэ амьдралын чанар луу чиглэсэн татварын бодлого руу бид хэзээ шилжих вэ? Би ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан. Энэ тухай ажлын хэсэг дээр яригдсан уу, хэлэлцэгдсэн үү гэдэг асуулт байна.

Үүнтэй холбоотой би юуг хэлэх гээд байна вэ гэвэл гэр бүлийг дэмжих бодлого маань татвар, санхүүгийн бодлого руу уялдахдаа сүүлийн үеийн статистик судалгааг харахаар нэг өрхийн хэмжээнд тооцвол нэг хүн 2-оос 3 хүний санхүүгийн ачааллыг үүрч байна гэж гараад байгаа. Дунджаар гэсэн үг. Тийм ээ. Ингээд харахаар –

- 2-оос 3 суралцагч байна,
- их дээд сургуулийн оюутан байна,
- өндөр настай аав ээжийгээ асарч байна,
- хөгжлийн бэрхшээлтэй хүнээ асарч байна.

Тэгэхээр энэ ачааллыг бид ерөөсөө татварын бодлогодоо огт харгалзаж үзэхгүй 30 жил боллоо гэсэн үг. Энэ асуудал дээр бид ямар бодлого манай улс орон ер нь цаашид баримталж байгаа вэ гэдэг дээр маш тодорхой хариулт хэлээд өгөөч ээ гэсэн үг.

Хувь хүний орлогын албан татварыг бууруулаад бүгд ижил 1 хувь гэдэг маань өөрөө тэгш бус байдалд яаж нөлөөлөх вэ? Нийгмийн тэгш бус байдлыг улам гааруулах энэ нөхцөл рүү аваачих юм биш биз дээ? Яг түүнтэй холбоотой хийгдсэн ямар судалгаа байна вэ гэдэг ийм хоёр дахь асуулт байна. Энэ дээр бас хариулаад өгөөрэй.

Тэгээд хүүхдээ өсгөж байгаа, өндөр настай аав, ээжийгээ харж байгаа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ асарч байгаа энэ бодлого маань, өөрөө энэ нь өөрөө тухайн улс орны хамгийн чухал нийгмийн капитал, үйлдвэрлэл, эдийн засагт оруулж байгаа том хувь нэмэр гэж бид тэр хүмүүсийг үнэлэх цаг нь болсон гэдэг байр суурьтай байгаа.

Тийм учраас миний хувьд ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан.

Тэгээд асуултад маань хариулаад өгөөрэй гэж хүсье.

Б.Пүрэвдорж: Асуултад хариулахыг бэлтгэх хооронд зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдоржийн урилгаар Дарханы Политехникумын цахилгааны техникчийн ангийн 1988 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Яг энэ хувь хүний орлогын албан татварыг хэлэлцэж байх үед хамгийн өндөр хувь хүний орлогын албан татвар төлдөг Дэлэгийн Загд-Очир гэдэг ах маань хамт явж байгаад баяр хүргэе. /алга ташив/

Хассуурийн Ганхуяг гишүүн хариулъя.

Х.Ганхуяг: Энэ удаагийн өөрчлөлтөөр хөдөлмөр эрхэлж байгаа бүх иргэдийнхээ орлогыг хамгаалах, татварын ачааллыг бууруулах хуулийн төсөл байгаа. Хувь хүний орлогын албан татвартай холбоотой.

Өнөөдрийн байдлаар сая 441 мянган хөдөлмөрийн насны хүн байхад түүнээс сая 31 мянган иргэн цалин, хөдөлмөрийн бусад орлоготой хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг. Өнөөдрийн байдлаар. Сая 31 мянга 745 хүн байна гэсэн үг.

Хувь хүний орлогын татварыг 1 хувийн шатлалыг оруулж өгөөд, дээрээс нь бид тэр НӨАТ-ын буцаалтын хууль байсан шүү дээ. НӨАТ-ын буцаалтын хууль гэдэг нь өрхийн орлогыг хамгаалах хууль байсан байхгүй юу.

Яагаад гэхээр 12 наснаас дээш бүх өрхийн гишүүд НӨАТ-гүйгээр бараа авах боломжтой байх байсан юм. Яах вэ, мэдээж хэрэг мөнгөн дүн дээр хязгаар байгаа шүү дээ. Тухайлбал, тэр чинь 500 сая гэсэн шатлалтай байсан. Хэрэв тэр байсан бол нэгдүгээрт ажил хөдөлмөр эрхэлж байгаа бүх иргэдийнхээ татварын ачааллыг нь бууруулж өгөх, нөгөө талдаа өрхийн орлогыг нь хамгаалах хамгийн бодит зүйл нь НӨАТ-ын буцаалт байсан юм. Одоо 2 хувь байгаа. Магадгүй бид энэ тал дээр илүүтэй сайн судалгаа хийж байгаад тэр шаталсан НӨАТ-ын буцаалтыг оруулах нь зүйтэй л гэж би хувь хүн, гишүүний хувьд боддог. 2 жил татварын хууль дээр ажилласан хүний хувьд. Тийм. Нэмээд гүйцээгээд хариулчих Ч.Чимидсүрэн.

Б.Пүрэвдорж: Ажлын хэсэг. Ч.Чимидсүрэн дарга 4 дүгээр микрофон.

Ч.Чимидсүрэн: Түрүүн ажлын хэсгийн ахлагч хэллээ. Энэ удаагийн Татварын хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдгээрт орлогыг нь үлдээх, татварын ачааллыг нь бууруулах чиглэлээр цөөн заалттай нэмэлт, өөрчлөлт орж байгаа. Цаашид цогц байдлаар харах шаардлагатай.

Ер нь бусад орнуудад байдаг орлогыг төвлөрүүлдэг төвлөрсөн тогтолцоотой. Тухайлбал, гаалийн татвар, татварын байгууллага дээр хураагаад байгаа татвар, тэгээд нийгмийн даатгалын шимтгэл ч гэдэг юм уу бүх орлогуудаа нэг цонхоор орж нэгтгэдэг. Мөн түүнээсээ хамаараад гарах гэж байгаа зардлууд дээр тэр хөнгөлөлт, чөлөөлөлт, халамжийн бодлогуудаа нэг доор уялдуулж цогц хэлбэрээр явж байгаа тогтолцоон дээр цаашид татварын бодлогоор харж үзэх нь зүйтэй, татварын бодлогыг цаашид илүү цогц шинэчлэл хийхэд харгалзах ёстой гэж үзэж байна. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын гишүүн Жудагийн Баярмаа хууль санаачлагчийн хувьд 3 минутаар хариулъя.

Ж.Баярмаа: Баярлалаа. Х.Баасанжаргал гишүүний асуулт ер нь энэ хуулийн үзэл баримтлал боллоо л доо. Энэ бол яах вэ, ерөнхийдөө Монгол Ардын намын үзэл баримтлал, социал демократ.

▷ **Нэгт.**Татварыг ерөөсөө ганцхан талаас нь хардаг.

→ Төсвийг санхүүжүүлэгч гэж хардаг,
→ эсвэл төсвийн зарлагыг бүрдүүлэгч гэж хардаг.

▷ **Хоёрт,** шударга ёсыг тогтооно, эсвэл нийгмийн тэгш бус байдлыг арилгах хэрэгсэл гэж бас хардаг.

▪ Энэ бол социал демократ үзэл баримтлал.

Гэтэл илүү их цалин авч байгаа хүмүүс ер нь яагаад илүү их цалин авч байгааг бодож үзсэн үү.

–Маш их хөдөлмөрлөж байгаа.
–Хуруу хумсаа хуйхлан байж шөнө дөлөөр хүртэл ажиллаж байгаа.
–Илүү боловсрол эзэмшсэн байгаа.
–Боловсрол эзэмшихдээ маш их мөнгө төлсөн байгаа.

Дээрээс нь ачаалал нь бага цалин авч байгаа хүмүүсээс их учраас илүү цалин авч байгаа шүү дээ.

Тэгээд л ерөөсөө тэд нарыг үзэхгүй юм.

Тэгээд тэр нөхдүүдийн цалингаас нь авч бага орлоготой иргэдэд өгөх ёстой л гэдэг ийм л үзэл баримтлалтай байдаг манай Монгол Ардын нам.

Тэгээд над руу маш олон мессеж ирж байгаа. Уурхайн ажилтнуудаас. Уурхайн ажилтнууд чинь 3, 4 саяын цалинтай юм байна л даа. Бид ёстой махаа

идээд бараг гэр бүлээсээ салан алдаж байж 3, 4 сая төгрөгийн цалин авч байгаа. Аагаа багтааж баян таргандаа бид ерөөсөө энд ажиллаагүй. Зарим тохиолдолд бүр үр хүүхдээсээ хэдэн сараар хол байна. Тэгээд энэ бол бидний махаа идэж олсон хөдөлмөрийн үр шим.

Гэтэл одоо энэ ерөөсөө өндөр цалинтай авч байгаа иргэд гээд л ерөөсөө биднийг тэр цалингийнх нь тоогоор хамруулаад ад үзээд байх юм. Бид тэгж цалингаасаа илүү татвар төлж тэр бага орлоготой иргэдийг халамжилмааргүй байна. Бид өөрснөө ядарч байна. Хэцүү байна. Ийм мессежүүд өдрийн хэд ирж байна.

Тэгэхээр манай Монгол Ардын нам бүх юмыг тэгшитгэх, ер нь социализмын үед тэгшитгэж ядууруулдаг байсан юм л даа. Бүгдээрээ ядуу байх ёстой гэдэг. Хуулиар –

- ➔ Өмчийг зөвшөөрдөггүй,
- ➔ Баян байхыг зөвшөөрдөггүй.
- ➔ Баячуудыг үздэггүй ийм л үзэл баримтлал л даа.

Чөлөөт зах зээлийн нийгэмд шилжээд 36 жил болж байгаа юм чинь –

- хөрөнгө, мөнгөтэй,
- илүү их сурч мэдээд,
- илүү их хөдөлмөрлөөд,
- илүү цалин авч байгаа хүмүүсийг уг нь илүү үзээд байх шаардлагагүй л байгаа юм л даа.

Тэр хүмүүсийн их олсон мөнгөнөөс нь авч бага орлоготой хүмүүст өгнө гэсэн зарчим манай Ардчилсан намын зарчим биш.

Тийм ч учраас энэ төслийг Ардчилсан намын ихэнх гишүүд гарын үсэг зурж дэмжсэн юм. Тэгэхдээ мэдээж тодорхой хэмжээнд иргэдийн бодит байдал маш хүнд байгаа.

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 53 хувь нь 2 саяас доош төгрөгийн цалинтай байна шүү дээ. 544 мянган иргэн.

Б.Пүрэвдорж: Х.Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Ж.Баярмаа гишүүн нэг зүйлийг маш буруу ойлгоод байна л даа.

Өндөр орлого авч байгаа хүмүүсээс өндөр хэмжээний татвар биш. Ерөөсөө л энэ хүмүүс хэчнээн ам бүлийг, хэчнээн хөдөлмөрийн чадваргүй иргэдийн

санхүүгийн ачааллыг үүрдэг юм бэ. Энэ нь өөрөө нийгмийн ачаалал. Үүнийгээ бид тооцож үзээд татварыг тооцдог байя гэдэг бодлого.

Өөрөөр хэлбэл 3 хүүхэдтэй ам бүл дээр энэ тооцооллыг хийгээд үзэхээр одоо амь амьжиргааны доод түвшин 650 мянга байгаа. 3 хүүхэдтэй өрх дээр хийхээр энэ тооцоолол шууд 2 сая 250 мянган төгрөг буюу энэ өрх амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой гэж гарч ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр таны хэлдгээр хэрвээ Та тооцооллоо зөв хийсэн бол 4 сая төгрөгийн орлоготой иргэн чинь өнөөдөр 1 хувийн татвар төлөх боломжтой байсан. Та нар энэ тооцооллоо буруу хийж орж ирсэн.

Тэгэхээр 3 хүүхэдтэй өрх айлын 4 сая төгрөгийн орлого, 2 сая төгрөгийн орлого гэдгийг... /минут дуусав/

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн урилгаар Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 1991 оны төгсөгчид болон Говь-Алтай аймгийн Тайшир сумын ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Үдээс өмнөх хуралдаан завсарлалаа. /алх цохив/

ЗАВСАРЛАГА

14.00 цаг болсон байна. Гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарын урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 24 дүгээр сургуулийн 9^Б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүүхэд багачууддаа Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Зуныхаа амралтаа зугаатай сайхан өнгөрүүлээрэй.

Дараагийн асуудалдаа орж байя.

**Арван гурав.Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн
2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна. /алх цохив/

Завсарлагын хугацаа дууссантай холбоотой үг хэлэхгүй.

Төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. /алх цохив/

Д.Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ. Алга байна. /алх цохив/
Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үг хэлнэ. Алга байна. /алх цохив/
Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн үг хэлнэ. Алга байна. /алх цохив/

Гишүүд үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалтууд явна. Санал хураалттай шүү. Гишүүд ээ.

14.00 цагаас санал хураалтыг зарласан. Санал хураалтдаа танхимд хүрэлцэн ирнэ үү. Бүлгүүдийн дарга нар, дэд дарга нар, хуралдаан зохион байгуулах газар, Улсын Их Хурлын гишүүдийн зөвлөх, туслахууд, Улсын Их Хурал дахь бүлгүүдийн ажлын албаныхан хуралдааны хэвийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар ажлаа хийцгээнэ үү. Гишүүд танхимдаа хүрэлцэн ирье.

Энэ хооронд гишүүддээ мэдээлэл хүргэж байя.

Бид иргэндээ нээлттэй, тэднийхээ дуу хоолойг сонсдог, ил тод, иргэдийн оролцоотой парламент болох зорилтыг дэвшүүлж байгаа.

Энэ хүрээнд чуулганы хуралдаан Монгол Улс даяар нийтэд нээлттэй ил явдаг. Парламентын суваг дээр бид дэлгэцийн доод талд QR код тавиад, QR кодоор хэлэлцэж байгаа асуудлуудын мэдээллүүдийг оруулдаг байсан бол одоо хэлэлцэж байгаа асуудал дээр QR код дээр тодорхой саналаа өгдөг болж байгаа.

Одоо харагдаж байгаа. Та бүхэн харж байгаа байх. Энэ доор харагдаж байгаа. Тийм ээ. Үүгээр иргэд, олон нийт Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа асуудал дээр шууд **real-time** бодит цагийн горимд энд хэлэлцэж байгаа асуудалтай танилцаад, саналаа өгөх бололцоотой болсон шүү. Үүнийг манай гишүүд ашиглаж болно. Иргэд, олон нийт саналаа өгч болно.

Мөн түүнчлэн парламентын албан ёсны сайт **www.parliament.mn** дээр цахим хуудсандаа нэвтрэх гишүүдийн ирцийн мэдээллийг хараад чуулганы хуралдаанд –

- ямар гишүүд оролцож байна,
- ямар гишүүд таслав,
- хэн санал хураалтдаа оролцохгүй байна,
- хэн цагтаа ирсэн,
- хэн хоцров –

гэдэг бүх мэдээллүүдэд нээлттэй дэлгэрэнгүй харагдах бололцоотой болсон байгаа.

Ирэх долоо хоногоос гишүүдийн санал хураалтын дүн бүтэн харагддаг болно.

- Өглөө ирцдээ орсон,
- хурлаа тасалсан,
- чөлөө авсан,
- өвчтэй байсан гээд нэг хэсэг.

Нөгөө талд нь ирцийн санал хураалт явуулаад –

- санал хураалтад оролцохгүй байгаа,
- иргэдийг төлөөлөх бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байгаа,
- ажлаа хийхгүй байгаа гишүүд санал хураалтад оролцоогүй байна –

гэдэг нь ирэх долоо хоногоос нээлттэй тавигддаг болно шүү гэдгийг гишүүддээ хэлье.

Ийм байдлаар парламентынхаа үйл ажиллагааг олон нийттэй ил тод, нээлттэй болгох, эргээд иргэдийнхээ оролцоотой болгох тал дээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлж эхэлсэн байгаа. Тодорхой ахиц дэвшлүүд гарч байгаа. Ирэх намрын чуулганд нэлээн сайжрах байх гэж би бодож байгаа.

Ирц бүртгэлийн санал хураалтдаа бэлдэцгээх үү? Ирц бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

- Гишүүд хурууны хээгээ уншуулж санал хураалтдаа бэлдье.
- Сайд нарыг дуудъя.
- Гишүүдийн зөвлөх туслахууд гишүүдээ чуулганы танхим руу явуулна уу.
- Хуралдаандаа оролцох нөхцөл бололцоог нь бүрдүүлж өгнө үү.
- Бүлгүүдийн ажлын алба, бүлгийн дарга, дэд дарга нар.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 1988 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Баяраа тэмдэглэж байгаа төгсөгч Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Гишүүд суудлаа эзэлцгээх үү? Засгийн газрын гишүүд суудлаа эзэлцгээе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Хурууны хээгээ уншуулж ирцдээ ороорой. 50 гаруй гишүүн байна. Ирц бүртгэлд одоогоор орсон 46 гишүүн байна шүү. Хурууны хээгээ уншуулаагүй гишүүд хурууны хээгээ уншуулж ирцдээ орно уу. Л.Мөнхбаясгалан гишүүн суудалдаа сууя. Г.Тэмүүлэн гишүүн наанаа суучхаж болно шүү дээ. Сууж болно.

Ирц бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

43 гишүүн чуулганы хуралдаанд хүрэлцэн ирээгүй байна.

Ж.Алдаржавхлан сайд, О.Алтангэрэл гишүүн, Н.Алтанхуяг гишүүн, Н.Алтаншагай гишүүн, О.Амгаланбаатар гишүүн, Б.Батбаатар гишүүн, Д.Батбаяр гишүүн, Р.Батболд сая орж ирсэн. Ж.Батсуурь гишүүн, П.Батчимэг гишүүн, Х.Булгантуяа гишүүн, А.Ганбаатар гишүүн, Д.Ганбат гишүүн, Б.Жавхлан гишүүн, Д.Жаргалсайхан гишүүн, Б.Заяабал гишүүн, Г.Лувсанжамц гишүүн, С.Лүндэг гишүүн, М.Мандхай гишүүн, Т.Мөнхсайхан гишүүн, П.Мөнхтулга гишүүн, Н.Наранбаатар гишүүн, М.Нарантуяа-Нара гишүүн, Х.Тэмүүжин гишүүн, А.Ундраа гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн, Г.Хосбаяр гишүүн, Б.Хэрлэн гишүүн, Даваагийн Цогтбаатар гишүүн, С.Цэнгүүн гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Д.Энхтүвшин гишүүн, Д.Энхтуяа гишүүн, С.Эрдэнэбат гишүүн, С.Эрдэнэболд гишүүн, Р.Эрдэнэбүрэн нарын гишүүд ажилдаа ирнэ үү? Санал хураалт болох гэж байна. Санал хураалтдаа оролцоно уу?

Сая нэр дурдсан гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ ажилд нь ирүүлнэ үү. Санал хураалт явах гээд байна.

Өглөө 14.00 цагаас санал хураалттай гэж зарласан байгаа. Одоо 14.00 цагаас санал хураалт явна. Дараа нь 17.00-гоос санал хураалт явна.

Ингээд санал хураалтаа эхэлье. Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, мөн дэмжсэн болон эсрэг байр суурьтай 2 хүртэл гишүүн үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийн талаарх саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал. Г.Хосбаяр гишүүн ирлээ. Баярлалаа.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6.1.51 дэх заалтын “гааль, татварын албаны” гэснийг “гаалийн мэдээллийн сан, татварын” гэж, мөн зүйлийн 2 дахь заалтын 18.1.13, 18.1.14 дэх заалтын “Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан,” гэснийг “Татварын асуудлаар захиргааны туслалцаа харилцан үзүүлэх тухай конвенцийг хэрэгжүүлэхэд ашиглах” гэж, мөн зүйлийн 6 дахь заалтын 76¹.3 дахь хэсгийн “тогтоож, татвар төлөгчид мэдээлнэ.” гэснийг “тогтооно.” гэж тус тус өөрчлөх.

Д.Энхтуяа гишүүндээ баярлалаа. Д.Энхтуяа гишүүн, Г.Хосбаяр гишүүдийн зөвлөх туслахуудад их баярлалаа. Гишүүдээ ажилд нь ирүүлж байна. Хариуцлагатай байна.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат, Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг. Цаашид “ажлын хэсэг” гэх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 59.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “70” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсон 56 гишүүн буюу 59.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хөххүүгийн Болормаа, Даваагийн Цогтбаатар гишүүн, Н.Алтаншагай гишүүддээ баярлалаа.

Энэ ажлын хэсэгт орж ажилласан мөртлөө хуралдаа суухгүй, ажлаа хийхгүй байгаа ажлын хэсгийн гишүүдийг бүртгэлд оруулдаг байя. Дэгийн хуульдаа.

Бусдын боломжийг урдуур нь орж ажлын хэсэгт ороод тэгээд ажлаа хийдэггүй. Нэрсийг нь гаргаж өгөөрэй. Ажлын хэсгийн гишүүдийг.

Найруулгын санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад “, тайлбар” гэж нэмж, 6 дахь заалтын 76¹.1 дэх хэсгийн “Гааль” гэснийг “Гаалийн байгууллага” гэж өөрчилж, 4 дүгээр зүйлийн “асуудлыг агуулсан” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцож, 59 гишүүн буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын 63.2 дахь хэсгийн “80” гэснийг “50” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг, Б.Жаргалан. Санал хураалт. /алх цохив/

Төсвийн байнгын хороонд дэмжээгүй санал гээд сая уншигдсан. Тэгээд дэмжээгүй саналыг дэмжье гэж дараад ажлын хэсгийн санал дэмжигдэж байна. Гишүүдийн гаргасан санал дэмжигдэхгүй байна.

94-өөс 59 буюу 62.8 хувийн санал санал дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж дэмжсэн, эсрэг байр суурьтай 2 хүртэл гишүүн үг хэлнэ. Зарчмын зөрүүтэй 7 санал байна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг. 7 саналтай.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 6 дахь заалтын “Их хэмжээний өгөгдлийг өндөр хурдтай хадгалах, автоматаар боловсруулах зориулалттай тоног төхөөрөмж, график процессор бүхий сервер, супер компьютер” гэснийг “Сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмж, график болон тусгай зориулалтын процессор бүхий тооцоолон бодох төхөөрөмж” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 22.5.23 дахь заалтын “виртуал бүсэд бүртгүүлсэн” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцож, 60 гишүүн буюу 63.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3 дахь санал хураалт. Ажлын хэсгээс Х.Ганхуяг гишүүний микрофон өгье.

Х.Ганхуяг: Дарга аа, энэ 3 дахь заалт дээр гүйцээн боловсруулах чиглэл авах шаардлагатай байна. Энэ татварын тайлагнах, төлөх хугацааг хойшлуулах бүхий зохицуулалтын санал байгаа.

Тэгээд үүнийг нөгөө бусад татварын хуулиудтай уялдуулах юмнуудтай бас нэг шалгах юм гараад байгаа юм. Дарга аа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн саналаар 3 дахь саналын томъёоллыг гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Төсвийн байнгын хороонд. /алх цохив/

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 56 буюу 59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж өөрчилж, мөн хэсгийн “6-10 тэрбум хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбумаас дээш давсан орлогод 15 хувиар,” гэснийг, мөн хэсгийн “200 сая” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан. Санал хураалт. /алх цохив/

94 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “22 дугаар зүйлийн” гэсний өмнө “20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “0-6” гэснийг “0-10” гэж, “6 тэрбум” гэснийг “10 тэрбум” гэж, “600 сая” гэснийг “1 тэрбум” гэж, “6 тэрбумаас” гэснийг “10 тэрбумаас” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал. Санал хураалт. /алх цохив/

94 гишүүнээс 59 гишүүн буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн “22.5.4 дэх” гэсний өмнө “22.1 дэх хэсгийн “20.2.7” гэснийг,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 55 гишүүн буюу 58.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргалын урилгаар Төв аймгийн ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Төгсөлтийнхөө 40 жилийн ойн баярыг тэмдэглэж байгаа нийт төгсөгчдөө Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

40 жилийн ойн баяраа сайхан тэмдэглээрэй.

Дараагийн асуудалдаа оръё.

**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл**
/Засгийн газар 2026.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо Байнгын хорооны санал хураахад бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу.

Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Нэмэгдсэн өртгийн алба албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 16^{1.5} дахь хэсгийн тайлбарын “Барааг” гэснийг “Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасан барааг” гэж өөрчилж, мөн зүйлийн 16^{1.11} дэх хэсгийн “бол тухайн албан татварын” гэсний өмнө “шийдвэр гарсан” гэж нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

94 шишүүнээс 60 гишүүн буюу 63.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг.

Х.Ганхуяг даргад микрофон өгье.

Х.Ганхуяг: Тийм. Тус асуудал Байнгын хороон дээр дэмжигдээгүй тул бусад татварын хуулиудын дэмжигдсэн саналуудтай уялдуулах шаардлагатай байгаа юм.

Тэгэхээр энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авах хэрэгтэй байгаа юм.

С.Бямбацогт: Саяын санал хураалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг Төсвийн байнгын хороо, ажлын хэсэгт өглөө. Гүйцээн боловсруулъя. /алх цохив/

2.Төслийн 2 дугаар зүйлийн “400” гэснийг “1 тэрбум” гэж, “2.5” гэснийг “1” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 59 буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.10 дахь хэсгийн “100 мянган америк доллароос” гэснийг “360 000 000 төгрөгөөс” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 63.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.
/алх цохив/

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалдаа оръё.

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**
/Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн
2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

П.Сайнзориг нарын гишүүдийн санаачилсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтуудыг явуулъя.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. Санал хураалт.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэж хурууны хээгээ уншуулна уу.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.6 дахь заалтын “олимпын төрлийн спортын холбоо,” гэснийг “олимп, тивийн наадмын төрлийн спортын холбоо,” гэж өөрчилсүгэй.”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 58 гишүүн буюу 61.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна. /алх цохив/

2. Саналын томьёоллын 1 дэх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг “ӨӨРЧЛӨЛТ” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 64 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 66.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Энэ их чухал хууль байгаа. 2024 оны 8 сард баталсан спорт, соёл урлагт зарцуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн 1 хувийн татварыг хөнгөлөх хууль. Энэ хууль хэрэгжиж эхэлсэн. Гэхдээ хэрэгжилт нь их удаашралтай байгаа юм билээ.

Манай Татварын ерөнхий газар, Сангийн яам, холбогдох байгууллагууд. Өнөөдрийн байдлаар 300 гаруй аж ахуйн нэгж 100 гаруй тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр тайлан хүргүүлсэн байгаа. Нэг ч компани хөнгөлөлтөө эдлээгүй байна лээ.

Тийм болохоор –

- спортоо дэмжих гэж байгаа,
- соёлоо дэмжих гэж байгаа,
- боловсролоо дэмжих гэж байгаа хөрөнгө оруулалтууд чинь хийгдэхгүй байна.

Энэ дээр анхаарч, нэгэнт баталсан хуулийг хэрэгжүүлэх тал дээр Засгийн газар, тэр дундаа Сангийн яам, Татварын ерөнхий газар онцгой анхаарч ажиллана шүү. Тодорхой үр дүн гаргана шүү. Тэгэхгүй тэгээд аж ахуйн нэгжүүд тодорхой дэмжлэг үзүүлээд, төрийн ачааг нуруун дээрээ үүрээд байхад бид ийм

байдлаар хандаж болохгүй. Спортын салбарынхантай уулзсан. Бүгдээрээ л энэ асуудлыг ярьж байна лээ. Энд онцгой анхаарах ёстой шүү гэдгийг хэлье.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хувь хүний орлогын албан татварын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
/Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын
32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл,
анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцүүлэг үргэлжлүүлнэ.

Байнгын хороо санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй гишүүд үг хэлж болно.

Зарчмын зөрүүтэй 15 санал байна. Гишүүд санал хураалтдаа илтгээ.

Саяын хуулийг санаачилсан манай 2 гишүүн хоёулаа алга байх юм. Б.Бат-Эрдэнэ гишүүн, П.Сайнзориг гишүүн. Хууль санаачилчхаад хуралдаа суугаад хуулиа дэмжиж явуулмаар байх юм.

Л.Энх-Амгалан сайд сууна уу, ажлаа хийнэ үү. Ерөнхийлөгч боловсролын салбартай уулзаж байгаа. Уулзалтад орж үг хэлэх юм байна. 5 минутын чөлөө авч байна.

Зочин танилцуулъя. Үндэсний батлан хамгаалах их сургуулийн харьяа ерөнхий боловсролын “Тэмүүжин-Өрлөг” сургуулийн 12^б ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сургуулиа амжилттай төгсөж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Гоё харагдаж байна шүү, хүүхдүүд ээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан аялал жуулчлалын бус орон сууцаа борлуулж олсон орлого”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Жавхлан, Д.Энхтүвшин. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 94 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 62.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн албан татвар ногдуулах орлогод доор дурдсан хувиар албан татвар ногдуулна:

21.1.1.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 11 049 600 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 20 049 600 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар;

21.1.2.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-24 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 1 хувиар, 24 000 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 144 960 төгрөг дээр 24 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 9 744 960 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 18 744 960 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар.

21.2.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Р.Батболд, Э.Болормаа, П.Ганзориг, Б.Жавхлан, Ц.Мөнхбат,

Б.Пунсалмаа, Л.Соронзонболд, Р.Сэддорж, Г.Тэмүүлэн, Г.Хосбаяр, Д.Энхтүвшин, М.Энхцэцэг. Цаашид “Ажлын хэсэг” гэх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 62 гишүүн буюу 65.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 21.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

95-аас 59 гишүүн буюу 62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “25 дугаар зүйлийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж,” гэснийг, мөн зүйлийн “26.1.1,” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж” гэснийг “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 63.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.14 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

95 гишүүнээс 62 гишүүн буюу 65.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Төслийн 5 дугаар зүйлийн “23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг,” гэснийг хасах.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

95-аас 62 гишүүн буюу 65.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төсвийн байнгын хороонд дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат. Санал хураалт. /алх цохив/

95 гишүүнээс 55 гишүүн буюу 57.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“15.6.Татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ногдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж болно.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал. Санал хураалт. /алх цохив/

95 гишүүнээс 53 гишүүн буюу 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж,” гэснийг “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж,” гэж өөрчлөх.

Санал гаргасан Их хурлын гишүүн Б.Заяабал. Санал хураалт. /алх цохив/

95 гишүүнээс 52 гишүүн буюу 54.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4 дэх санал, 5 дахь саналуудыг санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа саналаа татах уу? Микрофонд хэлэх үү? А.Ариунзаяа гишүүний микрофон.

А.Ариунзаяа: Шаталсан татвар нэвтрүүлэх санал гаргасан ажлын хэсгийн хүрээнд шийдэгдсэн учраас дараах 4 болон 5 дугаар саналуудаа татъя.

С.Бямбацогт: 4, 5 дугаар саналыг татлаа. /алх цохив/

6 дахь саналыг санал гаргасан С.Эрдэнэбат гишүүн микрофон өгье. С.Эрдэнэбат гишүүний микрофон.

С.Эрдэнэбат: Хуулийн шаталсан татварын асуудала ажлын хэсэг дээр санал гаргасан гишүүд хоорондоо ярилцаад түрүүний дэмжигдсэн саналыг олонхоороо дэмжээд явж байгаа учраас энэ саналаа татаж авч байна.

С.Бямбацогт: 6 дахь санал гаргасан С.Эрдэнэбат гишүүн саналаа татлаа.
/алх цохив/

7.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 15 дүгээр зүйлд заасан тухайн жилийн орлогод 5 хувиар тооцон албан татвар ногдуулна.

21.1.1.Татвар төлөгчийн асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тооноос хамааран дараах хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

21.1.1.а.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо нэг бол 4 хувь

21.1.1.б.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо хоёр бол 3 хувь

21.1.1.в.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо гурав бол 2 хувь

21.1.1.г.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо дөрөв бол 1 хувь

21.2.Асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүнд арван найман нас хүрээгүй хүүхэд, өдрийн ангид суралцаж байгаа хорин дөрвөн нас хүртэлх хүүхэд, тэжээн тэтгэж буй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийг хамруулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал. Санал хураалт.
/алх цохив/

95 гишүүнээс 52 гишүүн буюу 54.7 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогод доор дурдсан хувь хэмжээгээр албан татвар ногдуулна:

21.1.1.2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 12 дугаар сарын 31- ний өдрийг дуустал 5 хувиар

21.1.2.2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1 хувиар”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар. Санал хураалт. /алх цохив/

95 гишүүнээс 53 гишүүн буюу 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.14 дахь хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсгийн “23.1-д зааснаас бусад” гэснийг”, 5 дугаар зүйлийн “23 дугаар зүйлийн 23.1, 23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг, 28 дугаар зүйлийн 28.1.2-ыг” гэснийг тус тус хасах.

Санал гаргасан Улсын Их хурлын гишүүн М.Мандхай.

Санал хураалтад 95 гишүүн оролцсоноос 53 гишүүний 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. /алх цохив/

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Санал хураалт дуусаагүй байгаа шүү гишүүд ээ. Газрын тосныхоо хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл. Гишүүд ээ. Сууж байгаарай. Санал хураалт. Ж.Энхбаяр сайд.

Санал хураалт байгаа шүү. Ганцхан санал хураалт.

**Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд**
/Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд нарын 13 гишүүн
2026.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Гишүүд хуруугаа уншуулаарай. Э.Бат-Амгалан сайд суучих уу? Д.Батлут сайд суучих уу? Гишүүд хурууны хээг уншуулна уу? Х.Баасанжаргал гишүүн гишүүн ээ, суугаарай. Ц.Баатархүү гишүүн ээ. Санал хураалт.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

95 гишүүнээс 61 гишүүн буюу 64.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн 4 хуулийн төсөл байгаа. 4 санал хураалт.

2.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

95 гишүүнээс 58 гишүүн буюу 61.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

95 гишүүнээс 53 гишүүн буюу 55.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

95 гишүүнээс 59 гишүүн буюу 62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

Санал хураалтад 95 гишүүнээс 50 гишүүн буюу 52.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Газрын тосны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудалд оръё.

**Арван дөрөв. Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2026.04.20-ны өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг/**

Улсын нисэхийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Хажекберийн Жангабыл танилцуулна.

Энэ санал хураалт байхгүй. Зарчмын зөрүүтэй санал байхгүй байгаа шүү.

Х.Жангабыл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй бололцсонд тооцох тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийг баримтлан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн болно.

Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналыг Улсын нисэхийн тухай шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд тусган тэдгээрийн үзэл баримтлал, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр зүйл, хэсэг, заалтыг уялдуулан дэс дараалал, бүтцэд өөрчлөлт оруулах, нэр, томъёог,

жигдлэх үг, өгүүлбэр, хэллэгийг монгол хэлний дүрэмд нийцүүлэхтэй холбоотой зохих засвар өөрчлөлтийг хийсэн эцсийн хувилбарыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улсын нисэхийн тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын нисэхийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийг танилцуулъя.

Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Дагвадоржийн Ганхуяг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга хошууч, генерал, Эрхэмбаярын Гансүх тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Гомбосүрэнгийн Энхболд тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч, хуулийн зөвлөх, Сайнболдын Билигтборзаяа тус яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Улсын нисэхийн хэлтсийн шинжээч, хошууч, Сүнрэвийн Ганбямба Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, дэслэгч генерал, Бямбасүрэнгийн Мөнх-Ирээдүй Зэвсэгт хүчний агаарын цэргийн командлагч, бригадын генерал, Бумцэндийн Мөнхбат Зэвсэгт хүчний Жанжин штабын Хуулийн хэлтсийн дарга, хошууч.

Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандах, үнэн зөв, бодитой мэдээлэл өгөхийг сануулъя.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Батлан хамгаалах яамны харьяа Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын алба хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе. /алга ташив/

Гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу үг хэлнэ.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн. Тасаллаа. /алх цохив/

Засгийн яаралтай хуулиар санал хураана шүү дээ. Нийгмийн даатгал. Нэрээ. Тэр хаана явна.

Б.Пүрэвдорж үгээ хэлье.

Б.Пүрэвдорж: Би энэ хуулийн нөгөө хэлэлцүүлэг дээр нь байж амжаагүй.

Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал гэж байгаа. Энэ ангилал дээр 14.1.4 дээр “захиалгат нислэг хийнэ” гэж байгаа юм.

Өнөөдөр жишээ нь улсын батлан хамгаалах салбарт жижиг оврын онгоц, мөн түүнчлэн нисдэг тэрэг үйлчилгээ үзүүлдэг.

Тэгэхээр Монгол Улсад нисдэг тэрэг болон жижиг оврын агаарын хөлгүүд, ялангуяа жижиг, дунд бизнесүүд энэ нисдэг тэргийг, мөн түүнчлэн жижиг оврын агаарын хөлгийг хувийн салбарт хөгжүүлэх боломж нь нэмэгдэж байгаа. Маш олон бизнесүүд жижиг оврын нисдэг тэрэгтэй болсон. Үүгээрээ тодорхой хэмжээний өөрсдийнхөө хэрэгцээнд ашиглахын зэрэгцээгээр тодорхой хэмжээгээр төлбөрт нислэгүүд үйлддэг.

Гэвч хуульд энэ заалт орсноор төсвийн хөрөнгөөр төрийн томоохон байгууллагууд, ялангуяа онцгой чиг үүрэг, батлан хамгаалах чиг үүрэг болон энэ салбарт байгаа төрийн өмчийн байгууллагууд захиалгат нислэг хийгээд эхлэх юм бол энэ хувийн салбар чинь хөгжих боломжгүй болж эхлэх юм.

Тийм учраас эцсийн хэлэлцүүлэг дээр бас тодорхой хэмжээгээр энэ захиалгат нислэг гэдэгтээ яг энэ хувийн хэвшлийн хийх ёстой тэр салбар луу орохгүй байх талаар анхаарал тавьж, найруулга дээр тодорхой өөрчлөлтүүдийг хиймээр байна.

Аль эсвэл хийх боломжгүй гэж үзэх юм бол энэ протоколд тусгагдсаны дагуу төрийн өмчийн төсвийн байгууллагууд энэ захиалгат нислэгээрээ хувийн салбар луу хэт халдсан захиалгат нислэгийг хийж, чөлөөт зах зээлийн өрсөлдөөнийг байхгүй болгох шаардлага байхгүй шүү гэдгийг хэлж протоколд үлдээмээр байна.

Тэгээд дээрээс нь яг энэ “захиалгат нислэг” гэдэг нь ямар нислэг юм бэ гэдгийг өнөөдөр хууль оруулж ирсэн хүмүүсээс асууж тодруулмаар байна. Энэ дээр хариулт авъя.

С.Бямбацогт: Асуух дэг байхгүй. Бизнесийг хааж болохгүй. Тийм.

Төрийн өмчийн авиа компанийн нисэх онгоц, нисдэг тэргээр хувийн хэвшлийн бизнесийг хааж болохгүй шүү. Үүнийг чиглэл болгож хэллээ шүү. Сая гишүүд хэлсэн. Үг хэлж дууссан. Хариулт авсан.

Улсын нисэхийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлээ. /алх цохив/

Гишүүд ээ, одоо хоёрхон санал хураалттай. Тэгэх юм бол 17.00 цагаас санал хураалт явахгүй. Одоо шууд дуусах гээд байна. Гадуур байгаа гишүүдээ дуудаарай. Хоёр асуудал хэлэлцээд санал хураалт явна. Үг, асуулт, санал хураалт байхгүй.

Яаралтай горимын нэг асуудал байгаа. Нөгөө Нийгмийн даатгалын хууль. Тэтгэвэртэй холбоотой асуудал. Нөгөөдөх нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой санал хураалт байгаа.

Гишүүдийг санал хураалтдаа хүрэлцэн ирэхийг урья. 17.00 цагийн санал хураалт байхгүй. Улсын Их Хурлын тухай хуулиуд ирэх долоо хоногт хойшилсон учраас 16.00 цагийн орчим чуулган завсарлах гээд байна шүү. Гишүүд ээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Арван тав.Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Нанзадын Наранбаатар танилцуулна.

Индэрт урьж байна.

Гишүүд сууж байгаарай. Энд үг, асуулт байхгүй шүү. Ж.Батжаргал дарга аа. Асуулт, үг байхгүй. Бусад гишүүд сууж байгаарай. Одоо шууд санал хураалтууд руу орно шүү.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүнээс 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган, төслийн хэл зүйн найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Үүнийг түр хойшлуулаад. Санал хураалтаа түрүүлээд явъя. Энд санал хураалтгүй учраас асуулт, үгийг нь дараа явъя.

Тийм болохоор гишүүд танхимдаа цуглана уу. 2 санал хураалттай байгаа юм. Яаралтай горимоор орж ирсэн ахмадуудын тэтгэвэртэй холбоотой нэг асуудал байна. Шууд санал хураалт. Дараа нь Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах холбоотой нэг асуудал байгаа.

Дараагийн асуудалд оръё.

**Арван зургаа.Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах
саналын тухай**

Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг хэлэлцэнэ.

Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар танилцуулна.

Индэрт урьж байна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж байгаарай. Орж ирээрэй.

Да.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 88 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар танилцуулсан бөгөөд уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх хэсэгт заасан заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж байгаа талаар Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах тухай Улсын Их Хурлын гишүүний саналыг хэлэлцсэн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Да.Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Дарааллын дагуу асуулт асууж үг, хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. Гишүүд ээ, суудалдаа суугаад санал хураалтдаа бэлдэцгээе. Өрөө рүүгээ явсан гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Хоёрхон санал хураалт. Тэгээд чуулган завсарлана. Гишүүд ээ, санал хураалтдаа бэлдье. Тэнд гишүүд яагаад бөөгнөрөөд байна. Юу хуваагаад байна.

Т.Аубакир сайд аа, наад гишүүдээ тараагаад суулгана уу, Та. Юу тараагаад байна. Сайд нар, гишүүд суудалдаа сууцгаана уу. Т.Аубакир сайд суудалдаа суугаач. Ж.Баярмаа гишүүн суудалдаа сууна уу.

Хөдөө аж ахуй дээр санал хураалт байхгүй. Энэ төсвийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал байгаа. Да.Цогтбаатар гишүүн мэдэж байгаа. Гишүүд суудалдаа сууцгаана уу. Да.Цогтбаатар гишүүн үг хэлье. Үгүй юм уу. Хэлсэн. Тийм. Гишүүд ээ сууна уу. Сайд нар орж байя. Санал хураалтдаа бэлдье.

Ирц бүртгэлийн санал хураалт. Сургуулийн хүүхдүүд ороод ирсэн байна шүү. Ирцийн санал хураалт явуулъя даа. Ирц бүртгэлийн санал хураалт. /алх цохив/

Ирц бүртгэлийн санал хураалтад 52 гишүүн алга байна. Ж.Алдаржавхлан сайд хууль санаачилсан. Одоо хууль нь хэлэлцэгдэнэ. Хуралдаандаа хүрэлцэн ирнэ үү. О.Алтангэрэл гишүүн сая байсан. Чуулганы танхимдаа хүрэлцэн ирнэ үү. Норовын Алтанхуяг гишүүн. О.Амгаланбаатар гишүүн дотор байгаа мөртлөө ирцдээ ороогүй байна. Цэндийн Баатархүү гишүүн, Э.Бат-Амгалан сайд байгаа мөртлөө ороогүй байна. Б.Батбаатар гишүүн, Д.Батбаяр гишүүн, Д.Батлут сайд хуулиа батлуулчхаад гараад явдаг юм уу. Д.Батлут сайдыг дуудаарай. Одоо Засгийн асуудал орох гэж байгаа шүү. Ж.Батсуурь гишүүн, Б.Бат-Эрдэнэ гишүүн, Ж.Баярмаа гишүүн байна, Б.Бейсен гишүүн байна, Э.Болормаа гишүүн байна. А.Ганбаатар гишүүн, Д.Ганбат гишүүн, Л.Гантөмөр гишүүн, Х.Ганхуяг гишүүн хуруугаа уншуулаарай. Б.Дэлгэрсайхан сайд, Б.Жавхлан гишүүн, Д.Жаргалсайхан гишүүн, Б.Заяабал гишүүн, С.Лүндэг гишүүн, Д.Мөнхбаатар гишүүн хуруугаа уншуулаарай. Л.Мөнхбаясгалан гишүүн, Б.Мөнхсоёл гишүүн, П.Мөнхтулга гишүүн хуруугаа уншуулаарай. Б.Мөнхсоёл гишүүн байна. М.Нарантуяа-Нара гишүүн, П.Наранбаяр гишүүн, О.Номинчимэг гишүүн, Г.Очирбат гишүүн хуруугаа уншуулаарай. Х.Тэмүүжин гишүүн, А.Ундраа гишүүн, Д.Үүрийнтуяа гишүүн, Г.Уянгахишиг гишүүн, Г.Хосбаяр гишүүн хуруугаа уншуулаарай. О.Цогтгэрэл гишүүн, С.Цэнгүүн гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Л.Энх-Амгалан гишүүн, Л.Энхнасан гишүүн, Д.Энхтүвшин гишүүн, Д.Энхтуяа гишүүн, С.Эрдэнэбат гишүүн, Р.Эрдэнэбүрэн гишүүд танхимдаа хүрэлцэн ирнэ үү.

Сая нэр дурдсан гишүүд. О.Амгаланбаатар гишүүн ээ. Одоо санал хураах гэж байна. Та сууж байгаад саналаа өгчих.

Саяын гишүүд танхимдаа хүрэлцэн ирье. Гишүүдийн зөвлөх, туслахууд гишүүдээ явуулна уу. Чуулган танхим руу.

Зочин танилцуулъя. Нийслэлийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн н.Сувд-Эрдэнэ багштай 7^в ангийн сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Сургагч хүүхэд, багачууддаа Улсын Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сурлагын өндөр амжилтыг хүсье. /алга ташив/

Зуныхаа амралтаа зугаатай сайхан өнгөрүүлээрэй.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд ээ суудалдаа сууцгаана уу. Санал хураалтдаа бэлтгэе. Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. Гишүүд ээ, суудалдаа сууна уу. Г.Уянгахишиг гишүүн ээ.

Байнгын хорооны саналаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1 дэх заалт Монгол Улсын Үндсэн хуулийн хууль дээдлэх зарчмыг зөрчсөн эсэх талаар Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 65 гишүүн буюу 66.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар олонхын дэмжлэг авсан асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргах хүсэлтийг албан бичгээр хүргүүлнэ.

Дараагийн санал хураалт.

**Арван долоо.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон
хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд
/Засгийн газар 2026.06.12-ны өдөр өргөн мэдүүлсэн,
яаралтай хэлэлцэх эсэх/**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хороонд хамаарах бол зөвлөлтэй зөвшилцөж холбогдох Байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд зарлан мэдээлнэ.

Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлснийг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хуваарилсан.

Хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд

эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хурал бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасан.

Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн.

Энэ нөгөө тэтгэврийн хууль, ахмадуудын тэтгэвэртэй холбоотой асуудал байгаа. Нэн яаралтай хэлэлцээд энэ хаврын чуулганаараа баталъя гэж Засгийн газраас яаралтай горимоор өргөн мэдүүлсэн. Тэтгэврийн нэлээн хүлээлт байгаа. Бид хэлэлцэх эсэхээ шийдэх гэж байгаа юм. Нөгөө хэлэлцүүлэгт оруулах. Яаралтай шийдэх үү, үгүй юу гэдгээ. Хэлэлцэх эсэх нь дараа нь явна. Зүгээр яаралтай хэлэлцэх үү, үгүй юу гэдгээ шийдээд түүний дараа хэлэлцэх эсэх шүү гэдгийг хэлье.

Энэ зүгээр нэн яаралтай хэлэлцэх эсэхээ шийдэх гэж байгаа юм. Тэтгэврийн хууль гээд би хэллээ шүү дээ. Сая. Тийм ээ. Тэтгэвэртэй холбоотой. Харин тийм дэг байхгүй байна. Тийм дэггүй болохоор Та бүхэн зөв ойлгоорой. Тэтгэвэртэй холбоотой асуудлаа яаралтай хэлэлцээд. Одоо яаралтай хэлэлцэх эсэхээ шийдэх юм бол ирэх долоо хоногоос хэлэлцэх эсэх асуудал нь явна. Байнгын хороогоор хэлэлцэх эсэх явна. Түүний урд талд бүлгүүдээр танилцуулна.

Одоо хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгэе. /алх цохив/

Санал хураалт. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 98 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 53.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хүний хөгжил нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Ахмадуудын тэтгэвэр нэлээн асуудал болсон байгаа. Үүнийгээ хурдан Их Хурал шийдье ээ л гэсэн хууль байгаа. Ирэх долоо хоногт намын бүлгүүд дээр танилцуулаарай, Т.Аубакир сайд аа. Гишүүдэд ойлголт өгөхгүй бол мэдээлэлгүй байна гэсэн ийм эрсдэлтэй байна шүү дээ.

Цаашдаа яаралтай хэлэлцэх гэж байгаа асуудлыг танилцуулга хийдэг болно. Их Хурлын тухай хууль батлах юм бол ийм учраас нэн яаралтай хэлэлцэх гээд байгаа юм гэдгийг танилцуулж байж гишүүд санал хураадаг болно. Сая Б.Пүрэвдорж гишүүний хэлсэн тэр горимын саналаар нөгөө үг хэлэх дэг байхгүй учраас ингээд харанхуй хураачхаж байгаа шүү. Үүнийг зөв ойлгоорой гишүүд ээ.

Д.Батлут сайд байхгүй учраас хойшлуулсан. Нисэхийг.

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай нарын 10 гишүүн
2026.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
эцсийн хэлэлцүүлэг, **үргэлжлэл**/

Дараагийн асуудал. Хөдөө аж ахуйн тухай хууль байгаа. Хөдөө аж ахуйн хуулийн төслийг М.Мандхай нарын гишүүн санаачилсан.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Н.Наранбаатар гишүүн танилцуулсан. Ажлын хэсгийг урьж байна.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ч.Лодойсамбуугийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 34 дүгээр сургуулийн 9³ дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүүхэд, багачууддаа Улсын Их Хурлынх нь нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Зуныхаа амралтаараа сайхан амраарай хүүхдүүд ээ.

Тийм ажлын хэсгийн бүрэлдэхүүн хаана байна? Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Ажлын хэсгийг Их Хуралд хүндэтгэлтэй хандаж, үнэн зөв бодитой мэдээлэл өгөхийг сануулъя.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаг гишүүд урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууна уу?

Да.Цогтбаатар: Баярлалаа. М.Мандхай гишүүний санаачилсан Хөдөө аж ахуйн хуулийн шинэчилсэн найруулгыг дэмжиж байгаа.

Тэгээд Хөдөө аж ахуйн сайд нь уг нь байж байвал их сайн байна. Улсын Их Хурлын дарга аа.

Ямар ч унших материалгүйгээр Улсын Их Хурлынхаа гишүүдээр шийдвэр гаргуулах гэж хүчинддэг боллоо. Одоо энэ Хөдөө аж ахуйн сайдтай холбоотой асуудлыг бас ярих гэхээр Хөдөө аж ахуйн сайд нь алга. Хөдөө аж ахуйн сайдтай цуг Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан хөдөө аж ахуй, газар тариалангийн чиглэлийн албаны хүмүүстэй уулзалт хийсэн. Хэлсэн үгэндээ өөрийгөө л магтаад байх юм. Манай сайд. Уг нь ажлаа хиймээр байгаа юм.

Сая бид Баянхонгор аймгийн Богд суманд очиж ажиллаад ирсэн. Богд суманд тэтгэврийн эмээ, өвөө хоёр хуучин үйлдвэрийн барилгыг авсан. Тэтгэврийн зээл аваад засаж сайжруулах гээд үзэж байна.

Манай Хөдөө аж ахуйн сайд ерөөсөө тэр чиглэлд ажиллахгүй байна. Уг нь 330 сумдаа нэг нэг жижиг үйлдвэр Баянхонгор аймгийн Богд суманд байгаа шиг үйлдвэрүүдийг ашиглалтад оруулах юм бол 8-аас 10 хүний ажлын байртай, хаягдаад байгаа хонины ноос эцсийн бүтээгдэхүүн болох эсгий туурга, дээвэр, өрх, гудас гээд бүх төрлийн эсгий бүтээгдэхүүнийг хийх боломжтой үйлдвэр Баянхонгор аймгийн Богд суманд хөл дээрээ босох гэж ядаж байна.

Тэгж байхад манай Хөдөө аж ахуйн сайд яг энэ хөдөө аж ахуй дээр хаягдаад байгаа малын гаралтай бүтээгдэхүүнээ эцсийн бүтээгдэхүүн болгох чиглэлд бодлого гаргаж ажиллахгүй өөрийгөө магтаад гадаад, дотоодоор яваад байна.

Тэгээд энэ Хөдөө аж ахуйн сайд дээрээ анхаарлаа хандуулж ажиллахгүй юм бол. Н.Учрал Ерөнхий сайд аа, Н.Учрал сайд аа. Танай салбарын сайдтай холбоотой асуудлыг яриад байгаа юм. Танхимаас чинь хэн ч үүнийг анхааралтай сонсохгүй байна.

Баянхонгор аймгийн Богд сумд 10 хүнтэй ажлын байр бий болгох гээд нэг тэтгэврийн эмээ, өвөө хоёр байдаг тэтгэврийнхээ зээлээр тэр үйлдвэрийг засаад сууж байхад танай энэ Хөдөө аж ахуйн сайд чинь нэг суман дээрээ үйлдвэр оруулъя гэсэн зорилго байхгүй яваад байх юм.

Энэ рүүгээ анхаарч ажиллахгүй бол энэ Засгийн газар чинь муу ажиллаж байна гэдэг дүгнэлтэд нийгэм рүү хүрэхэд хүрнэ шүү дээ. Тэгээд энэ рүүгээ анхаарч ажилла л даа, та нар.

С.Бямбацогт: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух ёстой. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуултаа асуух ёстой. Сайд хамаагүй. Санаачилсан гишүүн, хууль санаачилсан тэнд байж байгаа.

Сайд Баян-Өлгий аймаг, Ховд аймагт шүлхий гарсантай холбоотой томилолтоор явж байгаа.

Гэхдээ энэ хуулийг Засгийн газар оруулж ирсэн бол сайд байх үүрэгтэй. Гишүүн санаачилсан учраас сайд байх үүрэггүй.

Дэгийнхээ хуулийг сайн уншмаар байна. Одоо байгаа дэгийн хууль дээр яаралтай горимоор хэлэлцэх бол танилцуулахгүй санал хураадаг дэгтэй байгаа. Үүнийг өөрчилж байгаа дэг дээр танилцуулж байж, гишүүдийг мэдээллээр хангаж байж хураадаг болох гэж байгаа.

Тийм болохоор хуулиа л биелүүлж ажиллаж байгаа шүү. Хуулиа сайн уншиж, судлах хэрэгтэй байна шүү гишүүд ээ.

Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя.

Д.Рэгдэл: Энэ их чухал хууль явж байгаад баяртай байгаа. Хөдөө аж ахуйн салбарын ач холбогдол сүүлийн жилүүдэд улам их тодорхой болоод байгаа.

Яах аргагүй эрх зүйн зохицуулалт шаардсан, санаачилсан хүн ажлын хэсэгт талархаж байна.

Тэгээд эцсийн хэлэлцүүлэг болж байгаатай холбогдуулаад хоёр асуулт байгаа юм.

Нэгдүгээр асуудал нь, хуулийн 3, 4 зүйл ажлын хэсгийн саналаар хасагдаж байгаа юм шиг байгаа юм. Түүнээс гадна 4 зүйл дээр үндсэндээ 80 орчим хувийн өөрчлөлт ороод байгаа юм. 4 зүйл дээр.

Тэгэхээр хуулийг санаачилсан гишүүдийн гаргасан хуулийн үзэл баримтлалтай энэ аль хэр нийцэж байна вэ? Энэ тал дээр тодорхой хариулт өгнө үү? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт нь, энэ нэр томъёоны зүйл дээр их хүчтэй өөрчилсөн байх юм. Энэ нь хуучин анхны санаачилсан хуулийнхаа үзэл баримтлал, нэр томъёо нь их өөрчлөгдөхөөр ер нь аль хэр нөлөөлж байна вэ? Энэ тал дээр нэг санал хэлж өгнө үү гэж.

Гуравдугаарт нь, хуулийн төсөлд нэг заалт байгаа юм. 21 аймагт судалж шинжилгээний лаборатори байгуулах асуудал байгаа.

Одоо хэдэн аймаг нь лабораторитой юм бэ? Тэгээд энэ лабораториудад мэргэжлийн мэргэжлийн судлаач шаардлагатай. Хичнээн хүн шаардагдах юм бэ? Энд Мэргэжлийн лаборатори ажиллахын тулд судалгааны багаж, тоног төхөөрөмж гээд нэлээн зүйл шаардана.

Тэгэхээр энэ тоног төхөөрөмж ер нь хэдэн төгрөгийн тоног төхөөрөмж орж ирэх. Өөрөөр хэлбэл хэр хэмжээний хөрөнгө оруулалт шаардах юм бэ? Энэ дээр нэлээн юм орох байх. Энэ талаар хариулаад өгөөч.

Үүнийг дан ганц төсвийн хөрөнгөөр явуулах боломж байна уу, үгүй юу? Боломж гарвал нэлээн урт хугацаанд сунжирсан ажил болох болов уу гэж бодоод байгаа юм. Төр, хувийн хэвшлийн тэн түншлэлийн хүрээнд лабораторийн тоног төхөөрөмж, лаборатори байгуулах асуудлыг зохицуулж болох уу гэсэн гурван асуулт байна.

С.Бямбацогт: Их Хурлын гишүүд чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын тухай хуулиа уншаад судлаад мэддэг болмоор байгаа юм.

Улсын Их Хурлын тухай хууль дээр хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг хийгдэж байх үед хууль санаачлагчаас асуулт асууж, үг хэлдэг. Хэлэлцэх эсэх нь шийдэгдээд ажлын хэсэг байгуулаад хэлэлцүүлэг бэлтгээд эхэлсэн бол хэлэлцүүлгийн үе шатад ажлын хэсгийн ахлагчаас, ажлын хэсгийн гишүүдээс, Байнгын хорооноос асуулт асууж Байнгын хороо, ажлын хэсэг хариулах үүрэгтэй.

Тэгж байхад одоо энэ чинь анхны хэлэлцүүлэг явж байгаа шүү дээ. Одоо эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Эцсийн хэлэлцүүлэгтэй холбоотойгоор ажлын хэсгийн ахлагч, Байнгын хорооны дарга хоёр л хариулах үүрэгтэй.

Ажлын хэсгийн ахлагчаас, Байнгын хорооноос л асуулт асуух дэгтэй.

Тэгж байхад сайдаас асууна гээд сайд ажлын хэсгийн гишүүн биш. Сайдад хамаагүй асуудал.

Хууль санаачлагчаас хэлэлцэх эсэхийн үед л асуух ёстой байтал эцсийн хэлэлцүүлэг явж байхад хууль санаачлагч асуух байдлаар яваад байна.

Ажлын хэсгийн ахлагч байхгүй байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн хариулах ёстой. Ажлын хэсгийн ахлагч байхгүй учраас Байнгын хорооны дарга Б.Бейсен дарга хариулна.

Б.Бейсен: Манай М.Мандхай гишүүн хариулна. Ажлын хэсэг дээр. Дараа нь Хөдөө аж ахуйн Ц.Болорчулуун дарга хоёр хариулна.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга чинь асуултад хариулах л үүрэгтэй шүү дээ. Зүгээр хуралдаан даргалах гэдгээс гадна Байнгын хороогоор хэлэлцэж байгаа бүх асуудлуудаа мэдээд хариулах. Хууль санаачлагч хариулах дэг байхгүй. Дэгийнхээ хууль барьцгаая хэдүүлээ.

Одоо дэд ажлын хэсэг Ц.Болорчулуун дарга хариулъя. Дэд ажлын хэсэг. Ажлын хэсгийн гишүүдээс Д.Жаргалсайхан гишүүн байх ёстой. С.Замира гишүүн, С.Лүндэг гишүүн, Н.Наранбаатар гишүүн, Р.Сэддорж гишүүн.

Сая Н.Наранбаатар гишүүн танилцуулга уншаад гараад явчихаж байна. Дэд ажлын хэсэг. Ажлын хэсэг 4.

Ц.Болорчулуун: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун.

Д.Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

Хөдөө аж ахуйн тухай хуулийг М.Мандхай гишүүн санаачилж, ажлын хэсэг ажиллаад явж байгаа.

Ер нь хууль санаачлагчаас гарсан батлагдсан үзэл баримтлалын хүрээнд хууль бүрэн энэ хүрээндээ багтаж бичигдэж хэлэлцүүлэг болж явж дууссан. Найруулгын чанартай хэд хэдэн өөрчлөлтүүдийг хийснээс биш үндсэн үзэл баримтлалаас хазайсан зүйл байхгүй гэдгийг хэлье.

Ер нь хүнсний аюулгүй байдал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг дотоод болон гадаадын зах зээлд гаргахад лабораторийн асуудлууд хамгийн чухал.

Бид хөрөнгө мөнгөтэй холбоотойгоор бүсчилсэн байдлаар ерөнхийдөө энэ лабораториудыг хүчин чадлыг нь нэмэгдүүлье гээд –

- баруун бүсдээ Ховд аймаг,
- зүүн талд Хэнтий аймаг,
- говийн бүсэд Дундговь аймаг,
- хойд талдаа Архангай аймаг –

гэсэн бүсчилсэн 4 лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлье, сайжруулъя гэдэг байдлаар холбогдох салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдээс хөрөнгийг нь гаргахаар ажиллаж байгаа.

Ер нь цаашлаад 21 аймагт лабораториудын хүчин чадлыг бэхжүүлэх зайлшгүй шаардлага байгаа. Ингэж байж бид малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын асуудлыг харих хамгийн чухал асуудлыг шийдэх боломжтой.

Хөрөнгө оруулалтаар асуудлыг шийдэх ёстой. Улсын төсөв дээр хөрөнгө оруулалт дээр энэ чиглэлийн хөрөнгө оруулалт сүүлийн жилүүдэд тусгагдахгүй байгаа.

Салбарын сайд салбарт хэрэгжиж байгаа Азийн хөгжлийн банкны 2 ч төсөлтэй сүүлийн үед маш өргөн хэлэлцүүлэг, уулзалтуудыг хийж тодорхой үр ашиггүй зардлуудыг танаж лабораторийн хүчин чадлыг бэхжүүлбэ гэдэг байдлаар тодорхой ажлуудыг эхлүүлээд байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

С.Бямбацогт: Д.Рэгдэл гишүүн тодруулж асууя.

Д.Рэгдэл: Мэдээж хэрэг хууль санаачлагчдын гаргасан үзэл баримтлал хазайгаагүй юм байна гэж ойлголоо.

Тэгэхээр бүлэг бүлгээр нь хасаад хаяхаар чинь юм үүсэлдэг л дээ.

Тэр яах вэ гэж бодъё. Би энэ 21 аймагт лабораторид –

- хэчнээн мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй юм бэ?
- хэчнээн хөрөнгө оруулалт хэрэгтэй юм бэ?

гээд тодорхой юм асуугаад байна.

Түүнээс лабораторийн ач холбогдол, хүчин чадал нэмэх асуудлыг би бага сага ойлгоно.

Тооцоо юу байна вэ? Тооцоо байвал нэг хэлж өгөөч. Байхгүй бол тооцоо гаргаагүй байгаа гээд хэлсэн ч болно. Ямар ч байсан протоколд үүнийг тэмдэглээд дараа нь төсөв, төлөвлөгөө ярихад чинь хэрэг болж мэднэ шүү дээ.

С.Бямбацогт: Хариулъя. Ажлын хэсэг 4 дүгээр микрофон.

Ц.Болорчулуун: Д.Рэгдэл гишүүний асуултад нэмэлт хариулт өгье.

Бүсийн лабораториудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр байгуулахад барилга байгууламжтайгаа 5-аас 7 тэрбум төгрөгийн асуудал байх юм бол иж бүрнээр нь шийдэх боломжтой гэсэн тооцооллыг бид гаргасан байгаа.

Нэг лабораторид лабораторид ажиллах хүн хүчний бололцоо гэх юм бол 12-оос 15 хүнтэй байж байж энэ цаашаа бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллана гэж тооцоолж байгаа.

21 аймгаараа тооцоод үзэх юм бол нэлээд их хэмжээний хөрөнгө гарахаар байгаа гэдгийг танд хэлье.

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлангийн урилгаар Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

40 жилийнхээ ойг тэмдэглэж байгаа Та бүхэндээ Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Ц.Туваан гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/
Ж.Чинбүрэн гишүүн асуултаа асууя. Алга байна. /алх цохив/

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Хүнс, хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

М.Ганхүлэг гишүүн үг хэлье. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн. Индрийн 1 дүгээр микрофон.

М.Ганхүлэг: Хөдөө аж ахуйн салбарын суурь хуулийг жилийн өмнө өргөн барьсан гишүүдийн нэг байгаа.

Ингээд үндсэндээ жил дамнаж энэхүү хуулийг хэлэлцэж байна. Ямар ч байсан сүүлийн жилүүдэд үндсэндээ Хөдөө аж ахуйн салбарын хууль тогтоомжуудыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, энэ чиглэлийн бодлого, үйл ажиллагааг нэлээн цэгцтэй байлгах суурь хууль зайлшгүй шаардлагатай байна гэдэг энэ үндэслэлээр энэхүү хуулийн төслийг гишүүд боловсруулж өргөн барьсан.

Энэ салбарт хэрэгжиж байгаа 20 гаруй хуулийг зохицуулах давуу тал энэ хуулиар бий болж байгаа.

Дээрээс нь уур амьсгалын өөрчлөлтүүд сүүлийн жилүүдэд мал аж ахуйн салбар, газар тариалангийн салбарын эрсдэлт нөхцөл байдал нэлээн нэмэгдсэн. Үүнтэй холбогдолтойгоор тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих чиглэлийн гол заалтууд энэ дээр орсон.

Цаашдаа үзэл баримтлалын хувьд хамтарч нэгдвэл илүү дэмжлэгүүдийг авдаг байх тодорхой зохицуулалтуудыг энд оруулсан байгаа.

Мөн дээрээс нь тооноос илүү чанарт шилжихийг дэмжсэн агуулгуудыг оруулсан. Салбарын хүний нөөц, сургалт хөгжил, түүнтэй холбогдолтой зохицуулалтуудыг энэ хуульд оруулснаараа чухал онцлогтой.

Үндсэндээ суурь хууль учраас яг тодорхой асуудлууд гэхээс илүүтэй салбарын зохицуулалтуудыг тусгасан гэдгээр энэ хуулийн онцлог байгаа юм.

Сая Д.Рэгдэл гишүүн олж харсан байна. Хуулийн төсөл өргөн барьсан нөхцөл байдлаасаа нэлээдгүй өөрчлөлтүүдийг ажлын хэсэг дээр орсон. Ийм учраас өргөн барьсан гишүүдийн хувьд цаашдаа хэрэгжүүлэхдээ анхаарал хандуулах ёстой гэдэг энэ агуулгаар би үгээ хэлье гэж бодсон юм.

Өртгийн сүлжээг илүү гол хуулийн үндсэндээ гол суурь болгож оруулж ирсэн. Ингэснээрээ зөвхөн үйлдвэрлэлийн асуудал биш –

- дизайн,
- маркетинг,
- логистикийн асуудал,
- мөшгих систем,
- хүйтэн систем –

гээд төр засгаас анхаарч чадахгүй байгаа асуудлуудыг бүгдийг нь цогцоор нь харахыг зорьсон ийм үндсэн агуулга үйлдвэрлэлийн процессоор хэмжих агуулга руугаа шилжсэн өөрчлөлтүүд ажлын хэсэг дээр гарч ирсэн.

Тэгэхээр цаашдаа хууль хэрэгжүүлэхдээ салбарын уялдаа холбоонд оролцож байгаа бүх талуудын уялдаа холбоог хангах чиглэл рүү нь хандуулсан, хуулийн анх өргөн барьсан үзэл санааг авч хэрэгжүүлж ажиллах нь зөв юм гэдгийг би онцлон хэлмээр байна.

Үйлдвэрлэлийн сүлжээ нь юуг хэрхэн хийх вэ гэдэг агуулгыг ярьж байгаа бол өртгийн сүлжээний хувьд хаана, яаж өрсөлдөх, давуу талуудыг бий болгох гээд үйлдвэрлэлээс нэмэлт бид бүхний олж харж чадахгүй байгаа олон асуудлуудыг тусгаснаараа онцлогтой.

Тэгэхээр энэ хуулийн үндсэндээ үзэл санаан дээр тодорхой өөрчлөлт орохуйц ийм өөрчлөлтийг хийснийг онцлон тэмдэглэе.

Тэгэхээр эдгээр агуулгуудыг цаашдаа хэрэгжилт дээрээ хангаад явахыг протоколд тэмдэглүүлж үлдээе. Баярлалаа.

С.Бямбацогт: М.Ганхүлэг гишүүнд баярлалаа. Чухал санал хэллээ.

Ингээд үг хэлэх гишүүд дууслаа. /алх цохив/

Хөдөө аж ахуйн тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ. /алх цохив/

Дараагийн асуудал.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль нэмэлт, өөрчлөлт гаргах хуулийн төсөл хэлэлцэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жуковын Алдаржавхлан танилцуулах ёстой. Ж.Алдаржавхлан гишүүн. 1 минутын дараа орж ирсэн бол хойшлуулах гэж байлаа. Үүнийг хойшлууллаа. /алх цохив/

Их Хуралдаа хүндэтгэлтэй хандаж байх хэрэгтэй шүү.

Гишүүд баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Дараагийн асуудалдаа орёё.

**Арван найм.Баталсан хууль, тогтоолын
эцсийн найруулгыг сонсоно**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг холбогдох Байнгын хороо бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгад сонссонд тооцлоо. /алх цохив/

2.Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгад сонссонд тооцлоо. /алх цохив/

3.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгад сонссонд тооцлоо. /алх цохив/

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсэг, Тамгын газрын ажилтнууддаа баярлалаа. /алх цохив/

Одоо даргын дэргэдэх зөвлөлийн хуралтай.

Хуралдаан 5 цаг 06 минут үргэлжилж, 16 цаг 03 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД